# ГАРЧИГ


**УДИРТГАЛ ... 6**

**ШАЛГУУР 1. МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА ... 7**

1.1 Хөтөлбөрийн боловсруулалт ... 7

1.2 Хөтөлбөрийн зорилго ... 11

1.3 Хөтөлбөрийн агуулга ... 16

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд ... 24

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага ... 26

1.6 Шалгуур 1 SWOT, TOWS шинжилгээ ... 31

1.7 Сайжруулах арга зам ... 33

1.8 Үнэлгээ ... 33

1.9 Дүгнэлт ... 34

**ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ ... 35**

2.1 Элсэлт ... 35

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг ... 37

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй ... 40

2.4 Судалгааны ажил ... 44

2.5 Бүтээлч ажил ... 47

2.6 Шалгуур 2 SWOT, TOWS шинжилгээ ... 48

2.7 Сайжруулах арга зам ... 49

2.8 Үнэлгээ ... 50

2.9 Дүгнэлт ... 51

**ШАЛГУУР 3. МАГИСТРАНТЫН СУРАЛЦАХУЙН ҮНЭЛГЭЭ, ХӨГЖИЛ ... 51**

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт ... 51

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх ... 56

3.3 Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ ... 56

3.4 Судалгааны санхүүжилт ... 59

3.5 Тэтгэлэг, тэтгэмж ... 60

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа ... 61

3.7 Магистрын ажлын хамгаалалт ... 64

3.8 Төгсөлтийн баримт бичиг ... 66

3.9 Шалгуур 3 SWOT, TOWS шинжилгээ ... 68

3.10 Сайжруулах арга зам ... 70

3.11 Үнэлгээ ... 70

3.12 Дүгнэлт ... 71

**ШАЛГУУР 4. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН ... 72**

4.1 Багшийн нөөц ... 72

4.2 Багшлахуйн үнэлгээ ... 74
4.3 Багшийн хөгжил ... 76
4.4 Судалгаа ба хөгжил ... 79
4.5 Шалгуур 4 SWOT, TOWS шинжилгээ ... 83
4.6 Сайжруулах арга зам ... 83
4.7 Үнэлгээ ... 84
4.8 Дүгнэлт ... 85
**ШАЛГУУР 5. НӨӨЦ БА САНХҮҮЖИЛТ ... 86**
5.1 Сургалт, судалгааны орчин ... 86
5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн ... 89
5.3 Төсөв, санхүүжилт ... 94
5.4 Шалгуур 5 SWOT, TOWS шинжилгээ ... 95
5.5 Сайжруулах арга зам ... 96
5.6 Үнэлгээ ... 96
5.7 Дүгнэлт ... 97
**ШАЛГУУР 6. УДИРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ... 98**
6.1 Засаглал ба удирдлага ... 98
6.2 Ажилтнууд ... 103
6.3 Удирдлага мэдээллийн систем ... 103
6.4 Мэдээллийн ил тод байдал ... 106
6.5 Шалгуур 6 SWOT, TOWS шинжилгээ ... 108
6.6 Сайжруулах арга зам ... 110
6.7 Үнэлгээ ... 110
6.8 Дүгнэлт ... 111
**ШАЛГУУР 7. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ ... 111**
7.1 Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт ... 111
7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл ... 115
7.3 Шалгуур 7 SWOT, TOWS шинжилгээ ... 118
7.4 Сайжруулах арга зам ... 119
7.5 Үнэлгээ ... 119
7.6 Дүгнэлт ... 120

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1 Агуулгын нийцэл........ 14
Хүснэгт 1.2 Оролцогч талуудын санал, зөвлөмж ........ 15
Хүснэгт 1.3 Мэргэжлийн хичээл ба хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн хоорондын уялдаа холбоо........ 19
Хүснэгт 1.4 Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний матриц........ 22
Хүснэгт 1.5 Хөтөлбөр дэх мэргэжлийн заавал судлах хичээлээр оюутны суралцах ачааллын шинжилгээ........ 27
Хүснэгт 1.6 Зөвлөлийн санал........ 28
Хүснэгт 1.7 Хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээний үр дүн ........ 28
Хүснэгт 1.8 Хөтөлбөрүүдийн бүтцийг харьцуулсан шинжилгээний үр дүн........ 29
Хүснэгт 1.9 Магистрантын зорилго, агуулгад хийсэн өөрийн үнэлгээ ........ 33
Хүснэгт 2.1 Элсэлт зохион байгуулах хугацаа........ 36
Хүснэгт 2.2 Суралцахуйн ачааллын зохицуулалтын бүтэц ........ 37
Хүснэгт 2.3 Магистрын сургалтын төлөвлөгөө ........ 38
Хүснэгт 2.4 "Биеийн тамирын боловсрол"-ын хөтөлбөрийн БШУ-ны сайдын А/147-р тушаалын дагуу шинэчилсэн төлөвлөгөөний харьцуулалт ........ 38
Хүснэгт 2.5 “Биеийн тамирын боловсрол” судалгааны магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц ........ 39
Хүснэгт 2.6 “Биеийн тамирын боловсрол” мэргэжлийн магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц ........ 39
Хүснэгт 2.7 Сургалтын арга зүйн сонголтын судалгааны үзүүлэлт ........ 42
Хүснэгт 2.8 Магистрын судалгааны ажлын явцыг хянах, зөвлөх ажлын хуваарь ........ 46
Хүснэгт 2.9 Магистрын ажил хамгаалсан тоо........ 46
Хүснэгт 2.10 ҮБТДС-ийн магистрантуудын сүүлийн 5 жилийн эрдэм шинжилгээний бүтээл ........ 47
Хүснэгт 2.11 Хөтөлбөрийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ........ 50
Хүснэгт 3.1 Хичээл тус бүрийн үнэлгээний арга, хэлбэр ........ 52
Хүснэгт 3.2 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд харилцах дансанд төвлөрсөн оюутны төлбөрийн орлого........ 59
Хүснэгт 3.3 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрийн сургалтад зарцуулсан тооцоо........ 60
Хүснэгт 3.4 Сургуулийн өөрийн санхүүжилтээр олгосон тэтгэлгийн хэмжээ /сүүлийн 5 жил/ ........ 61
Хүснэгт 3.5 Оюутны хөгжлийн зээлээр олгосон тэтгэлгийн хэмжээ /сүүлийн 5 жил/........ 61
Хүснэгт 3.6 Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжилд хийсэн өөрийн үнэлгээ........ 70
Хүснэгт 4.1 Багш нарын албан тушаалын ангилал ........ 73
Хүснэгт 4.2 Багшлах бүрэлдэхүүн ........ 73
Хүснэгт 4.3 Хөтөлбөрийн нэг багшид ноогдох магистрантын тооны харьцаа........ 74
Хүснэгт 4.4 Багшийн эрдмийн цол зэргээ ахиулахад дэмжих бодлогын төлөвлөлт ........ 76
Хүснэгт 4.5 Багшийн хөгжлийн төвийн төсөв........ 76
Хүснэгт 4.6 Судалгаа хийгдэн 2025-2026 оны хичээлийн жил хамтран ажиллах эрдэмтэн багш нар ажлын байрны төлөвлөлт ........ 77
Хүснэгт 4.7 Мэргэжил дээшлүүлсэн багш нарын тоо........ 77
Хүснэгт 4.8 ҮБТДС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн тоо........ 81
Хүснэгт 4.9 Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн оюутны тоо ........ 81
Хүснэгт 5.1 Анги танхим, спорт заал, лабораторийн жагсаалт ........ 86
Хүснэгт 5.2 Хөтөлбөрийн биеийн тамир, спортын хичээлийн хэрэгсэл материалын үндсэн үзүүлэлт........ 90
Хүснэгт 5.3 Сургалт, судалгааны зориулалттай лаборатори,туршилтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний судалгаа ........ 90
Хүснэгт 5.4 Сургалт, судалгаанд ашиглах компьютер, программ хангамжийн судалгаа.... 92
Хүснэгт 5.5 Сургалт судалгаанд ашиглах ном, сурах бичиг, бусад цахим эх үүсвэрийн судалгаа........ 92
Хүснэгт 5.6 Биеийн тамир, спортын чиглэлийн номын судалгаа ........ 93
Хүснэгт 5.7 Сургалт судалгаанд ашиглах цахим өгүүллийн судалгаа........ 93

Хүснэгт 5.8 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд харилцах дансанд төвлөрсөн оюутны төлбөрийн орлого ........ 94
Хүснэгт 5.9 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрийн сургалтад зарцуулсан тооцоо ........ 94
Хүснэгт 5.10 “Нөөц ба санхүүжилт”ийн өөрийн үнэлгээ ........ 96
Хүснэгт 6.1 ҮБТДС-н хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөр ........ 99
Хүснэгт 6.2 Хөтөлбөрийн хорооны бүтэц ........ 100
Хүснэгт 6.3 Удирдлага мэдээллийн системд хийсэн өөрийн үнэлгээ ........ 110
Хүснэгт 7.1 Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний матриц ........ 113

## Зургийн жагсаалт

Зураг 1.1 ҮБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл ........ 9
Зураг 1.2 Хөтөлбөрийн талаар санал асуулгын дүн ........ 10
Зураг 1.3 Хөтөлбөрийн зорилго, агуулгыг тодорхойлсон байдал ........ 12
Зураг 1.4 Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх менежментийн цикл ........ 19
Зураг 1.5 Магистрын хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо ........ 21
Зураг 1.6 Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO), хичээлүүдийн суралцахуйн үр дүнгийн (CLO) хамаарал ........ 26
Зураг 3.1 Багшийн дүнгийн задаргаа оруулах хэсэг ........ 54
Зураг 3.2 Суралцагчийн мэдлэг, чадварыг ил тод, бодитой үнэлдэг эсэхэд өгсөн оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ ........ 55
Зураг 3.3 Оюутан системээс хичээлийн дүн харагдах хэсэг ........ 55
Зураг 3.4 ҮБТДС-ийн захирлын магистрын зэрэг хамгаалуулах комиссын хурлын тогтоол ........ 65
Зураг 3.5 ҮБТДС-ийн захирлын тушаал ........ 65
Зураг 3.6 “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн тоо ........ 67
Зураг 3.7 “Биеийн тамирын боловсрол” магистрын дипломын нүүр, хавсралт ........ 68
Зураг 4.1 Хүний нөөцийн стратегийн зорилтууд ........ 77
Зураг 4.2 “Хиймэл оюун ухаан”-ыг сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх сургалт ........ 78
Зураг 4.3 ҮБТДС-тай хамтарч эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд .. 79
Зураг 5.1 Сургуулийн шинэ барилгын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын дүн ........ 86
Зураг 5.2 Анги танхимд өгсөн оюутны үнэлгээ ........ 88
Зураг 5.3 Спорт заалнуудад өгсөн оюутны үнэлгээ ........ 88
Зураг 5.4 Сургуулийн гадаад орчинд өгсөн оюутны үнэлгээ ........ 88
Зураг 5.5 Материаллаг нөөцийн зардал ........ 89
Зураг 5.6 Магистрын хөтөлбөрийн орлого зардал /2019-2024/ ........ 95
Зураг 6.1 ҮБТДС-ийн хөтөлбөрийн хорооны бүтэц ........ 98
Зураг 6.2 Хөтөлбөрийн шинэчлэл хийгдсэн байдал ........ 100
Зураг 6.3 Хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хянах, сайжруулах үйл явцын мөчлөг ........ 101
Зураг 6.4 Программ хангамжийн үндсэн модулиуд ........ 104
Зураг 6.5 Сургалтын удирдлагын систем ........ 105
Зураг 6.6 Оюутны вебийн харагдах байдал ........ 107
Зураг 6.7 Хэвлэмэл хуудас ........ 108
Зураг 7.1 Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтад оролцох талуудын схем ... 115
Зураг 7.2 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа ........ 117
Зураг 7.3 Ажил олгогчдоос өгсөн төгсөгчдийн үнэлгээ ........ 118

# УДИРТГАЛ

## ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА:

**Хөтөлбөрийн нэр индекс:** Биеийн тамирын боловсрол E011438

**Сургалт явуулах хэлбэр**: өдөр/эчнээ

**Хөтөлбөрийг хариуцах, сургууль, салбарын нэр:** Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль Онол, арга зүйн тэнхим

**Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх хугацаа:** Намар, Хавар

**Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21-р хороо архивчдын гудамж, Үндэсний Биеийн Тамирын Дээд сургуулийн шинэ ордон, 301 тоот

**Сургалт явуулж ирсэн түүхэн замнал, туршлага:**

Үндэсний биеийн тамирын дээд сургууль нь анх 1991 онд байгуулагдаж 2004, 2009, 2019 онуудад 3 удаа байгууллагаа магадлан итгэмжлүүлсэн, 2024 онд 4 дэх удаагаа магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ өгч, тайланг хүргүүлсэн байна. Манай сургууль биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч мэргэжлээр бакалаврын болон магистрын сургалт явуулж байгаа бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар 4000 гаруй мэргэжилтэн, 360 гаруй магистр төгсгөөд байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагааны үндсэн нэгж нь тэнхимүүд бөгөөд сургалт, судалгаа, дасгалжуулалт, биеийн тамирын арга зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын анхдагч нэгж нь профессорын баг, сургалтын лаборатори, мэргэжлийн баг, шавь сургалтын тусгай тоног төхөөрөмж бүхий заал, танхим, кабинетууд юм.

Үндэсний Биеийн Тамирын Дээд сургуулийн дүрэмд зааснаар тус сургууль нь "Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авсан хувийн өмчийн, ашгийн бус үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд мөн" тул "Биеийн тамирын боловсрол" магистрын сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэхээр өргөн барьж байна.

Хөтөлбөрийн болон сургалтын албаны мэргэжилтнүүд, хөтөлбөрийн хорооны гишүүд БМИҮЗ-өөс зохион байгуулсан цуврал сургалтад хамрагдсанаар тус сургуулийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлуудыг эхлүүлж, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын дагуу "Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж, тайлангаа боловсруулах үйл ажиллагаа эхлүүлсэн юм.

## ШАЛГУУР 1. МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

### 1.1 Хөтөлбөрийн боловсруулалт

*Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт, судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.*

**Хөтөлбөр боловсруулах үндэслэл:**

Хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхдээ дараах үндэсний хэмжээний бодлого баримт бичгүүдийг харгалзан нийцүүлэв.

- **Эрх зүйн үндэслэл**

Монгол Улсын Боловсролын тухай хууль, Магистрын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, Боловсролын болон шинжлэх ухааны сайдын холбогдох тушаал: "Багш боловсролын шинэчлэлийн бодлого", “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”, “Шинэ зууны багшийн загвар”,

- БШУ-ны сайдын 2014 оны 09 дүгээр сарын 12 өдрийн А/370 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын төлөвлөгөө шинэчлэх батлах тухай”,
- БСШУСпортын сайдын 2019 оны 08 сарын 01-ний “Хөтөлбөр батлах тухай”,
- Боловсролын хүрээлэнгийн захирлын 2019 оны 09-р сарын 06-ны өдрийн “Суралцахуйн удирдамж батлах тухай” тушаал,
- “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай”, БСШУСпортын сайдын 2022 оны 05 сарын 09 өдрийн А/160 тоот тушаал зэрэг баримт бичгүүдэд
- Нийтлэг шаардлагыг шинэчлэн батлах тухай”, БСШУСпортын сайдын 2024 оны 03 сарын 20 өдрийн А/147 тоот тушаал зэрэг баримт бичгүүдэд
- 2024.05.15-ны өдрийн "Магистрын хөтөлбөр шинэчлэх, зорилго, зорилт тодорхойлон хэрэгжүүлэх хурлын тэмдэглэл, "Хөтөлбөрийн зорилго зорилт батлах тухай" 2024.05.20-ны өдрийн захирлын 27 тоот тушаал

- **Үндэсний бодлого**

“Алсын хараа-2050” хөгжлийн бодлого, дээд боловсролын шинэчлэлийн хүрээний зорилтуудыг баримталсан. Мөн үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор боловсруулсан

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа“-Боловсрол. Зорилт. 2.1.-д “Хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
- Нэгдүгээр үе, шат зорилтын хүрээнд 2021- 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу 2.1.10-т “Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд төгсөгчдийнхөө мэргэжил

дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоог бий болгож, шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана." гэжээ.

- Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор 2008 онд баталсан "Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилтод суурилсан "Үндэсний хөгжлийн цогц бодлого" баримт бичгийн 4.4."Боловсролын хөгжлийн бодлого"-д: Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунлаг, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. Ур чадвар сайтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, дээд боловсрол олгох тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх бодлого баримтална.", "Олон улсын жишигт нийцсэн боловсролын тогтолцоонд 2021 он гэхэд шилжинэ" хэмээн заажээ. Иймээс шинэчлэлд дасан зохицох чадвартай, өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг, ажлын байрны шаардлага хангах мэргэжилтнийг хөгжүүлэх шаардлага дээд боловсролын байгууллагын өмнө тулгарч байна. Үүнээс гадна "Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийг боловсруулахдаа НҮБ-ийн ЮНЕСКО-гийн зөвлөсөн суралцахуйн бүтэлчихсэн хүрээг тодорхойлох үндсэн ай (2013), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2015), XXI зууны багшийн загвар (2014) зэрэг баримт бичгийг ашигласан болно. Түүнчлэн 2018 онд баталсан "Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилго нь Монгол улсад суралцахуйн үр дүнд суурилсан боловсролын стандарт, арга зүйг нэвтрүүлэх замаар дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төлөвшүүлнэ хэмээсэн байна.

- **Оролцогч талуудын хэрэгцээ**

Хөтөлбөрийг боловсруулах явцад оюутнууд, ажил олгогчид, салбарын байгууллагууд болон сургалтын багш нараас санал авсан. Судалгаа шинжилгээний дүгнэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаанд үндэслэн хөтөлбөрт өөрчлөлт оруулсан.

- **Чанарын хяналт**

Хөтөлбөрийн чанарыг хангах зорилгоор сургалтын явцад дотоод болон гадаад хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлдэг. Хөтөлбөрийн агуулга, хичээлийн үр дүнг жил бүр хянаж, сургалтын орчны чанарыг үнэлэх механизмуудыг ашигладаг.

- **Суралцагч төвтэй хандлага**

Биеийн тамирын боловсролын онцлогийг харгалзан, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн, онол, практик хослуулсан сургалтын арга зүйг хөгжүүлсэн.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэн ҮБТДС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр магистрын сургалтын хөтөлбөрийг сайжруулан ажиллаж байна. "Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийг олон жилийн турш амжилттай хэрэгжүүлж ирсэн туршлага нь тус мэргэжлээр магистрын түвшинд сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлж (Зураг 1.1) байна.




*Зураг 1.1 ҮБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл*

***Хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж оролцогч талуудыг хамруулсан байдал***

ҮБТДС-ийн “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөр нь “Судлаач” бэлтгэх үйл ажиллагааны цөм болсон үндсэн онол, сургаал, арга зүйг хэрэглээ болгон судалгааны бааз, нөөцөд тулгуурлан агуулгаа сайжруулсан болно. Мөн нийгмийн хөгжил, олон нийтийн оролцоо, эрэлт хэрэгцээ, бодит амьдралын шаардлага, мэргэжлийн байгууллагуудын харилцаа, практик үйл ажиллагааны үр дүнд суурилсан дүн шинжилгээг тусган ажиллаж байгаа юм.

ҮБТДС-ийн магистрын хөтөлбөрөөр 2018-2024 оны байдлаар авч үзвэл Монгол улсын 54, БНХАУ-ын ӨМӨЗО-ны 33, нийт 87 магистрант суралцан төгссөн байна. БНХАУ-ын Боловсролын яамны чиглэл ёсоор тус улсын иргэд “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрөөр суралцаж төгссөнөөр магистрын боловсролын диплом нь хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд цаашид мэргэжлээрээ ажиллах бүрэн боломжтой байдаг ажээ. Тус хөтөлбөрийн дотоодын төгсөгчид нь биеийн тамир, спортын салбарын бүхий л байгууллагын бодлогын түвшинд төдийгүй хэрэгжүүлэгч мэргэжилтнээр ажилладаг. Тэдгээр оролцогч талуудын санал зөвлөмж нь бидний сургалтын төлөвлөгөөнд тусгалаа олж хэрэгжиж байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд ҮБТДС-ийн “Хөтөлбөрийн дэд ба салбар хороо”, ҮБТДС-ийн “Хөтөлбөрийн ерөнхий хороо”, ҮБТДС-ийн хөтөлбөрийн албанаас хяналт тавьж ажиллахын зэрэгцээ суралцагч, төгсөгч нараас санал асуулга авч, үнэлэлт өгч төгсөгч, мэргэжилтний гол онцлог болон давуу талыг тодорхойлж, тэдгээрт 2023 онд магистрын хөтөлбөрийг боловсронгуй болгосон юм. ҮБТДС-д хэрэгжиж байсан 2018 оны магистрын хөтөлбөрийн сургалтын агуулга нь оюутнуудад аль хэр хүртээмжтэй, сэтгэл ханамжтай байгааг судлах зорилгоор тус хөтөлбөрт суралцаж байсан 32 магистрантаас 10 асуулттай асуулгаар судалгаа авч дүгнэлт хийснийг (Зураг 1.2.)-д харуулав




*Зураг 1.2 Хөтөлбөрийн талаар санал асуулгын дүн*

Тус судалгаанаас харахад 2018 онд хэрэгжүүлэн мөрдөж байсан “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөр нь магистрантуудын хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа ч дахин шинэчлэн сайжруулж, улам боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна. Ялангуяа магистрын хөтөлбөрт байгаа давхардсан агуулгыг хянах, сонгох хичээлийн тоог нэмэх, багш нарын үнэлгээний аргыг нарийвчлан тодорхой болгох, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц мэдлэг, чадвар, хандлагыг олгож төлөвшүүлэх хэрэгтэй байгааг харуулсан. Ингээд тус судалгааны үр дүнд үндэслэн “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийг боловсронгуй болгох ажлыг эхлүүлж, 2025 онд шинэчилсэн хөтөлбөрөө батлуулан, хэрэгжүүлж байна.

Мөн дипломын шүүмжлэгч болон диплом хамгаалалтын зөвлөлд тухайн салбарын мэдлэг туршлагатай гадны нэг ба түүнээс дээш мэргэжилтнийг оролцуулна гэж заажээ. Энэ нь УБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгатай нийцэж байна. “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрөөр төгсөгчийн давуу тал нь орчин үеийн хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухаан, техник технологийг дэвшилд суурилсан биеийн тамир, спорт хөгжиж байгаа өнөө үед мэргэжлийн шинжлэх ухааны онол, сургаал, үзэл баримтлал, судалгааны аргуудыг эзэмшиж онол, практикийн нэгдмэл чанарыг хослуулж байна.

***Хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбар***

Шинээр элсэн суралцаж буй магистрантыг хичээлээ оновчтой сонгон судлах, өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангах зорилгоор, “Биеийн тамирын судалгааны онол арга зүй”, “Боловсрол судлалын үндэс”, “Биеийн тамир спортын хэмжил зүй” зэрэг хичээлийг сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд шинээр тусгаж, хувь хүний хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. “Биеийн тамир, спортын сэтгэл судлалын үндэс” хичээлийг судалснаар багш, тамирчны сэтгэл зүй ба бусад шинжлэх ухааны мэдлэгийн харилцан хамаарлыг судлах төдийгүй биеийн тамирын багш өөрийгөө таньж мэдэх, хөгжүүлэх, байгууллага, хамт олныг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах мэдлэг эзэмших, аливаа асуудлыг оновчтой шийдвэрлэх зэрэг хандлага төлөвших юм.

“Биеийн тамирын боловсролын менежмент” хичээлээр олон нийт, байгууллагын ажилтан, алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, байгууллага, хамт олны бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийг хангах чадвартай, тусгай хэрэгцээт

түвшинд ажиллах хандлага, харилцааг эзэмших , ШУ-ы хөгжлийн нийгмийн үүрэг, ач холбогдол, макро, микро орчинд үзүүлэх нөлөөллийг таньж мэдэх юм.

Сургалтын төлөвлөгөөнөөс харахад БШУ-ны Сайдын 147 тоот тушаалын дагуу хичээлийн тоо, бүтцийн хувьд нэлээдгүй өөрчлөгдсөн. Эдгээр өөрчлөлтийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Мэргэжлийн суурь хичээл хуучин 10 багц цаг байсан бол шинэ төлөвлөгөөнд 12 багц цаг болж, эзлэх хувийн жин 4.2%-р нэмэгдсэн;
2. "Хуучин" хөтөлбөрт зөвхөн "Заавал судлах" хичээлтэй байсан бол шинэ хөтөлбөрт "Сонгон судлах" хичээл 2-р буюу 3 кредитээр нэмэгдсэн;
3. Мэргэших хичээл 12 багц цаг байсан бол шинэ шинэ төлөвлөгөөнд 11 багц цаг болж, эзлэх хувийн жин 5.6%-р хасагдсан;
4. Магистрын төгсөлтийн ажил 8 багц цаг байсан бол шинэ төлөвлөгөөнд 9 багц цаг болж, эзлэх хувийн жин 1.5%-р нэмэгдсэн;
5. 3 багц цаг ”Магистрын судалгааны ажлын арга зүй зохион байгуулалт”-ыг “Эрдэм шинжилгээ, судалгаа” нэртэй болгож 4 багц цаг болгож нэмэгдүүлэв;
6. “Биеийн тамирын боловсрол”-ын магистрын сургалтын төлөвлөгөө өмнө нь 30 багц цагтай байсан бол шинэ хөтөлбөр төлөвлөгөө нь 32 багц цагтай болж өөрчлөгдсөн.

Сургалтын хөтөлбөрийг сайжруулахдаа, сургуулийн хөтөлбөрийн хороо болон дэд хороо, Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэг. Тухайлбал, тус сургуулийн “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийг сүүлийн таван жилд 2 удаа сайжруулж, хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцэж, тогтсон журмын дагуу холбогдох чиглэлээр сайжруулж ҮБТДС-ийн хөтөлбөрийн хороо, Эрдмийн зөвлөлийн 2025 оны 04-р сарын 01-ны өдрийн хурлаар хэлэлцсэн шийдвэрийг үндэслэн Захирлын 2025 оны 04-р сарын 02-ны өдрийн 19 тоот тушаалаар баталгаажуулсан байна.

### 1.2 Хөтөлбөрийн зорилго

*Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудын татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.*

***Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилгод хийсэн судалгаа***

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогын зорилгоо хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг, чадвартай, зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, насан туршдаа суралцах чадвартай иргэн төлөвшүүлэх хэмээн тодорхойлох болсон. Үүнтэй холбоотойгоор дээд боловсролын олон улсын чиг хандлага нь хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ хүмүүнлэг, нээлттэй, уян хатан тогтолцоог хөгжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Сүүлийн жилүүдэд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг тусгайлан боловсруулж, түүнийг хөтөч болгон хөтөлбөр боловсруулдаг олон улсын хандлага

гарч байгаа бөгөөд ҮБТДС нь олон улсын жишигт нийцүүлэн хөтөлбөрөө шинэчлэн, хэрэгжүүлж байгаа юм.

ҮБТДС-н биеийн тамир, спортын боловсрол олгож байгаа хөтөлбөрүүдийн ерөнхий чиг хандлага, агуулгын баримжаа нь хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсийн тухай өргөн мэдлэгтэй, олон улсын түвшинд өрсөлдөх мэргэжлийн өндөр ур чадвартай, Монголын биеийн тамир, спортын салбарыг дэлхийн түвшинд хөгжүүлэхэд тэргүүлэх болон уламжлал шинэчлэлийг хослуулан ажиллах арга туршлагыг эзэмшсэн өндөр боловсролтой мэргэжилтний эзэмшвэл зохих мэдлэг, ёс зүй, хандлагаас бүрэн суралцаж, нийгэм, хамт олон, ажлын байрны тухайн шаардлагад нийцэн ажиллаж, амьдарч чадах бакалавр болон ахисан түвшний боловсролтой мэргэжилтэн, судлаач иргэнийг төлөвшүүлэхэд чиглэнэ.




*Зураг 1.3 Хөтөлбөрийн зорилго, агуулгыг тодорхойлсон байдал*

**Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургуулийн (ҮБТДС) магистрын хөтөлбөрийн зорилго:**

1. **Мэргэжилтэн бэлтгэх:** Монгол Улсын биеийн тамир, спортын салбарт шаардлагатай өндөр мэргэжлийн багш, дасгалжуулагч, судлаач, менежерүүдийг бэлтгэх.
2. **Судалгаа, шинжилгээ хөгжүүлэх:** Монгол Улсын үндэсний болон олон улсын спортын судалгааны арга зүй, шинжлэх ухааны ололтуудыг нэвтрүүлэх, шинэлэг судалгааны ажлуудыг хөгжүүлэх.
3. **Эрүүл амьдралын хэв маяг дэмжих:** Спорт, биеийн тамирын боловсролоор дамжуулан эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, биеийн тамирын ач холбогдлыг олон нийтэд түгээх.
4. **Байгууллагын удирдлага:** Спортын салбарын удирдлага, менежмент, төлөвлөлтийн мэдлэгтэй, шинэчлэл, инновацын санаачилга бүхий удирдагчид бэлтгэх.
5. **Үндэсний болон олон улсын онцлогийг тусгах:** Монголын спортын уламжлал, соёл, онцлогийг хүндэтгэн хадгалах, олон улсын спортын хөгжлийн

чиг хандлагад нийцсэн мэргэжлийн сургалт, судалгаа явуулах.

ҮБТДС-ийн "Биеийн тамирын боловсролын магистрын хөтөлбөрийн зорилго шинэчлэн тавихдаа дараах үе шатаар хийгдэв.

- **Зорилгын шаардлагыг тодорхойлох:**
  - Яагаад энэ зорилгыг тавих хэрэгтэй байгааг тогтоох. Энэ зорилго нь магистрантад хэрэгцээтэй мэдлэг, ур чадварыг олгох зорилгоор тавигддаг бөгөөд сургууль болон нийгэмд хэрэгтэй мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чиглэнэ.
  - Нөхцөл байдал, тулгамдсан асуудлуудыг нарийвчлан шинжлэх. Биеийн тамирын боловсролын магистрын хөтөлбөрийн зорилго тогтооход тулгарч болох нөхцөл байдал, тулгамдсан асуудлууд болон шаардлагыг илүү дэлгэрэнгүй тодорхойлох нь хөтөлбөрийн хэрэгжилт, чиглэлүүдийг зөв тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг. Энд зарим гол асуудлууд болон шаардлагуудыг тодорхойлсон болно.
- **Холбогдох оролцогч талуудыг тодорхойлох:**

ҮБТДС-ийн магистрын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, тамирчид, багш, судлаачид, олон улсын түншүүд зэрэг олон оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэдний уялдаа холбоо, дэмжлэг нь хөтөлбөрийн зорилгыг бодит үр дүнд хүргэх гол хүчин зүйл юм.

- **Эхний үнэлгээ хийх:**

Биеийн тамирын боловсролын магистрын хөтөлбөрийн зорилго тогтооход эхний үнэлгээ хийх нь хөтөлбөрийн хэрэгжилт, хөгжлийн чиглэлүүдийг амжилттай тодорхойлоход чухал алхам юм. Энэ үнэлгээ нь хөтөлбөрийн амжилттай хэрэгжилтэд шаардагдах эх үүсвэрүүд, бэрхшээлийг үнэлэх, мөн хэрэгжүүлэхэд тулгарч болох саад бэрхшээлийг тодорхойлоход чиглэгддэг. ҮБТДС-н хамт олон сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол улсын биеийн тамир спорт, боловсролын салбарын олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, салбарын оролцогч талуудын тулгамдаж буй асуудал, эрэлт хэрэгцээг сонсож дүгнэн Биеийн тамирын боловсролын магистрын зэргийн сургалтын хөтөлбөртөө тусгасан болно.

**Хөтөлбөрийн зорилго нь дараах зорилтод чиглэгдэнэ:**

1. **Судалгааны ур чадвар хөгжүүлэх:** Сургалт, судалгаа хосолсон арга зүйд тулгуурлан, биеийн тамир, спортын салбарт шинэлэг судалгааны ажлуудыг хийж чадах мэргэжилтэн бэлтгэх.
2. **Мэргэжлийн ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх:** Үндэсний болон олон улсын стандартад нийцсэн, өндөр ур чадвар бүхий мэргэжилтнийг хөгжүүлэх.
3. **Багш, судлаачдын сүлжээ бүрдүүлэх:** Спорт, биеийн тамирын боловсролын салбарт багш, судлаачдын өргөн хүрээний хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэх.
4. **Олон улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх:** Дэлхийн боловсролын стандарт, орчин үеийн технологийг ашиглах чадвартай, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх мэргэжилтнийг бэлтгэх.
5. **Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих:** Биеийн тамир, спортын ач холбогдлыг таниулах, нийгмийн эрүүл мэндийн хөгжилд хувь нэмэр оруулах мэргэжилтнийг

сургах.

***Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал***

Хөтөлбөрийн зорилгыг сургуулийн эрхэм зорилго болон бусад эрх зүйн баримт бичиг, стандарттай нийцэж байгаа байдлыг Хүснэгт 1.1-т үзүүллээ.

Хүснэгт 1.1 Агуулгын нийцэл

| | |
|---|---|
| МУ-ын үндсэн хууль | Монгол орондоо хүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулна. |
| Боловсролын хууль | Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах амьдрах чадвартай болгон төлөвшүүлнэ. |
| Дээд боловсролын хууль | Бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг чадвар эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэнэ. |
| ҮБТДС-ийн эрхэм зорилго | ҮБТДС-ийн эрхэм зорилго нь дэлхийн спортын чиг хандлага, нийгмийн шинэ харилцааны үеийн боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөрвөх чадвартай мэргэжилтэн бакалаврыг болон ахисан түвшинд өндөр хүчин чадал бүхий материаллаг бааз суурьд түшиглэн бэлтгэхэд оршино. |
| Хөтөлбөрийн зорилго | Биеийн тамир, спортын болон спортын зохих зэрэгтэй, өөр мэргэжлийн магистрын биеийн тамир спортын боловсролтой иргэнд сургалт, эрдэм шинжилгээ, биеийн тамирын боловсрол, үндэсний болон дэлхийн спортын уламжлал, чиг хандлага, шинжлэх ухаан, инновацын хүрээнд мэргэжлийн гүнзгийрүүлсэн боловсрол эзэмшүүлэх, эрдэм шинжилгээний ажлын удирдагч, зөвлөхийн удирдлагаар судалгаа шинжилгээний ажлыг аливаа түвшинд хийж, судалж буй асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй хувилбар боловсруулж, оновчтой сонголт, дүгнэлт хийхэд шаардлагатай мэдлэг чадвар олгох, ёс суртахууныг төлөвшүүлэхэд оршино. |

Үүнээс харахад, “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн зорилго, зорилт нь ҮБТДС-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлстэй нягт уялдаж байна.

***Хөтөлбөрийн зорилго, төгсөгчдийн эзэмших мэдлэг, хандлагыг оролцогч талуудын саналыг тусган тодорхойлсон байдал***

ҮБТДС-н хамт олон сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол улсын биеийн тамир спорт, боловсролын салбарын олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, салбарын оролцогч талуудын тулгамдаж буй асуудал, эрэлт хэрэгцээг сонсож дүгнээд “Биеийн тамирын боловсрол” магистрын зэргийн сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо 2024.05.15-ны өдрийн "Магистрын хөтөлбөр шинэчлэх, зорилго, зорилт тодорхойлон хэрэгжүүлэх хурлын тэмдэглэлийг үндэслэж "Хөтөлбөрийн зорилго

зорилт батлах тухай" 2024.05.20-ны өдрийн захирлын 27 тоот тушаалаар батласан бөгөөд Хүснэгт 1.2-д тусгасан болно.

Хүснэгт 1.2 Оролцогч талуудын санал, зөвлөмж

| № | Оролцогч талууд | Санал | Зорилгод тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1 | БШУЯ | - Судлаач-багш байх<br>- Биеийн тамир, спортын онол, арга зүйн гүнзгий мэдлэгтэй байх | Судалгааны арга зүйг эзэмшүүлж, аливаа асуудлыг мэргэжлийн онолын түвшинд судлан шинжлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг тусгасан. |
| 2 | Биеийн тамир, спортын улсын хороо | - Спортын менежмент, дасгалжуулалтын онол, арга зүйд суралцсан байх<br>- Хүний нөөцийн судлагдахууныг эзэмшсэн байх | Багц хөтөлбөрийг сонгон судлах боломж олгож хөтөлбөрт тусгасан. |
| 3 | Нийслэл, аймгийн боловсролын газар | Бүх шатны боловсролын байгууллагын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх түвшинд ажиллах чадвартай мэргэжилтэн байх | Биеийн тамир, спортын менежмент, багшлахуйн ур чадварт чиглэсэн хөтөлбөрийг сонгуулж байна. |
| 4 | Мэргэжлийн холбоо, клуб | Судалгаа хийж, шинжлэн боловсруулах чадвартай мэргэжилтэн байх | Судалгааны онол, арга зүйн хөтөлбөрүүдийг тусгаж өгсөн. |
| 5 | БТС-ийн Эрдмийн зөвлөл | Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх, ахисан шатны сургалтыг чанартай хөгжүүлж, зохион байгуулах | “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажиллав. |
| 6 | Хөтөлбөрийн хороо | - Агуулгын давхардалгүйгээр хичээлийн хөтөлбөр боловсруулахад анхаарах<br>- Хичээл хоорондын уялдаа залгамж, хүрэх үр дүнг нарийвчлан гаргах | Хөтөлбөрийн хорооны санал, дүгнэлтийг хичээлийн хөтөлбөр, агуулгад тусгав |
| 7 | Тэнхим, багш нар | - Төгсөгчдийн санал, хүсэлтийг судлан тусгах<br>- Мэргэжлийн хичээлийн агуулгыг сайтар боловсруулах<br>- Багш бүр хичээлийн хөтөлбөрийг судалгаа, | Хичээлийн хөтөлбөр боловсруулах явцдаа хэд, хэдэн удаагийн хэлэлцүүлэг, хурлыг зохион байгуулж багш нараас гарсан санал дүгнэлтийг хөтөлбөртөө тусгав. |

| | | | |
|---|---|---|---|
| | | харьцуулалттай боловсруулах | |

Өнгөрсөн хугацаанд “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрийн зорилго, төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг дараах чиглэлээр тодорхойлсон байна. Тухайлбал: Эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухааны үндэстэй бичих, гадаад хэлээр мэргэжлийн мэдээллийг ашиглах, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх, судалгааны аргуудыг бүтээлчээр хэрэглэх, хүний эрүүл мэндийг дэмжих, бие махбодын үйл ажиллагааг нөхөн сэргээх зэрэг биеийн тамир, спортын олон талт асуудлыг судлаачийн байр сууринаас шинжлэн судлах, судлаачийн нэр хүнд, ёс зүйг баримтлах, оюуны өмчид хууль, эрх зүйн хүрээнд хүндэтгэлттэй хандах агуулгаар шинэчлэгдсэн байна.

**Дүгнэлт:** Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд судалгааны ажлын үр дүнг хөхиүлэн дэмжиж, практик дээр суурилсан сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахад анхаарч байна. ҮБТДС-ийн магистрын хөтөлбөрийн агуулга, сургалтын зохион байгуулалт, судалгааны чиглэлээрээ хэрэгждэг бөгөөд МУ-ын спортын салбарын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

### 1.3 Хөтөлбөрийн агуулга

*Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшний судалгааг хөгжүүлэхэд чиглэж, онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны хэлбэрийг зохистой тогтоож мөрддөг байна.*

***Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж баталгаажуулсан байдал***

Монгол Улсын БСШУ-ны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалд “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг шаардлага”-д нийцүүлэн ҮБТДС-н хуучин хөтөлбөр боловсрогдон хэрэгжиж байсан бөгөөд хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалтыг байнга хянан сайжруулдаг.

Нийтлэг шаардлагыг шинэчлэн батлах тухай” БШУ-ны сайдын 2024 оны 03 сарын 20 өдрийн А/147 тоот тушаал зэрэг баримт бичгүүдийн заалтын дагуу “Биеийн тамирын боловсрол” (E011438) “судалгааны” болон “мэргэжлийн” гэсэн хоёр хувилбартай магистрын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хичээлүүдийг шинэчлэн боловсруулж БШУЯ болон ҮБТДС-ийн эрх зүйн баримт бичгийн дагуу хэрэгжүүлж байна. Үүнд:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар тушаал.
- ҮБТДС-ийн захирлын 2024 оны 05-р сарын 01-ны өдрийн 26 тоот “Магистрын хөтөлбөрийн баг шинэчлэн байгуулах тухай” тушаал
- ҮБТДС-ийн захирлын 2024 оны 06-р сарын 11-ны өдрийн 32 тоот “Хөтөлбөрийн хорооны журмыг шинэчлэн батлах тухай” тушаал
- ҮБТДС-ийн хөгжлийн бодлого (2021-2030). ҮБТДС-ийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тоот тогтоолоор баталгаажуулсан “Үндэсний Биеийн Тамирын дээд сургуулийг 2021-2030 онд хөгжүүлэх хөгжлийн шинэ шатанд хөтлөх, нийгэмд үзүүлэх нөлөөллийг нь дээшлүүлэх стратеги төлөвлөгөөний бодлогын иж бүрэн баримт бичиг

- ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04-р сарын 01-ны өдрийн 18 тоот “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” тушаал
- ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04-р сарын 02-ны өдрийн 19 тоот тушаалын 2-р хавсралтаар шинэчлэн баталсан “Магистрын сургалтын журам”

**Сургалтын төлөвлөгөө:**

“Биеийн тамирын боловсрол”-ын магистрын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг 32 багц цагаас багагүй байхаар боловсруулав.

| ҮБТДС-ИЙН ЗАХИРЛЫН 2025 ОНЫ 04 САРЫН 02-НЫ ӨДРИЙН 19 ТООТ ТУШААЛААР БАТЛАВ | ҮБТДС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ 2025 ОНЫ 04 САРЫН 01-НЫ ӨДРИЙН ХУРЛААР ЗӨВШӨӨРӨВ |
|---|---|

**ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ МАГИСТРЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Мэргэжлийн индекс: **Е-011438**

Мэргэжлийн нэр: **Биеийн тамирын боловсрол**

Суралцах хугацаа: **1,5 жил**

Элсэгчийн боловсрол: **Бакалавр**

Сургалтын хэлбэр: **Өдөр**

| № | Хичээлийн нэр | Хичээлийн код | Хичээлийн хэлбэр | Багц цаг, кр |
|---|---|---|---|---|
| **А. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ** | | | | **12** |
| **Заавал судлах** | | | | **9** |
| 1 | Шинжлэх ухааны судалгааны арга зүй | N.SCM-700 | 2:2:0:0 (5) | 3 |
| 2 | Биеийн тамирын боловсролын менежмент | N.MPE-706 | 2:2:0:0 (5) | 3 |
| 3 | Боловсрол судлалын үндэс | N.PES-702 | 2:2:0:0 (5) | 3 |
| **Сонгон судлах** | | | | **3** |
| 4 | Боловсролын философи | N.EPH-705 | 2:2:0:0 (5) | 3 |
| 5 | Биеийн тамир спортын хэмжил зүй | N.SMT-709 | 2:2:0:0 (5) | 3 |
| **Б. МЭРГЭШИХ ХИЧЭЭЛ** | | | | **11** |
| 1 | Эрүүл мэндийн боловсрол | N.HED-704 | 2:2:0:0 (5) | 3 |
| 2 | Биеийн тамирын судалгааны онол, арга зүй | N.TMR-701 | 1:0:2:2 (5) | 3 |
| 3 | Биеийн тамир спортын сэтгэл судлалын үндэс | N.PPE-707 | 2:2:0:0 (5) | 3 |
| 4 | Биеийн тамирын боловсролын онол, арга зүй | N.TPE-708 | 2:0:0:0 (3) | 2 |
| **В. МАГИСТРЫН ТӨГСӨЛТИЙН АЖИЛ** | | | | ***9*** |
| 5 | Эрдэм шинжилгээ, судалгаа | N.RSC-710 | | 4 |
| 6 | Магистрын төгсөлтийн ажил | N.DMD-711 | | 5 |
| **Дүн** | | | | **32** |

**ҮБТДС-ИЙН ЗАХИРЛЫН 2025 ОНЫ 04 САРЫН 02-НЫ ӨДРИЙН 19 ТООТ ТУШААЛААР БАТЛАВ**

**ҮБТДС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ 2025 ОНЫ 04 САРЫН 01-НЫ ӨДРИЙН ХУРЛААР ЗӨВШӨӨРӨВ**

## ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН МАГИСТРЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжлийн индекс: **Е-011438**

Мэргэжлийн нэр: **Биеийн тамирын боловсрол**

Суралцах хугацаа: **1,5 жил**

Элсэгчийн боловсрол: **Бакалавр**

Сургалтын хэлбэр: **Өдөр**

| **№** | **Хичээлийн нэр** | **Хичээлийн код** | **Хичээлийн хэлбэр** | **Багц цаг** |
|---|---|---|---|---|
| **А. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ** | | | | **12 кр** |
| **Заавал судлах** | | | | **9 кр** |
| 1. | Шинжлэх ухааны судалгааны арга зүй | N.SCM-700 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 2. | Биеийн тамирын боловсролын менежмент | N.MPE-706 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 3. | Боловсрол судлалын үндэс | N.PES-702 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| **Сонгон судлах** | | | | **3 кр** |
| 4 | Биеийн тамир спортын хэмжил зүй | N.SMT-709 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 5 | Спортын анагаах ухаан | N.SMD-700 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| **Б. МЭРГЭШИХ ХИЧЭЭЛ** | | | | **15 кр** |
| 1 | Эрүүл мэндийн боловсрол | N.HED-704 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 2 | Биеийн тамирын судалгааны онол, арга зүй | N.TMR-701 | 1:2:0:2 (5) | 3 кр |
| 3 | Биеийн тамир спортын сэтгэл судлалын үндэс | N.PPE-707 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 4 | Биеийн тамирын боловсролын онол, арга зүй | N.TPE-708 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| 5 | Боловсролын философи | N.EPH-705 | 2:2:0:0 (5) | 3 кр |
| **В. МЭРГЭЖЛИЙН ДАДЛАГА (сонголтоор)** | | | | **5 кр** |
| 1 | Сонгосон спортын төрлөөр дадлагын хичээл | N.SAB-700 | 0:0:0:10 (5) | 5 кр |
| **Дүн** | | | | **32 кр** |




*Зураг 1.4 Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх менежментийн цикл*

### Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график, хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийн уялдаа холбоо

"Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд буй хичээлүүдээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй (PLO) хэрхэн уялдаж байгааг тодруулах судалгаанд мэргэжлийн суурийн 5 хичээл, мэргэших 5 хичээлийн болон судалгааны сонгох ажлыг хамруулан авч үзсэн байдлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.3 Мэргэжлийн хичээл ба хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн хоорондын уялдаа холбоо

| № | Хичээлийн нэр | Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт (PLO) | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | PLO 1.1 | PLO 1.2 | PLO 1.3 | PLO 1.4 | PLO 2.1 | PLO 2.2 | PLO 2.3 | PLO 2.4 | PLO 2.5 | PLO 2.6 | PLO 2.7 | PLO 3.1 | PLO 3.2 | PLO 3.3 |
| | А. **Мэргэжлийн суурь хичээл** | | | | | | | | | | | | | | |
| 1 | Шинжлэх ухааны судалгааны арга зүй | + | + | | + | + | + | | + | | + | | + | + | |
| 2 | Биеийн тамирын боловсролын менежмент | + | | + | + | | | | + | | | + | + | + | + |
| 3 | Боловсрол судлалын үндэс | + | + | + | + | + | + | + | | + | + | + | + | + | + |
| 4 | Боловсролын философи | + | + | + | | | | + | | | + | | + | | + |
| 5 | Биеийн тамир спортын хэмжил зүй | + | + | + | + | + | + | + | + | + | + | + | + | + | + |
| | Б.**Мэргэших хичээл** | | | | | | | | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн боловсрол | + | + | + | + | + | + | + | + | + | | | + | + | + |
| 2 | Биеийн тамирын судалгааны онол арга зүй | + | + | + | | + | + | | | + | + | + | + | + | + |
| 3 | Биеийн тамир спортын сэтгэл судлалын үндэс | + | + | | | + | + | | | | | | + | + | + |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Биеийн тамирын боловсролын онол, арга зүй | | + | + | + | + | + | + | | + | + | | + | + | + |

“Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн мэргэжлийн суралцахуйн нэг үр дүнд (PLO-д) хичээлийн 9-22 суралцахуйн үр дүн (CLO) харгалзаж байна. Ялангуяа 1.2 буюу “Бие бялдрын хөгжил, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх зүй, эрүүл мэндийн боловсролын онол, үндсэн ойлголт хоорондын хамаарлыг харьцуулах”, 1.3 буюу “Биеийн тамирын боловсролын салбар дахь үндэсний болон олон улсын хууль, бодлого, боловсролын стандарт, хөтөлбөрийн бүтэц, үнэлгээний зарчмыг тайлбарлах”, 2.2 буюу “Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон сургалтын арга зүйг орчин үеийн боловсролын үнэлгээ, арга хэрэгслийг ашиглан суралцагчийн хөгжилд тохирсон үнэлгээ хийх” гэсэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тус бүрд нь хичээлийн 13 үр дүн харгалзаж байна. Харин 2.3 буюу “Олон нийт, эцэг эх, хамт олон, байгууллагатай харилцан ойлголцох, хамтран ажиллах”, 2.4 буюу “Компьютер, мэдээллийн технологийн хэрэглээг судалгааны арга зүй, шинжлэх ухааны судалгааны төрөл, аргачлал, өгөгдөл боловсруулахад ашиглах” гэсэн PLO-д хамгийн цөөн буюу 5 CLO харгалзсан байна (Хүснэгт 1.3).

Биеийн тамирын боловсрол мэргэжлээр суралцагчдын эзэмших академик мэдлэг, чадвар, хандлагын тоог хичээлийн кредит цагтай нь холбон судлахад:

- 3 кредит цаг судлах хичээл – 8
- 2 кредит цаг судлах хичээл – 1 байсан.
- 3 кредит цаг судалж буй хичээлүүдээр нийт 110 суралцахуйн үр дүнг дэвшүүлсэн нь нэг хичээлд дунджаар 13,75 мэдлэг, чадвар, хандлага оногдож байна.
- 2 кредит цаг судалж буй хичээлүүдээр нийт 13 суралцахуйн үр дүнг дэвшүүлсэн нь нэг хичээлд дунджаар 13 мэдлэг, чадвар, хандлага оногдоно.

Судалгааны энэ үзүүлэлт хөтөлбөрийн үр дүнгийн боловсруулалтыг хичээлийн кредит цагтай уялдуулж байгааг харуулсан. Тиймээс ҮБТДС-ийн хөтөлбөрийн дэд хороо 3 тэнхимтэй хамтарч “Мэргэжлийн хичээлийн стандартын CLO-г сайжруулах арга зүй” сэдэвт сургалтыг багш нартаа зохион байгуулж, нэг кредит хичээлд оногдох CLO-ны тоог тухайн хичээлийн хэлбэрээс хамаарсан жишиг загвар гаргаж, хичээлийн стандартаа сайжруулсан.

**Хичээлийн хөтөлбөрийн баталгаажуулалтыг сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглүүлж, агуулга, эзэмших чадварын залгамж холбоог хангаж, үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал**

БШУЯ-аас баталсан “Багш боловсролын талаар баримтлах бодлого”-д багш бэлтгэдэг сургуулийн сургалтын багц хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх хүрээнд; багц хөтөлбөрт сургалтын үндсэн хөтөлбөр, цахим хичээл, хэвлэмэл болон цахим сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, үнэлгээний даалгаврын санг багтаах, багш бэлтгэх хөтөлбөрийн үнэлгээг таван жил тутам хийж, хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлэх тогтолцоог бий болгох зорилт дэвшүүлжээ.




*Зураг 1.5 Магистрын хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо*

Магистрын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн нь төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох бөгөөд үүнийг сайжруулахад хичээлийн хүрэх үр дүн болон агуулгыг уялдуулна. “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн агуулгын залгамж холбоог зураг 1.5 харууллаа.

Магистрын сургалтын төлөвлөгөө нь намар, хавар гэсэн хатуу холбоо байдаггүй ба хичээлийн жилийн намар, өвөл, хаврын улиралд санал болгох төлөвлөгөөний дагуу хичээлүүд ордог (зураг 1.5). Хичээлийн агуулгын залгамж холбоо нь мэргэжлийн суурь хичээл ба магистрын судалгааны ажил гүйцэтгэх суурийг тавьж өгөхөөс гадна “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн онол, арга зүй, ойлголтыг эзэмшүүлэх эхний түвшин болно. Энэ нь 1-р улиралд судлах хичээлээр хэрэгжих бөгөөд 2,3-р улиралд мэргэшүүлэх болон судалгааны заавал ба сонгон судлах хичээлүүдээр хэрэгжинэ.

***Хөтөлбөрийн чанарын баталгаажилт***

Магистрын сургалтын хөтөлбөрт чанарын дотоод баталгаажуулалтын үнэлгээ хийх ажлын зорилго нь хөтөлбөрийн дотоод чанарын тогтолцоог бий болгон хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийн чанарын бодит үр дүнг хэмжих, баталгаажуулах, сайжруулахад чиглэсэн байна.

ҮБТДС-ийн “Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам”-ыг 2019 онд баталсан нь хөтөлбөрийн дотоод чанарын тогтолцоог бий болгон хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит үр дүнг хэмжих, баталгаажуулах, сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэг болсон. “Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам” болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэсэн сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх үнэлгээний хэлбэрүүдийг дараах матрицаар нэгтгэн харууллаа.

Хүснэгт 1.4 Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний матриц

| Үнэлэх хэсэг | Үнэлэх чиглэл | Үнэлэх зүйл | Үнэлэх шалгуур | Хэн хариуцах | Хэзээ үнэлэх |
|---|---|---|---|---|---|
| Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт | Хөтөлбөрийн үзэл баримтлал | Сургалтын хөтөлбөр | Журам 3.1,3.3 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | 3 жил тутамд |
| | Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүн | Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүн | Журам 3.1 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | 3 жил тутамд |
| | Сургалтын төлөвлөгөө | Сургалтын төлөвлөгөө-ний матриц | Журам 2.1, 3.1 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | Жилд 1 удаа |
| | Хичээлийн стандарт хөтөлбөр | Хичээлийн стандарт хөтөлбөр | Журам 2.1, 3.2 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | Жилд 1 удаа |
| Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт | Суралцахуйн үр дүнгийн үнэлгээ | Төгсөх ангийн оюутнуудаас | Төгсөлт-ийн шалгалт-ын дүн, дипломын дүн | Шалгалтын комисс, сургалтын алба | Хавар төгсөх үед |
| | Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа | Оюутан, багш, ажилтнууд | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд нэг удаа |
| | Хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ | Төгсөгчид, ажил олгогчоос | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд нэг удаа |
| | Хичээлийн хөтөлбөрийн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа | Хичээлийг судалсан оюутнуудаас | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд нэг удаа |
| | Хичээлийн үнэлгээ | Багш нарын явцын үнэлгээгээр | Ирц, явц, бие даалтын үнэлгээ-ний хуудас | Тэнхимийн эрхлэгч, сургалтын алба | Улирал бүр |

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг дараах 3 шатны үйл ажиллагаагаар төлөвлөж үнэлгээ дүгнэлт хийнэ.

- **Хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэх**

"Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэхдээ нэгдүгээрт тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнгийн хамаарлын матрицыг гаргасан байна. Мөн тодорхой ажил олгогч, хөтөлбөрт оролцогчдын саналыг судална.

- **Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх**

ҮБТДС-ийн 2024-2025 оны хичээлийн жилд шинэ хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, судлагдахуун бүрийн хөтөлбөрийг уялдуулан шинэчлэх, сургалтын чанар үр өгөөжийг дээшлүүлэх, сургалтад шинэ арга хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэх зэрэг зорилгыг дэвшүүлэн ажилласан. Ийнхүү хөтөлбөрийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмыг сургуулийн эрхэм зорилго, үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөөг үр дүнтэй нь уялдуулан, бодитой үр ашигтай хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа нь үр нөлөөгөө үзүүлж байна.

- **Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх**

Хөтөлбөрийн нэр хүндийн үзүүлэлт нь элсэгчдийн тоо, шилжилт хөдөлгөөний шалтгаан, гадаад оюутны тоо, мэргэжлийн уралдаан тэмцээний амжилт, ажлын байрны эрэлт зэргээр тодорхойлогдоно. Хөтөлбөрийн суралцахуйн болон хичээлийн үр дүнг үнэлэх үнэлгээний даалгаврыг хичээл бүрээр боловсруулж, тохирлыг удаа дараа хянаж сайжруулсан. Үнэлгээний даалгавраар магистрын ажил хамгаалалт хийж байна.

Чанарын дотоод баталгаажуулалтын албанаас хичээлийн үр дүн, багшийн заах арга, ур чадвар, харилцаа хандлагын талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг улирал тутамд авч, үр дүнг нэгтгэж хичээлийн чанарыг сайжруулахад анхаарч ирсэн. Мөн хөтөлбөр хэрэгжих үйл ажиллагааг зохион байгуулагч сургуулийн захиргаа, хөтөлбөрийн алба, сургалтын албаны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Магистрын ажил хамгаалалтаас үндэслэж мэргэжлийн удирдагч нараас судалгаа авч боловсруулалт хийсэн. Энэ судалгаанд ҮБТДС-ийн 8 багш, удирдагч 5 эрдэмтэн багш хамрагдсан. Тэд магистрын хөтөлбөрийн хэрэгжилтийг ерөнхийдөө сайн гэж үнэлсэн.

Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад оролцогч талууд нь сургуулийн захиргаа, хөтөлбөрийн хороо, чанарын баталгаажуулалтын алба, багш, оюутан, төгсөгч, ажил олгогч, бусад гэсэн талуудаас бүрдэнэ. Энэ нь бүх талуудын оролцоо санал хүсэлтээр сургалтын хөтөлбөрийг үнэлж дүгнэх сайжруулах арга юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ оролцогч болон сонирхогч талуудын оролцоог дэмжих зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтарч ажилладаг. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж, өөрийн үнэлгээ хийдэг байдал:

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц дүрэм журам, удирдамжийг боловсруулж, тэдгээрийг байнга сайжруулж ирсэн нь сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн агуулга, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг ашиглах боломжийг нээж өгсөн. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд өөрийн сургуулийн багш нараас гадна суралцагчид, биеийн тамирын салбарын багш мэргэжилтнүүдийн санал ба оролцоог өргөжүүлэх талаар цаашид анхаарах хэрэгтэй. Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний

журмаар хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээний тогтолцоог бий болгож, хэвшүүлэх ажил хийгдэж байна.

### 1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

*Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.*

***Хичээлийн нэр, зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн /магистрант, докторантын эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамж/ энэхүү хичээлийг судлахын өмнө судалсан байвал зохих хичээлийн тухай үндсэн мэдээллийг гаргасан байдал.***

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт ба хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтууд, хоорондын уялдаа холбоо, магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөөний матриц, хичээлийн хөтөлбөрийг цэгцтэй, ойлгомжтой болгох зэргээр нэмэлт өөрчлөлтийг сургалтын чанарт анхаарч, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу сайжруулж байна. Тухайлбал, Хөтөлбөрийн хороо буюу тэнхимийн 2025 оны 03 сарын 15-ны өдрийн хурлаар “Хичээлийн хөтөлбөрийн бүтэц, боловсруулалтын хувилбар”-ыг хэлэлцэн баталсан бөгөөд хэрэгжиж байна. “Биеийн тамирын боловсрол”-ын магистрын хөтөлбөрийн хичээлийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг БШУ-ны сайдын 147-р тогтоолын 2.5.6.2-д заасны дагуу дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

1) Хичээлийн үндсэн мэдээлэл (Хичээлийн нэр, код, багц цаг, хариуцах нэгж, багшийн мэдээлэл, хичээлийн залгамж холбоо, багц цагийн харьцаа, түвшин, судлах улирал гэх мэт)
2) Хичээлд ашиглах материал (Үндсэн сурах бичиг, нэмэлт ном, материал, цахим сургалтын веб холбоос гэх мэт)
3) Хичээлийн тодорхойлолт
4) Хичээлийн зорилго
5) Хичээлийн агуулга, цагийн хуваарилалт
6) Хичээлийн суралцахуйн үр дүн
7) Сургалтын арга зүйн төлөвлөлт
8) Хичээлийн үнэлгээний аргачлал
9) Хичээлд тавих нэмэлт шаардлага

Суралцахуйн ачаалал багц цагаар тодорхойлогддог, хичээлүүдийн залгамж холбоогоор уялдааг харуулсан байгаа. Багш бүр хичээлийн хөтөлбөрүүд, үнэлгээний загвар гарын авлага боловсруулсан бөгөөд 2025-2026 оны хичээлийн жилд сургалтад хэрэгжүүлэхэд бэлэн болсон байна.

***Гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх арга хэлбэрийн тодорхойлолт ба хичээлийн үндсэн агуулга, судлах зүйлийн тойм, холбогдох эх сурвалж, гүйцэтгэх даалгаврыг тусгасан байдал***

"Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийснээр цаашид хэрэгжих мэргэжлийн суурь-4, мэргэшүүлэх-4, нийт 8 хичээлийн хөтөлбөрийг дараах загварын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан.

БСШУ-ны сайдын 2014 оны 9-р сарын 12-ны өдрийн А/370 тоот, нийтлэг шаардлагыг шинэчлэн батлах тухай", БСШУСпортын сайдын 2024 оны 03 сарын 20 өдрийн А/147 тоот тушаалын хавсралтуудаар батлагдсан "Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам"-ын дагуу хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулсан.

- Хичээлийн нэр, зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн (магистрантын эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага), энэхүү хичээлийг судлахын өмнө судалсан байвал зохих хичээлийн тухай үндсэн мэдээлэл
- Хичээлийн үндсэн агуулга, хичээллэх өдөр бүрээр төлөвлөсөн судлах зүйлийн тойм, холбогдох эх сурвалж, гүйцэтгэх даалгавар
- Суралцагчийн гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх арга хэлбэр, үнэлгээний хуваарь
- Хичээлийг заах багшийн нэр, хаяг

***Хичээлийн хөтөлбөрүүд суралцагчийн мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал***

"Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээлийг ҮБТДС-ийн эрдэмтэн судлаач багш нар заадаг ба хичээлүүдийн уялдаа холбоог сайжруулах, дэлхийн чиг хандлага руу ойртуулах зорилгоор сургалтын хөтөлбөр, стандартыг шинэчлэн боловсронгуй болгох ажлыг үе шаттай явуулж байна. Үүнээс гадна суралцагчдад дараах байдлаар мэдээллийг хүргэдэг. Үүнд:

- Хичээл сургалтын төлөвлөгөө, үйл явц, сургалтын программ хангамж
- Суралцагчдад зориулсан гарын авлага
- Хичээл сургалтаас бусад бүхий л мэдээлэл
- Хичээлийн хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааны чиглүүлэх сургалтыг танхим болон ганцаарчилсан хэлбэрээр хөтөлбөрийн алба ба зөвлөх багш нар чиглүүлж, хэрэгжүүлж, хяналт тавьж ажилладаг. Мөн хөтөлбөрөөр зааж буй хичээлийн онцлогоос хамаарч, багш нар хичээлийн агуулга, арга зүйдээ хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх чиглэлийн агуулгыг тусган хэрэгжүүлж байна.

***Хөтөлбөрт хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадварыг хөгжүүлэх боломжийг тусгасан байдал***

ҮБТДС-ийн "Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрт суралцахыг сонирхогч элсэгчид нь жилд 2 удаа буюу намар, өвөл элсэлтээр хамрагддаг нь хувь хүний сурах, хөгжих хүсэл эрмэлзэл, эрхийг хангасан бөгөөд шаардлагатай үед хичээлийн хоцрогдлоо гүйцэж, нөхөн суух боломжтой байдаг. Хөтөлбөрөөр суралцагч нь эрдэм шинжилгээний ажлын удирдагч, зөвлөх зэргийг өөрөө сонгож, хамтран багаар ажиллаж, судалгааны ажлыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ. Судалгаа хийж, эрдэм шинжилгээний бүтээл туурвих явцдаа номын сан,

холбогдох лаборатори, судалгааны материалтай нээлттэй ажиллаж, төсөл, хөтөлбөрт хамрагдаж, өөрийгөө хөгжүүлэх, ур чадвараа дээшлүүлэх боломжтой.

Хөтөлбөрөөр суралцаж буй гадаад суралцагч нь монгол хэл, найруулга зүй, соёлын чиглэлийн хичээлд хамрагдаж, хэлний мэдлэгээ дээшлүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сургууль, хамт олны зүгээс дэмжлэг үзүүлдэг. Сургалтын төлбөрийг төв, орон нутгийн байгууллага, хувь хүн төлөх зэрэг хувилбартай.

**1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

*Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий төрөлжсөн нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.*

***Сургалтын агуулга, хичээлийн суралцахуйн үр дүн нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй нийцсэн байдал***

Суралцахуйн хүрэх үр дүн нь МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дээд боловсролын болон олон улсын жишиг, хөгжлийн чиг хандлагыг үндэс болгосон мэргэжилтэн, судлаачийг бэлтгэх бодлогыг баримтлан, биеийн тамир, спортын шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгт суурилсан суурь болон хавсарга судалгааг хөгжүүлэх, туршилт судалгаанд суурилсан, мэргэжлийн өндөр чадамжтай, бие бялдар, ёс зүйн хувьд төлөвшсөн, зөв хандлагатай судлаачийг бэлтгэн төгсгөхөд чиглэж байна.




*Зураг 1.6 Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO), хичээлүүдийн суралцахуйн үр дүнгийн (CLO) хамаарал*

“Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн мэргэжлийн суралцахуйн нэг үр дүнд (PLO-д) хичээлийн 6-34 суралцахуйн үр дүн (CLO) харгалзаж байна. Ялангуяа 4.1. буюу “Мэргэшиж буй шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар”, 4.2. буюу “Биеийн тамирын магистрын боловсролын мэдлэг, чадвар” гэсэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тус бүрд нь хичээлийн 28-31 үр дүн буюу 17,6-19,5% нь харгалзаж байна. Харин 2.1. буюу “Мэдээлэл харилцаа технологийг хэрэглэх, статистик аргаар мэдээлэл боловсруулах, үнэлэн дүгнэх” ба 3.2. "Суралцахуйн зүй тогтол, сургалтыг зохион байгуулахад харгалзах” гэсэн PLO-д хамгийн цөөн буюу 8 CLO буюу 5,0-6,3% нь харгалзсан байна.

***Хөтөлбөрийн хичээлүүдийн онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал***

“Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөр нь онол болон практик хичээлийг зохистой харьцаагаар судлахаар төлөвлөгдсөн бөгөөд хичээл тус бүр лекц, семинар, бие даалтын цагийг багтаасан болно. “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн шаардлагын дагуу хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулсан бөгөөд суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагад анхаарч ур чадварыг сайжруулах, бие даан шийдвэр гаргах, судалгаа хийх чадварыг нэмэгдүүлэх, орчин үе, нийгмийн орчинд ажиллах боломжтой нөхцөлийг тооцон сургалтыг зохион байгуулж байна.

Хүснэгт 1.5 Хөтөлбөр дэх мэргэжлийн заавал судлах хичээлээр оюутны суралцах ачааллын шинжилгээ

| Улирал | | Судлах хичээлийн тоо | Хичээлийн хэлбэр, цаг | | | | Бие даалтын цаг | Долоо хоногт судлах цаг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Лекц | Сем | Лаб | Прак | | |
| 1 А улирал I | | 4 | 112 | 96 | 32 | | 12 | 15 |
| 1 С улирал II | | 4 | 112 | 96 | 32 | | 24 | 15 |
| 2 А улирал III | | 2 | | | 48 | 112 | 16 | 3 |
| **Нийт** | **Цаг** | | **224** | **192** | **112** | **112** | **52** | **33** |
| | **Хувь** | | **35.0** | **30.0** | **17.5** | **17.5** | | |

Суралцагчийн санал болгох төлөвлөгөө (Хүснэгт 1.5)-нд тусгасан танхимд судлах болон бие даан судлах цагийн ачаалал ойролцоо байгаа нь лекц, семинараар эзэмшсэн чадвараа практик хэрэглээ болгоход чиглэсэн, зохистой цагийн ачаалал гэж дүгнэж байна. Сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн заавал судлах хичээлүүдийн онол, практикийн харьцааг авч үзэхэд лекц, семинар, лаборатори 65%, спортын практик хичээл 35%- ийг эзэлж байна. Багш нараас гаргасан санал, оюутны судалгаанд шинжилгээ хийж үзвэл “Биеийн тамирын боловсролын” судлаачийн хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэх, хүрэх үр дүнг хангахад онолын хичээл 60%, практикийн хичээл 40% байх нь тохиромжтой гэж үзсэн.

“Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын 1-р курст судлах суурь хичээлүүд нь мэргэжлийн болон судалгааны онол, арга зүйг эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухаан, мэргэжлийн суурь хичээлүүд болно. 2-р курст судлах хичээл нь мэргэшүүлэх чиглэлд илүү анхаарч, сонгох хөтөлбөрийг илүү олон хувилбартайгаар санал болгож байгаа юм. Энэ нь суралцагчдын нийгмийн хэрэгцээ тухайн судалгаа, шинжилгээний ажлын чиглэлд нийцүүлэн биеийн тамир, спортын орчин үеийн болон уламжлалт мэдлэг чадвар хандлагыг эзэмшүүлэх зэргээр нарийвчилсан судалгаа шинжилгээ хийх арга зүйг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

***Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал***

Сургалтын хөтөлбөрийн сүүлийн 5 жилийн хугацаа (2018-2023)-нд хийсэн өөрчлөлт, нэмэлт сайжруулалт нь дараах агуулгыг багтаасан. Үүнд: ”Биеийн тамирын судалгааны арга зүй” хичээлээр гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлүүд, олон улсын туршлагыг сургалтад ашиглах, дадлага, дасгал хийх

чиглэлээр агуулгын өөрчлөлт хийсэн. ”Биеийн тамирын тэгш хамруулах боловсрол” хичээлээр хүний эрх, хүртээмжтэй боловсролыг хангах чиг үүрэг бүхий агентлаг, байгууллагуудын менежмент, түүний онцлогийг таньж мэдэх, мэргэжлийн байгууллагуудад ажиллах болон удирдахуйн ухааны асуудлыг тусгасан нь суралцагчдад бүх талын мэдлэг, чадвар эзэмших боломжийг нээж зөв хандлага төлөвшүүлэх юм.

***Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлага ба хөтөлбөрийн хичээлүүдэд тусгасан байдал***

ҮБТДС-ийн захиргаа, Эрдмийн зөвлөл болон хөтөлбөрийн хороо, мэргэжлийн багш нараас “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийг боловсронгуй болгох асуудлаар гаргасан саналыг хөтөлбөрт тусгав.

Хүснэгт 1.6 Зөвлөлийн санал

| № | Оролцогч талууд | Санал | Хөтөлбөрт тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1 | Захиргааны зөвлөл | Сургалтын журмыг мөрдөх | Шаардлагатай заалтуудыг боловсруулж тусгах |
| 2 | Эрдмийн зөвлөл | Судалгааны арга зүйг гүнзгийрүүлэх | Шаардлагатай хөтөлбөрүүдийг боловсруулах |
| 3 | Хөтөлбөрийн хороо | Хөтөлбөрийн агуулгыг сайжруулах | Судлаач эрдэмтдийг бэлтгэх, судалгааны семинарын үйл явцыг удирдах |
| 4 | Багш нар | Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх | Чадварлаг мэргэжилтэнд зориулсан хөтөлбөр боловсруулах |

***Хөтөлбөрийн хичээлүүдийн үндэсний болон олон улсын ижил төстэй хөтөлбөртэй нийцсэн байдал***

ҮБТДС-ийн “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа гадаад, дотоодын нэр хүнд бүхий дараах сургуулиудын сургалтын төлөвлөгөөг судалж, харьцуулсан бөгөөд үүнд хичээлийн хөтөлбөрүүд, суралцагчдын үнэлгээний журам, суралцагчдад олгох академик мэдлэг чадвар, бие даасан болон хамтарсан судалгааг хийх, мэргэжлийн ур чадварт чиглэсэн хөтөлбөр болон хичээл хоорондын уялдаа холбоо зэргийг хамруулна.

Хүснэгт 1.7 Хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээний үр дүн

| № | Их, дээд сургуулиуд | Хөтөлбөрийн үндсэн баримт | Суралцах хэлбэр | Суралцах хугацаа | Судалгааны үр дүн | Нийт цаг |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний Биеийн Тамирын Дээд сургууль | БСШУ-ны сайдын А/370 | өдөр, эчнээ | 1,5-2 жил | - судлаач<br>- мэргэжлийн | 34 кр |
| 2 | Кёнхи их сургуулийн (Kyung Hee University) | БНСУ-ын боловсролын яамны нийтлэг шаардлага | өдөр | 2 жил | - багш<br>– судлаач | 24 кр |
| 3 | ОХУ (РГУФКСМиТ)<br>БТСАЖЗ-н Их Сургууль | ОХУ-ын Спортын яамны нийтлэг шаардлага | өдөр, эчнээ | 2-2,5 жил | -багш<br>- судлаач | 120 цаг |
| 4 | Хятад (Бээжингийн спортын их сургууль, BSU) | БНХАУ-ын боловсролын яамны нийтлэг шаардлага | өдөр | 2-4 жил | -судлаач | 36 кр |
| 5 | МУБИС, Биеийн тамирын сургууль | БСШУ-ны сайдын А/370 | өдөр, эчнээ | 1,5-2 жил | -судлаач | 34 кр |
| 6 | Аварга Дээд сургууль | БСШУ-ны сайдын А/370 | өдөр, эчнээ | 1,5-2 жил | - судлаач | 34 кр |
| 7 | Мон-Алтиус Дээд сургууль | БСШУ-ны сайдын А/370 | өдөр, эчнээ | 1,5-2 жил | - судлаач | 34 кр |

***Ижил хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийж давуу болон сул талуудыг тодорхойлсон байдал***

Хүснэгт 1.8 Хөтөлбөрүүдийн бүтцийг харьцуулсан шинжилгээний үр дүн

| **Улс /Сургууль/** | **Судалгааны суурь** | **Мэргэжлийн суурь** | **Мэргэжлийн судалгаа** | **Сонгон судлах** | **Диссертацийн ажил** | **Нийт багц цаг** |
|---|---|---|---|---|---|---|
| ОХУ (РГУФКСМиТ) | 20-30 | 40-50 | 30-40 | 10-20 | 20-30 | 120 |
| Хятад (Бээжингийн Спортын Их Сургууль) | 8-12 | 10-15 | 8-12 | 5-8 | 6-10 | 36-50 |
| Япон (Спортын Шинжлэх Ухааны Их Сургууль) | 6-10 | 10-15 | 6-10 | 3-5 | 5-10 | 30-40 |
| Солонгос (Кёнхи Их Сургууль) | 9-12 | 12-15 | 6-9 | 3-6 | 6-9 | 36-42 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль | 6 | 6 | 9 | 4 | 5 | 34 |
| МУБИС, Биеийн тамирын сургууль | 8 | 10 | 6 | 2-4 | 5 | 30-34 |
| Аварга Дээд Сургууль | 6 | 12 | 8 | 2-4 | 5 | 30 |
| Мон-Алтиус Дээд Сургууль | 8-10 | 10-12 | 6-8 | 4-6 | 6 | 32-36 |

Хүснэгт 1.7, 1.8-аас дүгнэхэд улс орнуудын магистрын хөтөлбөрийн багц цагийн хуваарилалт нь сургалтын онцлог, зорилгоос хамаарч өөр өөр байгааг харуулж байна. ОХУ, Хятад, Солонгосын хөтөлбөрүүд илүү өргөн хүрээг хамардаг бол Монголын хөтөлбөр нь илүү төвлөрсөн бүтэцтэй байна.

- ОХУ судалгааны өргөн хүрээ, гүнзгийрүүлсэн агуулга, багц цагийн өндөр шаардлагаараа онцлогтой.
- Хятад, Япон, Солонгос судалгаа, практик, сонголтын хослолыг чухалчилсан, илүү уян хатан бүтэцтэй.
- Монгол илүү төвлөрсөн, үндэсний боловсролын онцлогийг тусгасан, бага хэмжээний багц цагтай хөтөлбөртэй.

ҮБТДС-ийн “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрийг ижил төстэй сургуулиудын хөтөлбөртэй харьцуулахад дэлхийн боловсролын хөгжлийн чиг хандлага болон өөрийн орны хөгжлийн бодлоготой уялдуулсан, чадварлаг мэргэжилтнийг бэлтгэх зорилго бүхий нийтлэг шинж ажиглагдаж байна. “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн бүтэц тэр дундаа сонгох хөтөлбөрийг олноор санал болгож байгаа нь тус хөтөлбөрийн давуу тал болж байна. Мөн дипломын шүүмжлэгч болон диплом хамгаалалтын зөвлөлд тухайн салбарын мэдлэг туршлагатай гадны нэг ба түүнээс дээш мэргэжилтнийг оролцуулна гэж заажээ. Энэ нь ҮБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгатай нийцэж байна. “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрөөр төгсөгчийн давуу тал нь орчин үеийн хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухаан, техник технологийг дэвшилд суурилсан биеийн тамир, спорт хөгжиж байгаа өнөө үед мэргэжлийн шинжлэх ухааны онол, сургаал, үзэл баримтлал, судалгааны аргуудыг эзэмшиж онол, практикийн нэгдмэл чанарыг хослуулж байна.

***Дотоодын сургалтын хөтөлбөртэй хийсэн харьцуулалт***

“Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрийг МУ-ын хэмжээнд магистрын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа дотоодын их, дээд сургуулиудын хөтөлбөртэй харьцуулж үзсэн.

Монгол улсад “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн өмчийн их сургууль нэг, хувийн хэвшлийн их, дээд сургууль гурав байна. Үүнээс “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөр хэрэгжүүлдэг гурван их, дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулан судлахдаа сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн тоо, нийт кредит, ерөнхий суурь

хичээл, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн харьцаа зэрэг үзүүлэлтийг шалгуур болгон авсан.

Бусад сургуулийн “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөртэй харьцуулахад Үндэсний Биеийн Тамирын дээд сургууль, “Мон-Алтиус” дээд сургууль, “Аварга” дээд сургуулийн ерөнхий суурь, мэргэшүүлэх суурь, мэргэжлийн суурь хичээлийн кредит нь нийт 34 байгаа нь МУБИС-ийн БТС-ийн сургалтын хөтөлбөртэй ижил байна (Хүснэгт 1.7-1.8).

**1.6 Шалгуур 1 SWOT, TOWS шинжилгээ**

| Давуу тал/S | Сул тал/W |
|---|---|
| • **Туршлага**: Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль нь 1991 онд байгуулагдсан бөгөөд хэд хэдэн удаа магадлан итгэмжлүүлсэн, туршлага, нэр хүндтэй. Хөтөлбөр нь сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, хөгжлийн бодлоготой уялдсан. Багш мэргэжлийн үнэт зүйл, суралцахуй, үр дүнд суурилсан сайн үзэл баримтлалтай<br>• **Олон улсын хүлээн зөвшөөрөлт**: Хөтөлбөр нь олон улсын хөгжлийн чиг хандлага, монголын боловсролын бодлогод нийцсэн. БНХАУ, ОХУ, БНСУ зэрэг олон орны оюутнууд энэ хөтөлбөрт суралцаж төгсдөг. Магистрын диплом нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгддөг.<br>• **Судалгааны чиглэл**: Хөтөлбөрт биеийн тамирын судалгааны болон шинжлэх ухаан дээр анхаарал хандуулсан бөгөөд мэргэжлийн багш нарын судалгааны аргачлал, шинэлэг байдлыг ашиглаж байна.<br>• **Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн** арга зүй, орчин, үнэлгээ нь хичээлийн хөтөлбөрөөр хэрэгжихүйц цогц байдлаар боловсруулсан. Хөтөлбөрийн PLO-г хангахуйц CLO-г хичээл бүрээр тодорхойлж, түүнийгээ үнэлэх тогтолцоо бий болсон. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, баталгаажуулах тогтолцоо бүрдсэн. | • Хөтөлбөрийн боловсруулалтад ажил олгогч, төгсөгчдийн оролцоо дутмаг<br>• Хөтөлбөрийн зорилго, шинэчлэл, суралцахуйн үр дүнд суурилсан онцлогийг мэргэжлийн удирдлага, биеийн тамирын багш нарт таниулах, хөтөлбөр боловсруулахдаа хамтран ажиллах үйл ажиллагаа дутагдалтай.<br>• Биеийн тамирын боловсролын салбарт практик дадлага хийх боломж хязгаарлагдмал байж болно. |
| **Боломж/O** | **Эрсдэл/T** |

| | |
|---|---|
| • **Олон улсын хамтын ажиллагаа**: Солилцооны хөтөлбөрүүд болон хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх боломжууд нэмэгдэж байна.<br>• **Биеийн тамирын боловсролын өсөлт**: Монгол Улс болон дэлхий даяар биеийн тамир, спортын боловсролын хэрэгцээ өссөөр байгаа бөгөөд энэ нь хөтөлбөрийн хэрэгцээг нэмэгдүүлж байна.<br>• **Технологийн дэвшил**: Онлайн болон дижитал сургалтын аргуудын өргөжилт, мөн шинэ технологиудын хэрэгжилтээр сургалт болон судалгаа, сургалтын ачааллыг багасгах боломжтой.<br>• **Нийгмийн эрэлт хэрэгцээ**: Спортын боловсролын салбар дахь шинэчлэл болон мэргэжлийн ур чадварын эрэлт нэмэгдэж байгаа нь магистрын хөтөлбөрт амжилттай үр дүн гаргах боломжийг бий болгож байна. | • **Багш, ажилтнуудын шилжилт**: Багш нар болон мэргэжилтнүүдийн хөдөлгөөн нь хөтөлбөрийн чанар болон тогтвортой байдлыг эрсдэлд оруулж магадгүй.<br>• **Өрсөлдөөн**: Биеийн тамир, спортын боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй олон сургуулиудтай өрсөлдөх шаардлага үүсэж болно.<br>• **Эдийн засгийн хүндрэл**: Санхүүгийн хүндрэлийн үед сургалтын төсөв болон тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийхэд хүндрэлтэй байж болох юм.<br>• **Судалгааны хүрээний хязгаарлалт**: Шинэ судалгааны төсөл, инновац дээр зарим зөрчилдөөн гарах буюу санхүүжилт дутагдах боломжтой. |
| **OS стратеги** | **OW стратеги** |
| • **Олон улсын хамтын ажиллагаа**: Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль нь олон улсын түншлэлээ өргөжүүлж, хамтарсан судалгаа, хичээл зохион байгуулах, академик солилцоог нэмэгдүүлэх боломжтой.<br>• **Биеийн тамирын боловсролын өсөлт**: Биеийн тамирын боловсролыг дэлхий даяар нэмэгдэж буй хэрэгцээтэй нийцүүлэн хөтөлбөрийн агуулгыг шинэчилж, илүү олон салбарт чиглэсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх.<br>• **Технологийн дэвшил**: Онлайн болон дижитал сургалтын хөтөлбөрүүдийг өргөжүүлж, сургалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгох. | • **Мэргэжлийн багш нарын ур чадварыг сайжруулах**: Олон улсын сургалт, семинаруудыг зохион байгуулж, багш нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх.<br>• **Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт**: Олон улсын хамтын ажиллагааг ашиглан шаардлагатай тоног төхөөрөмж, судалгааны баазыг шинэчлэх.<br>• **Практик сургалтыг дэмжих**: Оюутнуудын практик туршлага олгох, бодит амьдралд хэрэгтэй ур чадварыг эзэмшихэд илүү их анхаарах. |
| **TS стратеги** | **TW стратеги** |
| • **Шилжилтийг даван туулах**: Багш нарын тогтвортой байдлыг хангах үүднээс дотоод сургалт, хариуцлагын тогтолцоог боловсруулж, багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах.<br>• **Орон нутгийн болон олон улсын өрсөлдөөнтэй тулалдах**: Хөтөлбөрийн агуулгыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, шинэ санаачилгуудыг дэмжих. | • **Шилжилт хөдөлгөөнөөс хамгаалах**: Багш нарын тогтвортой байдлыг дэмжих үүднээс мэргэжлийн хөгжлийг дэмжих системийг бий болгох.<br>• **Эдийн засгийн хүндрэлийг даван туулах**: Санхүүгийн олон эх үүсвэрийг эрэлхийлэх, хувийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах. |

| | |
|---|---|
| • **Эдийн засгийн хүндрэлд дасан зохицох**: Хөтөлбөрийг олон эх үүсвэрээс санхүүжүүлэх стратеги боловсруулж, гадаад хамтын ажиллагаа, түншлэлүүдийг ашиглах.<br>• **Оюутнуудын оролцооны хомсдолыг арилгах**: Суралцагчдад илүү оролцооны боломжийг олгох, практик сургалт, төсөл хэрэгжүүлэх арга хэмжээг нэмэгдүүлэх. | • **Техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах**: Багц цаг болон сургалтын ачааллын шаардлагын дагуу тоног төхөөрөмж, лабораториудыг сайжруулах. |

### 1.7 Сайжруулах арга зам

- Оролцогч, сонирхогч талуудыг хамарсан зөвлөгөөнийг улсын хэмжээнд зохион байгуулж, санал, хүсэлтийг тусган, хөтөлбөрөө сайжруулахад ашиглах
- “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг олон нийтэд таниулах онлайн болон бусад хэлбэрийг ашиглах
- Оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны ажлыг захиалгат төслийн хэлбэрээр судлаач багш нараар хийлгэн, хөтөлбөрийг боловсруулах болон чанарын үнэлгээ хийхэд ашиглах
- Биеийн тамирын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон харгалзах хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийг Хөтөлбөрийн дэд хороо, салбар хороогоор дахин үе шаттайгаар хэлэлцэж, сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах
- -Багш нарын хөтөлбөр боловсруулах мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг өмнөх туршлагадаа тулгуурлан, тогтмол зохион байгуулах зэргээр хөтөлбөрийн төлөвлөлтийг сайжруулах боломж, арга замууд байна.

### 1.8 Үнэлгээ

“Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн “Хөтөлбөрийн зорилго, агуулга”-д холбогдох шалгуурын хувьд их сургуулийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангахуйц түвшинд өөрийн үнэлгээний тайланг боловсруулсан байна.

Хүснэгт 1.9 Магистрантын зорилго, агуулгад хийсэн өөрийн үнэлгээ

| Шалгуур | Үзүүлэлт | Хэмжээс | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1.1 | Холбогдох хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан эсэх | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг хангаан тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг<br><br>**Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт | **Хангалттай сайн** |
| | Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт,үнэлгээ,чанарын баталгаажуулалтыг жил бүр хянадаг эсэх | | |
| | Хөтөлбөр нь чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгжиж байгаа эсэх | | |

| | | | |
|---|---|---|---|
| **1.2** | Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон эсэх | бүрийг бүрэн хангасан | **Хангалттай сайн** |
| | Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн эсэх (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан). | **Сайжруулах шаардлагатай:** Нэг үзүүлэлтийг хангасан | |
| **1.3** | Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж баталгаажсан эсэх | **Хангалтгүй:** | **Хангалттай сайн** |
| | Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшний судалгааг хөгжүүлэхэд чиглэн, онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалт, судалгааны төлөвлөгөө болж чадсан эсэх | Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | |
| **1.4** | Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан эсэх | | **Сайжруулах шаардлагатай** |
| | Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх | | |
| **1.5** | Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан эсэх | | **Хангалттай сайн** |
| | Үндэсний болон олон улсын сайн туршлагыг судалж хэрэгжүүлж байгаа эсэх | | |

### 1.9 Дүгнэлт

Биеийн тамирын боловсролын “Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга” шалгуурын дагуу өөрийн үнэлгээнд суурилан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Биеийн тамирын боловсрол хөтөлбөр нь олон улсын болон Монгол улсын боловсролын чиг хандлагад тулгуурласан үнэт зүйлд баримжаалсан, үр дүнд суурилсан, суралцахуйд чиглэсэн сургалтын хөтөлбөр болсон байна.
2. Магистрын сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгыг хангалттай сайн хэрэгжүүлж байна.
3. Магистрын ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, хамтын судалгааны баг бүрдүүлэх, төсөл хөтөлбөрт магистрантуудыг нэмж оролцуулж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

## ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль (ҮБТДС) нь магистрын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрэн хангаж, тус сургалтын түвшинд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэн, үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль (ҮБТДС) нь магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлсэн бөгөөд магистрантын суралцахуйн үйл явц, судалгааны ажлыг бүх шатанд дэмжих тогтолцоог бүрэн нуруутай хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь дараах эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурласан. Үүнд:

- Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль
- БШУ-ны сайдын 2024 оны А/147, А/144 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Магистрын сургалтын нийтлэг шаардлага”
- ҮБТДС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 79 тоот тушаалаар батлагдсан “Магистрын сургалтын журам”
    - ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 19 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой дотоод журам, баримт бичгүүд
    - “ҮБТДС-д оюутан элсүүлэх журам” – 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 31 тоот тушаал

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хөтөлбөрийн ерөнхий хороо”, “Хөтөлбөрийн дэд хороо” болон хөтөлбөрийн алба арга зүйн удирдлагаар хангаж, мэргэжлийн тэнхимүүд, профессорын багийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг. Хөтөлбөрийн хэрэгжилтэд суралцагч, төгсөгч, ажил олгогч, багш нараас санал авч үнэлгээ хийдэг тогтолцоо бүрдсэн.

Ийнхүү ҮБТДС нь эрх зүйн үндэслэл, зохион байгуулалтын бүтэц, журам, удирдлагын тогтолцоогоор хангагдсан, нотолгоонд суурилсан, ил тод, үр дүнтэй магистрын сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

### 2.1 Элсэлт

*Элсэгчид тавигдах шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцөлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв, удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.*

Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль нь магистрын хөтөлбөрт элсэгчдэд тавих шаардлагаа шударга, ил тод, хөтөлбөрийн зорилтот суралцахуйн үр дүнд хүрэх боломжийг хангах зарчимд тулгуурлан хэрэгжүүлдэг. Элсэгч нь бакалаврын боловсрол эзэмшсэн, тухайн мэргэжлийн чиглэлээр тодорхой хугацаанд ажилласан, судалгааны үндсэн ойлголт, чадвартай, гадаад хэлний мэдлэг бүхий байх шаардлагатай.

Элсэлтийн үйл ажиллагаа нь дараах эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлаж хэрэгждэг:

- ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 19 тоот тушаал – “Магистрын сургалтын журам”-ын 9.1–9.3-р зүйл,
- ҮБТДС-ийн захирлын 2024 оны 6 дугаар сарын 10-ны 31 тоот тушаал – “ҮБТДС-д оюутан элсүүлэх журам”-ын 4.1, 4.2-р зүйл.

Сүүлийн 5 жилийн элсэлтийн мэдээнээс үзэхэд дотоодоос 54, гадаадаас 51, нийт 105 магистрант элссэн байна. ҮБТДС нь 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр БНХАУ-ын “Mongol Bridge Group” байгууллагатай байгуулсан гэрээний хүрээнд гадаадын магистрантыг тогтмол элсүүлж байна.

Магистрын хөтөлбөрт суралцагч элсүүлэх үйл ажиллагааг жил бүрийн элсэлтийн журмаар зохицуулна. ҮБТДС-ийн магистрантурт суралцагч элсүүлсэн тухай шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна. Магистрын хөтөлбөрийн элсэлтийг жилд 1-2 удаа зохион байгуулна.

Хүснэгт 2.1 Элсэлт зохион байгуулах хугацаа

| Зун | Өвөл |
|---|---|
| 7-8 сард бүртгэл, анги сонголт, 10 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 15 хүртэл сургалт | 12, 1 дүгээр сард бүртгэл, анги сонголт,<br>1 дүгээр сарын 20-ноос 4 дүгээр сарын 15-ыг хүртэл сургалт |

Суралцах эрх авсан магистрант нь сургалтын болон хөтөлбөрийн албаны мэргэжилтэнтэй уулзаж, суралцах гэрээ байгуулан, хичээлийн хуваарь болон багшаа сонгоно.Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогийг харгалзан элсэгчдэд дараах шаардлагыг тусгасан. Үүнд:

- Бакалаврын боловсролтой байх;
- “Биеийн тамирын багш” мэргэжилтэй байх;
- Спортын төрлүүдээр секц, дугуйлан хичээллүүлж, тамирчин бэлтгэсэн туршлагатай байх;

***Гадаад магистрантад тавигдах шаардлага***

Гадаадын иргэн магистрантурт суралцах үйл ажиллагаа, тавигдах шаардлагыг ҮБТДС-ийн магистрын сургалтын журмын 9.3-д тусгасан болно. ҮБТДС-д суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь МУ-д мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин стандартад дүйцэх өмнөх шатны боловсролыг эзэмшсэн байх ба суралцахыг хүсэгч гадаадын иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлнэ. Үүнд:

- Гадаад паспортын хуулбар /Нотариатаар баталгаажуулсан байх/
- Бүрэн дунд боловсролын үнэмлэх /Эхээр нь/
- Их, дээд сургуулийн диплом /Эхээр нь/
- Эрүүл мэндийн бичиг зэрэг материалыг бүрдүүлнэ.
- Шаардлагатай бичиг баримтыг монгол хэл дээр баталгаат орчуулга хийлгэсэн байна.
- Монгол хэлний шалгалт өгч тэнцсэн байх
- Оршин суух газрын хаяг, түрээсийн гэрээ
- Сургалтын төлбөр төлсөн баримт
- Суралцахыг хүсэгч гадаадын иргэн элсэн суралцах тухай өргөдлөө англи эсвэл монгол хэл дээр бичиж материалыг хавсаргаж сургалтын албанд бүртгүүлнэ.

***Шинээр элссэн магистрантуудын хувьд:***

- **Сургалтын алба** анхны долоо хоногт сургалтын бүтэц, төлөвлөгөө, хичээлийн хуваарь, багш нарын талаарх танилцуулгыг хийдэг.
- “WeChat” групп болон цахим платформоор улирал тутам мэдээлэл тогтмол өгдөг.
- Гадаад магистрантад зориулсан **гарын авлага, нэмэлт сургалт, хэлний дэмжлэг** үзүүлдэг зохицуулалт үйлчилж байна.

Ийнхүү ҮБТДС нь магистрын хөтөлбөрийн элсэлтийг эрх зүй, мэргэжлийн шаардлагад нийцүүлэн ил тод, шударга, үр дүнтэй хэрэгжүүлж байна.

### 2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

*Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх, болон багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

***Магистрантын суралцах хугацааны төлөвлөлт***

ҮБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөр нь суралцагчийн танхимын болон бие даасан сургалтын ачааллыг зохистой, жигд байлгахад чиглэсэн бүтэцтэйгээр хэрэгждэг. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд нь “Магистрын сургалтын журам” (ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 19 тоот тушаал )-ын 7.2.2, -р заалтын 1-р хүснэгтээр судалгааны магистр, 2-р хүснэгтээр мэргэжлийн магистрын сургалтын төлөвлөгөөний багц цагийг хувиарлан тогтоосон бөгөөд суралцахуйн үр дүнд чиглэсэн боловсруулалттай байна. Сургалтын төлөвлөгөөнд нэг улиралд 15 хүртэл багц цагтай хичээл сонгон суралцах боломжийг нээлттэй байлгаж, өдөрт 4–6 академик цагийн сургалтад хамрагдах хуваарь гаргасан нь суралцагчийн хэт ачаалалд өртөхөөс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Суралцахуйн ачаалал нь танхимын сургалт 36%, бие даан судлах 64%-ийн харьцаатайгаар төлөвлөгддөг. Ийнхүү бие даан суралцах хугацаа давамгайлсан бүтэц нь магистрантад судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний арга барилд суралцах, асуудлыг бие даан шийдвэрлэх чадамж эзэмших нөхцөлийг бүрдүүлдэг.

ҮБТДС-ийн магистрын сургалтын хөтөлбөр нь суралцагчийн танхимын болон бие даасан сургалтын ачааллыг жигд, зохистой байлгах зарчимд тулгуурлан хэрэгждэг. Сургалтын хуваарь нь улирал тутамд багц цагийн дээд хязгаар, өдөр тутмын хичээллэх хугацаа, судалгааны ажилд хуваарилагдах цаг зэрэг зохистой харьцаанд суурилдаг.

Хүснэгт 2.2 Суралцахуйн ачааллын зохицуулалтын бүтэц

| Үзүүлэлт | Хэмжээ, бүтэц | Тайлбар |
|---|---|---|
| Улиралд судлах нийт багц цаг | Хамгийн ихдээ 15 кр | Суралцагчийн ачааллыг хэт нэмэгдүүлэхгүй байхад чиглэнэ |
| Өдөрт хичээллэх цаг | 4–6 академик цаг | Илүү үр дүнтэй суралцах нөхцөл бүрдүүлдэг |
| Танхимын сургалтын хувь | 36% | Суурь мэдлэг эзэмших, зааварчилга авах |
| Бие даасан судалгааны хувь | 64% | Шинжлэх ухааны судалгаа, практик хэрэглээнд чиглэнэ |

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан танхим болон бие даалтын цагийн зохицуулалт нь суралцагчийн суралцахуйн үндсэн орон зайг судалгаанд чиглүүлэх,

бие даан ажиллах чадварыг төлөвшүүлэх зорилготой. “Магистрын сургалтын журам”, “ҮБТДС-д оюутан элсүүлэх журам” -ын дагуу энэхүү бүтэц баталгаажсан.

Мөн магистрант бүр удирдагч багштай хамтран улирал тутам 'Суралцах төлөвлөгөө' боловсруулж, судалгааны ажлын явцыг баримтжуулан хянаж байдаг нь суралцахуйн ачааллыг тэнцвэртэй, үр дүнтэй хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог.

Өнгөрсөн хугацаанд “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын төлөвлөгөө 5 удаа шинэчлэгдсэнийг 2.3-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2.3 Магистрын сургалтын төлөвлөгөө

| № | Батлагдсан огноо | Мэргэжлийн индекс | Нийт кредит | Хичээлийн эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мэргэжлийн суурь | Мэргэших | Сонгосон судалгааны ажлын арга зүй з/б/сонгох/ | Магистрын дипломын ажил |
| 1 | 2002.06.15 | E148105 | 34 | 14/41.2% | 10/29.4% | 3/8.8% | 7/20.59% |
| 2 | 2013.09.15 | E143700 | 34 | 14/41.2% | 10/29.4% | 3/8.8% | 7/20.59% |
| 3 | 2017.06.15 | E01110101 | 30 | 11/36.7% | 11/36.7% | 3/10% | 5/16.7% |
| 4 | 2022.05.09 | E01110101 | 30 | 10/29.5% | 12/35.3% | 7/20.5% | 5/14.7% |
| 5 | 2025.04.02 | E011438 - судалгааны | 32 | 12/37.59 | 11/34,4% | 4/12,51% | 5/15,6% |
| | | E011438-мэргэжлийн | 32 | 12/37.59 | 15/46,9% | 5/15,6% | 0 |

Магистрын сургалт нь 30, 34 кредит байснаа сүүлийн жилүүдэд БШУ-ны сайдын 2024 оны 03 сарын 20-ны А/147 тоот тушаалын үндэслэн, Захирлын ҮБТДС-ийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 19 тоот тушаалаар батлагдсан шинэ хөтөлбөрөөр 32 кредит болон өөрчлөгдсөн байна. Энэ нь мэргэжлийн чиглэлээр онол, арга зүйн мэдлэгээ хөгжүүлэх, судалгааны арга барилд сурахад чухал ач холбогдолтой болсон.

Хүснэгт 2.4 "Биеийн тамирын боловсрол"-ын хөтөлбөрийн БШУ-ны сайдын А/147-р тушаалын дагуу шинэчилсэн төлөвлөгөөний харьцуулалт

| № | Хичээлийн нэр | Хичээлийн код | Хичээлийн хэлбэр | Багц цаг | % | № | Хичээлийн нэр | Хичээлийн код | Хичээлийн хэлбэр | Багц цаг, кр | % | Ялгаа | ДҮГНЭЛТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Биеийн тамирын боловсролын хуучин хөтөлбөрийн төлөвлөгөө | | | | | | Биеийн тамирын боловсролын хуучин хөтөлбөрийн төлөвлөгөө | | | | | | | |
| А. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ | | | | 10 | 33.3 | А. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ | | | | 12 | 37.5 | 4.2 | |
| Заавал судлах | | | | | | Заавал судлах | | | | 9 | 28.1 | | 1. Мэргэжлийн суурь хичээлийн эзлэх хувийн жин 4.2%-р нэмэгдсэн 2. "Хуучин" хөтөлбөрт зөвхөн "заавал судлах" хичээлтэй байсан бол "шинэ" хөтөлбөрт "Сонгон судлах" хичээл 2-р нэмэгдсэн. |
| 1 | Шинжлэх ухааны судалгааны арга зүй | N.SCM-700 | 2:1:1:0 | 2 | | 1 | Шинжлэх ухааны судалгааны арга зүй | N.SCM-700 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| 2 | Биеийн тамирын шинжлэх ухааны онол, арга зүй | N.TMS-701 | 3:2:1:0 | 3 | | 2 | Биеийн тамирын боловсролын менежмент | N.MPE-706 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| 3 | Боловсрол судлалын үндэс | N.PES-702 | 3:2:1:0 | 3 | | 3 | Боловсрол судлалын үндэс | N.PES-702 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| 4 | Бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн боловсрол | N.REP-704 | 2:1:1:0 | 2 | | Сонгон судлах | | | | 3 | 9.4 | 9.4 | |
| Сонгон судлах | | | | 0 | 0 | 4 | Боловсролын фипософи | N.EPH-705 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| 5 | | | | | | 5 | Биеийн тамир спортын хэмжил зүй | N.SMT-709 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| Б. МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛ | | | | 12 | 40 | Б. МЭРГЭШИХ ХИЧЭЭЛ | | | | 11 | 34.4 | -5.6 | Мэргэших хичээлийн эзлэх хувь 5.6%-р буурсан |
| 1 | Боловсролын фипософи | N.EPH-705 | 3:2:1:0 | 3 | | 1 | Эрүүл мэндийн боловсрол | N.EPH-704 | 1:0:2:2(5) | 3 | | | |
| 2 | Биеийн тамирын боловсролын менежмент | N.MPE-706 | 2:1:1:0 | 2 | | 2 | Биеийн тамирын судалгааны онол, | N.TMR-701 | 1:0:2:2 (5) | 3 | | | |
| 3 | Багш, биеийн тамирын боловсролын сэтгэл зүйн | N.PPE-707 | 3:2:1:0 | 3 | | 3 | Биеийн тамир спортын сэтгэл | N.PPE-707 | 2:2:0:0 (5) | 3 | | | |
| 4 | Биеийн тамирын боловсролын онол, арга | N.TPE-708 | 4:3:1:0 | 4 | | 4 | Биеийн тамирын онол арга зүй | N.TPE-708 | 2:0:0:0 (3) | 2 | | | |
| В. МАГИСТРЫН ТӨГСӨЛТИЙН АЖИЛ | | | | *8* | 26.7 | В. МАГИСТРЫН ТӨГСӨЛТИЙН АЖИЛ | | | | 9 | 28.1 | 1.5 | |
| 5 | Магистрын судалгааны ажлын арга зүй зохион байгуулалт | N.RSC-710 | | 3 | | 5 | Эрдэм шинжилгээ, судалгаа | N.RSC-710 | | 4 | | 1 | Магистрантын эрдэм шинжилгээ |
| 6 | Магистрын төгсөлтийн ажил | N.DMD-711 | | 5 | | 6 | Магистрын төгсөлтийн ажил | N.DMD-711 | | 5 | | 0 | |
| | Нийт | | | 30 | 100 | Дүн | | | | 32 | 100 | 2 | Нийт багц цаг 2 Кредитээр |

"Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрөөр магистрантурт суралцагч нь өдрөөр 1,5 жил суралцана. Энэ тайланд хамаарах хугацаанд буюу 2024-2025 он онд мөрдөж ирсэн сургалтын төлөвлөгөөгөөр мэргэжлийн суурь хичээл 12 кр, мэргэшүүлэх хичээл 11 кр, магистрын ажил 9 кр, нийт 32 кр цагийн хичээлийг судалж байна.

Энэ нь суралцагчтай болон багш нартай хэлэлцүүлэг зохион байгуулж, магистрын сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь болон мэргэшүүлэх хичээлийг өөрчлөн сайжруулсан.

Хүснэгт 2.5 "Биеийн тамирын боловсрол" судалгааны магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц

| Багцын нэр | Нийт кредит | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Заавал судлах | | Сонгон судлах | |
| | Кредит | Хувь | Кредит | Хувь | Кредит | Хувь |
| Мэргэжлийн суурь | 12 | 37,5 | 9 | 28,1 | 3 | 9,4 |
| Мэргэших | 11 | 34,4 | 11 | 34,4 | | |
| Эрдэм шинжилгээ, судалгаа | 4 | 12,5 | | | 4 | 12,5 |
| Магистрын ажил | 5 | 15,6 | | | 5 | 15,6 |
| **Нийт** | **32** | **100** | **20** | **62,5** | **12** | **37,5** |

Хүснэгт 2.6 "Биеийн тамирын боловсрол" мэргэжлийн магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц

| | Нийт кредит | Үүнээс | |
|---|---|---|---|
| | | Заавал судлах | Сонгон судлах |

| Багцын нэр | Кредит | Хувь | Кредит | Хувь | Кредит | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Мэргэжлийн суурь хичээл | 12 | 37,5 | 9 | 28,1 | 3 | 9,4 |
| Мэргэших хичээл | 15 | 46,9 | 15 | 46,9 | | |
| Сонгосон спортын төрлөөр дадлагын хичээл | 5 | 15,6 | | | 5 | 15,6 |
| **Нийт** | **32** | **100** | **24** | **75** | **8** | **25** |

БШУЯ-ны сайдын А/147 дугаар тушаалын 2.5.1.35-д (2024) "ахисан түвшний сургалтын төлөвлөгөөний агуулга, багц цаг" хуваарилагдан батлагдсан судалгааны магистрын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад мэргэжлийн суурь хичээл нийт 12 багц цаг, мэргэших хичээл 9 багц цаг, эрдэм шинжилгээ, судалгаа 4 багц цаг, магистрын төгсөлтийн ажил 5 байхаар заасан бол мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад мэргэжлийн суурь хичээл нийт 12 багц цаг, мэргэших хичээл 15 багц цаг, мэргэжлийн дадлага 5 багц цаг байхаар тус тус заасан. Энэхүү судалгааны болон мэргэжлийн сургалтын төлөвлөгөө нь уг шаардлагад нийцэж байгаа нь дээрх хүснэгтээс харагдлаа.

Магистрантын суралцах хугацааг энэ жишгээр төлөвлөх нь суралцагсдад хэт ачаалал үүсэхгүй, улирал бүрд жигд ачаалалтай байх нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн магистрантад санал болгосон сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийг аль ч улиралд сонгон судлах боломжтой. Магистрант өөрийн эрхэлдэг ажлын ачаалалд тохируулан хичээл сонголтоо хийх нөхцөл бүрддэг.

***Хөтөлбөрт элссэн магистрантууд зохих хугацаанд төгсдөг байдал***

Хөтөлбөрийн сургалтад элссэн ихэнх магистрантууд сургалтын хугацаандаа төгсөж байгааг хүснэгт 2.1-ээс харж болно.Тэдний 15-20%-нь суралцах хугацаагаа хойшлуулж байна. Үүний шалтгаан нь:

- Хөдөлмөр олгогчоос магистрантыг дэмжиж ажлын зохицуулалт хийж өгдөггүй, амьдралын боломж, сургалтын төлбөрийн асуудал
- Гадаадын магистрантуудыг хувьд ажлаасаа чөлөө авч чадахгүй байдал, визийн асуудал зэргээс шалтгаалан сургалтын хугацаагаа хойшлуулдаг байна. Харин сургалтын үйл явц, сурлагын үнэлгээнээс хамаарч зохих хугацаандаа төгсөөгүй магистрант өнөөгийн байдлаар байхгүй байна.

### 2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

*Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд нь тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.*

ҮБТДС-ийн магистрын хөтөлбөр нь суралцагч төвтэй, судалгаанд суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлж буйгаараа онцлог. Сургалтын үйл ажиллагаа нь суралцагчийн бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэлгээг хөгжүүлэх, мэргэжлийн судалгааны арга барилд суралцах, асуудал шийдвэрлэх чадамж төлөвшүүлэхэд чиглэсэн байдаг.

Хичээл заадаг багш нарын дунд 2023 онд явуулсан арга зүйн судалгаанд нийт 15 төрлийн сургалтын арга хэрэглэж буйг тогтоосон бөгөөд багш нарын 80% нь суралцахуйн үр дүнд чиглэсэн бүтээлч, идэвхтэй арга зүйг сонгон хэрэглэдэг байна. Тухайлбал, кейс анализ, багийн ажил, тайлбарт лекц, задлан шинжлэх, асуудал

шийдвэрлэх, асуулт хариулт, загварчлал, практик даалгавар, нээлттэй хэлэлцүүлэг зэрэг арга барилыг өргөн хэрэглэдэг.

Сургалтын арга зүйг дараах үндэслэлтэйгээр хэрэгжүүлдэг:

- Судалгаанд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилгоор "ШУ - ны судалгааны онол арга зүй', "Биеийн тамирын судалгааны арга зүй" зэрэг хичээлүүдээр удирдамж өгөх
- Хичээлийн төлөвлөлт, үнэлгээ нь суралцагчийн оролцоонд суурилсан, үйлдлээр сурах боломжийг хангасан байх
- Төслийн ажил, кейс даалгавар, хээрийн судалгаа зэрэг бодит практикт суурилсан арга зүйг түлхүү ашиглах
- Суралцагчийн сонирхол, мэргэжлийн хэрэгцээнд нийцсэн бие даалтын ажлыг түлхүү хөгжүүлэх
- Цахим сургалтын платформ, интерактив хэрэглэгдэхүүнийг ашиглан олон төрлийн арга хэлбэрээр хичээл заах

ҮБТДС нь ОХУ, Япон, БНСУ зэрэг орнуудын магистрын сургалтын хөтөлбөрийн арга зүйг харьцуулан судалж, багш нарт зориулсан дотоод арга зүйн зөвлөмж боловсруулсан. Сургалтын арга зүйн удирдамж нь ҮБТДС-ийн “Магистрын сургалтын журам” (2025 оны 04 сарын 02-ны 19 тоот тушаал)-ын 7.2.3-р зүйлд нийцсэн бөгөөд хичээлийн үр дүн, судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулж, суралцагчийг судлаач мэргэжилтнээр бэлтгэх боломжийг бүрдүүлдэг.

***Багшлахуй ба суралцахуйн арга зүйг тусгасан баримт бичиг, зөвлөмж***

“Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй, сургалтын таатай орчныг бүрдүүлсэн, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн байх нь чухал юм. Магистрын сургалтын арга зүйг тусгайлан боловсруулсан баримт бичиг гаргаагүй ч Хөтөлбөрийн хороо, Хөтөлбөрийн дэд хороо, ОАЗ-н тэнхимтэй хамтран сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт, семинарыг 2022-2023 онд 4 удаа зохион байгуулж сургалтын арга зүйн зөвлөмж өгч, лекц, семинарын хичээлийн арга зүйг боловсруулах жишиг загвар гаргаж магистрын сургалтад ашиглаж байна.

Сургуулийн профессорын багаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг эзэмшихэд тохирох сургалтын арга зүйг хэлэлцүүлэн багш бүр өөрийн арга зүйн туршлага, орчин үеийн судалгаа шинжилгээний ажлын чиг хандлагад багшлахуйн болон суралцахуйн арга зүйд орж буй өөрчлөлтийн талаар дүгнэн ярилцаж, хичээл бүрийнхээ арга зүйг сайжруулсан. Түүнчлэн тус сургуулийн хөтөлбөрийн хороо, дэд хороодоос арга зүйн зөвлөмжийг тогтмол хэвлэн өгч, тодорхой бүтээлч аргуудыг хөтөлбөрөө боловсруулахад болон хэрэгжүүлэхдээ ашиглаж байгаа нь магистрантуудын суралцах үйлийг идэвхжүүлж, бүтээлчээр суралцахад нь үнэтэй дэмжлэг болж байна.

***Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад нөлөөлж чаддаг эсэх***

Сургалтын явцад магистрант нэг бүрийн хөгжих боломжийг дэмжиж, тэдний бүтээлч хандлага, мэргэжлийн сэдэл тэмүүллийг өдөөх идэвхтэй сургалтын арга, хэлбэрээр сургалтыг зохион байгуулахад багш нар анхаарч ирсэн. Хөтөлбөрийн МИҮЗ-өөс гаргасан удирдамж, шалгууруудыг үндэслэн багш бүрийн хичээлийн хөтөлбөрийг тэнхимээр хэлэлцэн улмаар хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн багаар дахин хэлэлцэн баталж, мөрдөн хэрэгжүүлдэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх

явцад багш нарын ашиглаж буй арга зүйн жишээ болгон дараах асуудлуудыг авч үзье. Тухайлбал:

- Магистрантуудын бүтээлч даалгаврын аргаар гүйцэтгэсэн бүтээлийг хэлэлцэх
- Тодорхой асуудлаар “Асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх” хэлэлцүүлэг хийх
- Тайлбарт лекцийн аргаар бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
- Нээлттэй хэлэлцүүлэг хийх г.м болно.

“Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрт хичээл тус бүрээр магистрантууд мэдлэг бүтээх, чадвараа ашиглаж сургахад чиглэсэн арга зүйг ашиглаж байна.

***Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа хийж сайжруулдаг байдал***

Магистрантуудад хичээл заадаг докторын зэрэгтэй багш нарын дунд арга зүйн судалгааг явуулсан. Энэ судалгаагаар багш нарын хэрэглэж буй сургалтын аргууд болоод судалгааны ажлыг удирдах арга зүйгээ хэрхэн сонгон хэрэгжүүлж байгааг тодорхойлсон юм.

Хүснэгт 2.7 Сургалтын арга зүйн сонголтын судалгааны үзүүлэлт

| Багш нарын сургалтад хэрэглэж буй аргууд | Сургалтын арга зүйгээ зөв сонгон хөгжүүлж буй байдал | Магистрын судалгааны ажлыг удирдах арга, барилаа хөгжүүлж байгаа байдал |
|---|---|---|
| - Асуудал дэвшүүлж, шийдвэрлэх арга<br>- Хурлын арга<br>- Хэлэлцүүлэг<br>- Ялгаатай байдлыг оношлох арга<br>- Загварчилсан тэмдэглэл хөтлөх арга<br>- Тайлбарт лекцийн арга<br>- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга<br>- Задлан шинжлэх, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх арга<br>- Үр дүнд суурилсан сургалтын аргууд<br>- Багаар хамтран ажиллах арга<br>- Практик даалгавар гүйцэтгэх арга<br>- Эвлүүлгийн арга<br>- Баримтуудыг дэс дараалалд оруулах арга | - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ажиглалт хийж арга зүйгээ өөрчлөх<br>- Сургалт, семинарт оролцох<br>- Сургалтын арга зүйн чиглэлийн төсөлт ажилд оролцох<br>- Урьдчилан бэлтгэл хангуулж магистрантаар хичээл заалгах<br>- Магистрантын сонирхолд нийцсэн даалгавар дээр ажиллуулах<br>- Багш нарын хичээлд оролцон сууж, туршлага судалж, санал солилцох<br>- Сургалтын арга зүйн талаар судлах<br>- Цахим сургалтын арга зүйн талаар гүнзгийрүүлэн судлах<br>- Хичээлийн агуулгад холбогдох ухагдахуун, нэр | - Судалгааны явцад ажиглалт хийж, зааварчилгаа, чиглүүлгийн арга барилаа шинэчилж байдаг.<br>- Судалгааны арга зүй, эрдмийн бичгийн чиглэлийн сургалт, семинарт оролцож мэргэжлээ хөгжүүлдэг.<br>- Бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой сургалт-судалгааны төсөл, хэлэлцүүлэгт оролцдог.<br>- Судалгааны чиглэлтэй уялдсан хичээлийг заалгах, танилцуулах боломжийг олгодог.<br>- Судалгааны сэдэв, арга зүйг эзэмшүүлэхэд хувь хүний сонирхолд нийцүүлсэн бүтээлч даалгавар өгдөг<br>- Багш нар хоорондоо судалгааны удирдлагын арга барилын туршлагаа солилцдог.<br>- Судалгааны өгөгдөл боловсруулах |

| | | |
|---|---|---|
| - Ажиглалт, туршилтын арга<br>- Харилцан ярилцлага<br>- Танилцуулах арга<br>- Туршилт хийх<br>- Цахим сургалтын арга | томьёо,тодорхойлолт нэршлийг танил болгон хэвшүүлэх тал дээр даалгавар түлхүү өгч ажиллах | платформ, бичгийн хэрэгслүүдийг зааж сургадаг.<br>- Судалгааны үндсэн ойлголт, тодорхойлолт, нэршлийг стандартчлан хэвшүүлэхэд анхаардаг. |

Магистрын сургалтад ашиглаж буй арга зүй нь хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагад (CLO) чиглэдэг болох нь судалгаанд хамрагдсан багш нарын 80%-ийн хариултаас харагдаж байсан бол тэдний 20%-нь хичээлийн агуулгыг эзэмшүүлэхэд чиглэсэн арга зүйг голлон хэрэглэж байна. Ийнхүү хичээлийн агуулгад тулгуурласан арга зүйг ашиглах нь гадаад магистрантуудад хичээлийн агуулгыг ойлгуулахын тулд ихэвчлэн уламжлалт лекц, тайлбар яриа, харилцан ярианы аргуудыг хэрэглэж байгаатай холбоотой юм. Судалгаанаас үзвэл багш нар Багшийн хөгжил төв, МИҮЗ болон Сургалтын албанаас зохион байгуулсан арга зүйн богино хугацааны сургалтад хамрагдан оролцож арга зүйн чадвараа сайжруулсаар байна.

***Магистрын сургалтад хэрэглэж буй арга зүйн сайн туршлагаас***

ҮБТДС-нь Оросын Холбооны Улсын Москва хотын Орос Улсын Биеийн тамир, Спорт, Аялал жуулчлалын Их сургуулийн магистрантурын 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын арга зүйн зөвлөмжүүдийг судлан магистрын сургалтад хичээл заадаг багш нартаа зөвлөмж боловсруулан өгч сургалтын ажлаа зохион байгуулахад арга зүйн хангалт хийж, зөвлөн дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал: Дараах арга зүйн зөвлөмжийн агуулгыг товчхон танилцуулж байна.

**Заах арга зүйн зөвлөмж**

- Тухайн төрөл хичээлийн заах аргын онцлог болон аргыг сонгох дидактикийн шаардлагуудаас хамааруулж,
- Тодорхой хичээлийн зорилго, зорилтууд болон эзэмших

**Заах арга, барил**

**Заах арга:** Сургалтын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн багш болон оюутнуудын хамтын үйл ажиллагаа юм. Заах аргад багшлахуй ба суралцахуйн арга багтана.

**Сурган хүмүүжүүлэх барил:** Багш хүний төрөлхийн оюун ухааны авьяасын тулгуурласан онцлог бүхий аргын нэг хувилбар юм. Орчин үеийн дидактикийн шинжлэх ухааны заах аргын ангилал:

- Тайлбар, ярианы арга
- Үзүүлэн таниулах арга
- Практик дасгалын арга
- Асуудал дэвшүүлж, шийдвэрлэх арга
- Хэсэгчилсэн эрэл хайгуулын арга
- Сургалт-судалгааны арга

**Заах аргын сонголт**

Орчин үеийн СХУ-ны практик туршлагыг нэгтгэн дүгнэж үзвэл багш нар нь сурган хүмүүжүүлэх үйл явцын тодорхой нөхцөл, байдлаас хамааруулж заах аргаа сонгох оролдлогуудыг хийдэг. Тухайлбал заах аргын сонголт нь:

- Орчин үеийн дидактикийн хөтлөх чиглэл болон оюутны хөгжил, боловсрол, хүмүүжлийн ерөнхий зорилгоос хамааруулж,
- Судалж буй зүйлийн онцлогоос хамааруулж,
- материалын агуулгаас хамааруулж,
- Тухайн материалыг эзэмших тогтоогдсон хугацаанаас
- Оюутнуудын нас, хүйсийн онцлогоос
- Оюутны хөгжил, бэлтгэлжилтийн түвшнөөс
- Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материаллаг хангалтын байдлаас хамааруулж
- Багш-хувь хүний онцлог, арга зүйн ур чадвар, онол-арга зүйн бэлтгэлжилт зэргийг тус тус харгалзан үзэж оюутнуудад чанартай боловсрол олгох, оюун санааны болон бүтээлч чадварыг хөгжүүлэх дэвшилтэт заах аргыг сонгон авахад багш анхаарах нь зүйтэй.

**2.4 Судалгааны ажил**

*Магистрант, удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.*

ҮБТДС-ийн магистрын хөтөлбөрийн хүрээнд судалгааны ажил нь суралцагчийн мэргэжлийн гүнзгий мэдлэг, судалгааны арга зүй, бие даасан шинжилгээ хийх чадамжийг төлөвшүүлэх гол хөшүүрэг болдог. Судалгааны ажил нь хичээлийн төлөвлөгөөний 30–40 хувийг эзэлдэг бөгөөд дараах бүтэц, шат дарааллын дагуу хэрэгждэг:

Судалгааны ажлын үндсэн үе шат:

- Судалгааны асуудал тодорхойлох, онолын суурьтай уялдуулах
- Судалгааны төлөвлөгөө боловсруулах, удирдагчтай зөвшилцөх
- Ёс зүйн зөвшөөрөл авах, урьдчилсан хамгаалалт хийх
- Судалгаа хэрэгжүүлж, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх
- Бичгийн бүтэц, эрдмийн шаардлагад нийцүүлэн диссертаци боловсруулах
- Хамгаалалтад оруулахын өмнөх урьдчилсан рецензи, илтгэл, баталгаажуулалт

Судалгааны ажлын хэрэгжилт, удирдлагын тогтолцоо нь 'Магистрын сургалтын журам' Сургалт-судалгааны бүтээлийн удирдамж', 'Шүүмж, магистр хамгаалалтын журам', 'Эрдмийн ёс зүйн дүрэм' зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан шаардлагын дагуу явагддаг. Судалгааны явцад дараах дэмжлэг, хяналтыг хэрэгжүүлдэг:

Судалгааны ажлыг дэмжих тогтолцооны жишээ:

- Удирдагч багшийн улирлын төлөвлөгөөт зөвлөлгөө, уулзалтууд
- Судалгааны арга зүй, эрдмийн бичгийн сургалт, гарын авлага
- Дотоод хамгаалалт, рецензи үнэлгээ, хяналтын шат
- Судалгаанд шаардлагатай тоног төхөөрөмж, лабораторийн орчин
- Судалгааны санхүүжилтийн тодорхой боломж (тэтгэлэг, төсөл)

Судалгааны ажлыг удирдах, хэрэгжүүлэх арга барил нь суралцагчийн судалгааны сонирхол, мэргэшлийн чиглэл, боловсруулж буй асуудлын шинжлэх ухаанч чанарт нийцсэн, хариуцлагатай, тогтвортой хандлагаар хэрэгждэг бөгөөд хөгжлийн тасралтгүй дэмжлэг үзүүлдэг тогтолцоотой.

***Судалгааны сэдэв, удирдагч багшийг сонгох үйл ажиллагаа нээлттэй ил тод байна.***

Магистрант судалгааны ажлынхаа сэдвийг сонгохдоо дараах асуудалд анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Магистрант өөрөө тулгамдаж буй асуудлаа тодорхойлоод эхний байдлаар сэдвээ тогтооно.
2. Магистрын судалгааны зарлагдсан сэдвээс сонгох гэсэн хоёр хэлбэрийг ашиглаж байна.

Сүүлийн 5 жилийн практикаас ажиглахад магистр хамгаалсан суралцагсдын 70% нь 1 дүгээр хэлбэрээр сэдвээ сонгосон бол 30% нь багш нарын санал болгосон сэдвээр магистрын судалгааны ажлаа хийсэн байна. Магистрант өөрөө сэдвээ сонгох нь илүү үр дүнтэй байдаг. Суралцагч судалгааны сэдвээ тодорхой болгосны дараа тухайн сэдвийн багшийн удирдсан магистрын ажлууд, судалгааны бүтээлүүдтэй танилцах үүргийг суралцагчид өгнө. Дараа нь магистрантын сонгосон багшид сэдвийг танилцуулж, багш зөвшөөрвөл хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн захирлын тушаал гаргуулахаар хөтөлбөрийн албанд өгнө. Судалгааны ажлын сэдэв ба удирдагчийг баталсан ҮБТДС-ийн захирлын тушаал гарна. Судалгааны ажлын удирдагч багшийг сонгох боломжийг нээлттэй, ил тод байлгахын тулд багш нарын судалгааны ажлын чиглэл, бүтээлүүдийн танилцуулгыг байршуулсан байна. Магистрант судалгааны сэдвээ өөрөө тодорхойлсны дараа багштайгаа зөвшилцөн, хөтөлбөрийн албанд бүртгүүлж, захирлын тушаалаар албан ёсоор баталгаажуулдаг. Жишээлбэл, 2023 оны хаврын элсэлтийн судалгааны сэдвүүдийг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08 тоот тушаалаар баталсан болно.

***Санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.***

Магистрын сургалтын төлбөрийн хэмжээг ҮБТДС-ийн удирдах зөвлөлөөр хэлэлцэн тогтоодог. Одоогийн мөрдөж буй сургалтын төлбөрийг сургуулийн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн хурлын тогтоолоор батлан мөрдөж байна. Суралцагч сургалтын төлбөрийн талаарх мэдээллийг оюутны вебээс авах бүрэн боломжтой. Түүнчлэн сургалтын журамд заасны дагуу зохих шаардлагыг хангасан суралцагчдад дараах сургалтын тэтгэлгийг олгоно. Тухайлбал: ҮБТДС-ийн магистрын зэргээр 3,7-оос дээш голчтой төгссөн төгсөгчдөд сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно. Мөн хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагын багш, ажилчдад сургалтын төлбөрийн 15%-20%-ийн тэтгэлэг олгоно. Магистрын судалгааны ажлын удирдагч, шүүмжлэгч багшийн ажлын хөлсийг дээрх журамд зааснаар олгоно.

***Магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлэх үйл явцыг тодорхойлсон байдал***

Магистрант судалгааны сэдвээ сонгосны дараа Магистрын зөвлөл хуралдан магистрантын судалгааны сэдэв болон сэдэвт ажлыг удирдахаар санал болгосон багш нарыг танилцуулж, хэлэлцэн магистрантын сэдэв болон удирдагчийг батлах сургуулийн захирлын тушаалыг гаргуулах саналыг хөтөлбөрийн албанд хүргүүлж тушаал гарна. Үүнээс хойш магистрын судалгааны ажлын гүйцэтгэлд удирдагч

багшийн харьяалагддаг тэнхим хяналт тавин ажиллана.Тухайлбал: 2024-2025 оны магистрантуудын явцыг хянаж, зөвлөн туслах ажлын хуваарийг үзүүлэв

Хүснэгт 2.8 Магистрын судалгааны ажлын явцыг хянах, зөвлөх ажлын хуваарь

| Удирдагч багш | Магистрын ажлын тоо | Зөвлөгөө өгөх багш | Хийх ажлууд | Хугацаа |
|---|---|---|---|---|
| Л.Алтанцэцэг | 5 | Л.Алтанцэцэг | -Бүтцийн төлөвлөгөө гаргах<br>-Судалгааны арга зүй боловсруулах<br>-Объект, субъектээ тогтоох<br>-Ажлын төлөвлөгөө гаргах | 2025 оны 6 сарын 15 |
| Л.Гүндэгмаа | 5 | Л.Гүндэгмаа | | |
| Ц.Оюунбат | 5 | Ц.Оюунбат | | |
| Р.Ганбаатар | 5 | Р.Ганбаатар | | |
| С.Зоригт | 5 | С.Зоригт | | |
| Ш.Бат-Эрдэнэ | 3 | Ш.Бат-Эрдэнэ | | |
| Г.Эрдэнэбаатар | 3 | Г.Эрдэнэбаатар | | |

Магистрын судалгааны ажлын удирдагч багш нар нь горилогчийн судалгааны арга зүйг хамтран боловсруулах, судалгаа авах объектыг тодорхойлж өгөх, судалгааг авахад биечлэн туслах зэргээр хамран ажиллаж ирсэн. Судалгааны явцын үр дүнгээр оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, тэнхимийн семинарт танилцуулга хийх зэрэг нь магистрантуудын судалгааны ажлын гүйцэтгэлийг идэвхжүүлэх нэг хэлбэр болсон. Судалгааны ажлын явцын үр дүнгээ тэнхмээр хэлэлцүүлснээр магистрант 2 ийг тооцуулна. Судалгааны ажлыг тэнхмээр хэлэлцэхийн өмнө оюуны өмчийн бодлогод нийцүүлэн “хуулбарлалт” байгаа эсэхийг шалгах ажлыг 2019 оноос хийж эхэлсэн. Тогтоогдсон хэмжээнээс илүү “хуулбарлалт” илэрвэл заавал засуулж байж тэнхимийн хурлаар оруулдаг. Магистрантын судалгааны ажлын явцыг ийнхүү хянаж, зөвлөн туслах, хэлэлцүүлэх ажлыг хийсний үр дүнд магистрантууд судалгааны ажлын үе шатаа бие даан тодорхойлох, төлөвлөх ба судалгааны аргуудыг зорилгодоо нийцүүлэн сонгон хэрэглэх чадварт ахиц гарсан байна. Сургалтын явцаас ажиглахад магистрантуудад чанарын шинжилгээний аргуудыг оновчтой ашиглаж сурахад анхаарч хөтөлбөрт нь тусгаж өгөх нь зүйтэй байна.

Хүснэгт 2.9 Магистрын ажил хамгаалсан тоо

| № | Онууд | Улирал | Биеийн тамирын боловсрол |
|---|---|---|---|
| 1 | 2019 | Өвөл | 14 |
| | | Хавар | 37 |
| 2 | 2020 | Өвөл | - |
| | | Хавар | 19 |
| 3 | 2021 | Өвөл | - |
| | | Хавар | 21 |
| 4 | 2022 | Өвөл | - |
| | | Хавар | 12 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | 2023 | Өвөл | 2 |
| | | Хавар | 9 |
| 6 | 2024 | Өвөл | - |
| | | Хавар | 11 |
| **Дүн** | | | **125** |

**2.5 Бүтээлч ажил**

*Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцож, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.*

***Суралцагч судалгааны ажлаараа эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн хэлэлцүүлэгт оролцох оролцоог хангадаг байдал***

ҮБТДС-ийн магистрын төгсөлтийн сургалтын журамд "Магистрантын судалгааны ажлын төлөвлөгөөт семинарт оролцсон, туршилт, судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний хурал, семинарт хэлэлцүүлсэн, ЭШ-ний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн зэргээр удирдагч үнэлж, тэнхим, профессорын баг баталгаажуулна" гэж заасан байдаг. Энэхүү хөтөлбөрөөр сурч байгаа магистрантууд нь өөрийн судалгааны ажлаар боловсрол судлалын болон БТС-ын чиглэлийн эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлдэг. Энэ нь магистрын судалгааны ажлын 1-2 ийг тооцуулах боломжийг олгодог. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн хугацаанд эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2.10 ҮБТДС-ийн магистрантуудын сүүлийн 5 жилийн эрдэм шинжилгээний бүтээл

| Магистрантын эрдэм шинжилгээний бүтээл | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Эрдэм шинжилгээний өгүүлэл | 7 | 6 | 8 | 7 | 28 |
| Эрдэм шинжилгээний хуралд оролцсон илтгэл | 4 | 3 | 5 | 5 | 17 |
| Нийт бүтээл | 11 | 9 | 13 | 12 | 45 |

***Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоог бүрдүүлж буй байдал***

Магистрын хөтөлбөрийн хүрээнд судалгааны болон бүтээлч ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх нь суралцагчийн судалгааны чадамж, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэдэг. "Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөр нь дараах чиглэлээр бүтээлч ажлын оролцоог дэмжиж, урамшуулж, үнэлэх тогтолцоотой. (Магистрын сургалтын журмын 7.2.2.1, 7.2.3.1.)

1. **Эрдэм шинжилгээ, судалгааны ажил**
   - Хичээл: Эрдэм шинжилгээ, судалгаа (4 кр)

- Зорилго: Судалгааны асуудал тодорхойлох, онол-практикийн үндэслэлтэй судалгаа гүйцэтгэх, үр дүнг тайлагнах чадамж эзэмших
- Хэрэгжих орчин: ҮБТДС-ийн профессорын багуудын удирдлага дор, спортын холбоо, ЕБС, лаборатори

**2. Магистрын төгсөлтийн ажил**

- Хичээл: Магистрын дипломын ажил (5 кр)
- Агуулга: Судалгааны үндэслэл, арга зүй, туршилтын зохион байгуулалт, үр дүнгийн шинжилгээ, санал дүгнэлт бүхий бүтээл бэлтгэх
- Хамтран ажиллах байгууллага: ЕБС, их дээд сургууль, хөдөлгөөн судлалын төвүүд

**3. Судалгааны туршилт, төсөлт ажил**

- Хэрэгжилт:
  - Судалгааны аргазүй, хэмжил зүйн хичээлээр төсөлт ажил хийх
  - Туршилтын судалгааг төлөвлөж, хэрэгжүүлэх
  - ҮБТДС-ийн профессорын багийн удирдлага дор хамтын судалгаанд оролцох
  - Хуралд оролцох, өгүүлэл хэвлүүлэх боломжийг бүрдүүлэх

**4. Дадлага сургалт (мэргэжлийн магистрт хамаарна)**

- “Шалгуур 2”-ын 2.5-д заасны магистрантын бүтээлч ажилд хурлын илтгэл, өгүүллийг үнэлэх кредитийн тогтолцоо үйлчилдэг

**5. Үнэлгээ ба урамшуулал**

- Олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд – 4 кр
- Дотоодын сэтгүүл – 2 кр
- Хурлын илтгэл – 2 кр
- Семинар, төсөл, туршилт – 1–2 кр

Энэхүү бүтэц, үнэлгээний систем нь магистрантын судалгааны ажлын чанар, оролцоог урамшуулах, түүнд суурилсан хөгжлийн чиг хандлагыг бий болгоход чиглэдэг.

### 2.6 Шалгуур 2 SWOT, TOWS шинжилгээ

| Давуу тал S | Сул тал W |
|---|---|
| **-Хууль зүйн болон эрх зүйн орчны бүрдүүлэлт**: Хөтөлбөрийн зохион байгуулалт нь холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу явагдаж байгаа.<br>**-Багшлах бүрэлдэхүүн**: Багш нарын мэргэжлийн өндөр түвшинд ажилладаг бөгөөд эрдэм шинжилгээний төсөл, хамтын ажиллагааг идэвхтэй дэмжиж байна.<br>**-Эрдэм шинжилгээний ажлын чанар**: Магистрантууд эрдэм шинжилгээний хурлууд болон мэргэжлийн семинаруудад идэвхтэй оролцож, судалгааны ажилд амжилттай оролцдог.<br>**-Гадаад хамтын ажиллагаа**: ОХУ, Япон, БНХАУ зэрэг орны судалгааны төвүүдтэй хамтран ажиллаж, олон улсын төсөлд оролцох боломжтой. | **-Гадаадын оюутны монгол хэлний бэлтгэл хомс**: Гадаад оюутнуудын монгол хэлний мэдлэг хангалтгүй байгаагаас тэдэнд сургалтын орчныг бүрдүүлэхэд бэрхшээл үүсэж байна.<br><br>**-Оюутны дэмжлэг ба ажлын зохицуулалт**: Зарим магистрантууд ажлын ачаалалтай, ажил олгогчоос дэмжлэг авахад хүндрэлтэй байдаг.<br><br>**-Суралцах хугацаа хойшлох**: Зарим магистрантуудын сургалтын хугацаа хойшилж байгаа нь төсвийн болон ажлын зохицуулалттай холбоотой. |

| | |
|---|---|
| -**Элсэгчдэд тавигдах шаардлага** ил тод, төгсөлтийн журмын дагуу хэрэгждэг. Элсэгчийн тоо нэмэгдэх хандлагатай. Суралцагч төвтэй сургалтын арга зүйд суурилсан. | - Элсэгчийн тоо нэмэгдэх нь багшийн ачааллыг ихэсгэнэ.<br><br>- Магистрын судалгааны ажлын төлөвлөгөө, явцын гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах шаардлагатай.<br><br>- Бүтээлч ажлыг тооцох, урамшуулах, үнэлэх тогтолцоог бүрдүүлэх |
| **Боломж О** | **Эрсдэл Т** |
| -**Дижитал шилжилт**: Онлайн болон хосолмол сургалтын аргуудыг ашиглан, олон улсын оюутнуудтай хамтран суралцах, сургалтын үйл явцыг сайжруулах боломжтой.<br>-**Олон улсын эрдэм шинжилгээний төсөл**: Олон улсын судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, магистрантуудад олон улсын судалгааны туршлага олгох.<br>-**Шинэчлэл ба инновац**: Судалгааны шинэ чиглэлүүд, шинжлэх ухаан, технологийн салбарт шинэчлэл хийж, магистрантуудыг илүү гүнзгий судалгааны ажлаар хангах боломж.<br>-**Бүтээлч ажлуудыг дэмжих**: Оюутнуудын бүтээлч ажлын оролцоог нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний хурлуудад оролцуулах. | -**Эдийн засгийн хүндрэл**: Хөтөлбөрийн санхүүжилт болон төсвийн хязгаарлалт нь хөтөлбөрийн чанар болон хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж магадгүй.<br><br>-**Орон нутгийн болон олон улсын өрсөлдөөн**: Биеийн тамир, спортын боловсролын салбарт олон нийтийн болон боловсролын байгууллагуудтай өрсөлдөх эрсдэл.<br><br>-**Гадаадын оюутнуудын бэрхшээл**: Монгол хэлний бэлтгэлийн дутагдал, визийн асуудал зэрэг гадаад магистрантуудын сургалтын орчинд хүндрэлтэй нөхцөлүүд.<br><br>-**Багш нарын шилжилт хөдөлгөөн**: Багш нарын тогтвортой байдлыг хангах шаардлагатай бөгөөд шилжилт хөдөлгөөн нь сургалтын чанарыг бууруулах эрсдэлтэй. |

### 2.7 Сайжруулах арга зам

- Магистрантурт элсэгчдийн тоо нэмэгдэж байгаатай уялдуулан судалгааны ажлын нарийвчилсан чиглэлээр залуу докторуудыг хөгжүүлэх, удирдагч багш нарын ачааллыг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх
- Магистрын судалгааны ажилд мэргэжлийн байгууллагуудын оролцоог өргөжүүлэх
- Судалгааны бүтээлүүдийг цахим хэлбэрээр үнэгүй судлах боломжийг эрж хайх, хэрэгжүүлэх
- Төсөлт ажилд магистрантуудын оролцоог өргөжүүлэх
- Хамтарсан судалгааны ажил болон туслах багшаар ажиллуулах арга замыг эрж хайх
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн судалгааг өргөжүүлэх, магистрын сургалтын арга зүйд гадаад орны туршлагыг нэвтрүүлэх

- Магистрын судалгааны ажлын төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог багш нарын оролцоотой бүрдүүлэх
- Судалгааны болон бүтээлч ажлыг тооцох, үр дүнг урамшуулах боломжийг сургалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулах.

**2.8 Үнэлгээ**

"Биеийн тамирын боловсрол" магистрын сургалтын "Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт" нь Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж БМИҮЗ-ийн шалгуураар баримжаалсан дараах үзүүлэлтийг боловсруулан үнэллээ.

Хүснэгт 2.11 Хөтөлбөрийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ

| Шалгуур | Үзүүлэлт | Хэмжээс | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|
| **2.1** | Элсэгчдэд тавих шаардлага ил тод, шударга байх, журмын дагуу хэрэгждэг байх | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг ханган тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг<br><br>**Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан<br><br>**Сайжруулах шаардлагатай:** Нэг үзүүлэлтийг хангасан<br><br>**Хангалтгүй:** Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | **Хангалттай сайн** |
| | Судалгааны сэдэв,удирдагч сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журамтай, тэр нь ил тод байх | | |
| **2.2** | Магистрантын суралцах ачааллыг тооцсон байх, тэнхимийн болоод бие даалтын ачаалал нь жигд, оновчтой байх | | **Хангалттай сайн** |
| | Магистрант зохих хугацаандаа төгсөж чаддаг байх | | |
| **2.3** | Багшлахуй, суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй байх. | | **Хангалттай** |
| | Сургалтын арга зүй нь магистрантад судалгааны арга, барилд сурах, мэргэжлийн ёс зүйг баримтлахад суралцах нөхцөлийг бүрдүүлсэн байх | | |
| **2.4** | Судалгааны ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байх | | **Хангалттай** |
| | Удирдагч багш нар судалгааны ажлыг удирдах ур чадвараа тасралтгүй хөгжүүлдэг байх | | |
| **2.5** | Магистрантуудын бүтээлч ажилд оролцох нөхцөлийг бүрдүүлсэн байх | | **Сайжруулах шаардлагатай** |
| | Бүтээлч ажлыг дэмжин урамшуулах үнэлэх, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | баталгаажуулах тогтолцоотой байх. | | |

### 2.9 Дүгнэлт

"Биеийн тамирын боловсрол" магистрын сургалтын "Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт"-д өөрийн үнэлгээ хийснээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Тус магистрын сургалтын хөтөлбөр нь УБТДС-ийн төгсөлтийн сургалтын журмын дагуу хэрэгжиж байна.
2. Магистрантын сурах ачааллыг тооцсон суралцагч төвтэй суралцахуйг хэрэгжүүлж байгаа нь давуу тал болж байна.
3. Магистрын судалгааны ажлыг биеийн тамирын боловсролын салбарт тулгамдаж буй асуудалд чиглүүлж байгаагийн зэрэгцээ удирдагч багш нар арга зүйгээ байнга хөгжүүлж байна.
4. ОХУ, Япон, БНХАУ зэрэг орны судалгааны төвүүдтэй хамтран ажиллаж, гадаад хамтын ажиллагааг ашиглан магистрантуудад олон улсын эрдэм шинжилгээний төсөлд оролцох боломж олгодог.
5. Магистрантур төгсөгчдийн судалгааны ажлын чанарыг дээшлүүлэхийн тулд магистрын судалгааны ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэх бүтээлч ажлыг урамшуулан дэмжих, үнэлэх, баталгаажуулах тогтолцоог бүрдүүлж,үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

## ШАЛГУУР 3. МАГИСТРАНТЫН СУРАЛЦАХУЙН ҮНЭЛГЭЭ, ХӨГЖИЛ

Хөтөлбөрөөр суралцагч суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөөлөн тусалдаг байна.

### 3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

*Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)- йин гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, орон гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга, ил тод үнэлж, сайжруулдаг байна.*

***Хөтөлбөрийн явцад суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг тогтоож, үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлдэг байдал***

УБТДС-ийн сургалтын журмын 6.6.-д "Суралцагчийн мэдлэг, чадвар хандлагыг үнэлэхдээ БШУ-ны сайдын 2024 оны А/147, А/144 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Магистрын сургалтын нийтлэг шаардлага", УБТДС-ийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 19 тоот тушаалаар батлагдсан "Магистрын сургалтын журам"-ын 8.1.6-р заалтаар Магистрантуудын мэдлэг чадварыг дүгнэдэг.

"Биеийн тамирын боловсрол" магистрын сургалтын хөтөлбөрийн үнэлгээг багш тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага буюу хичээлийн үр дүнг (CLO)-г сургалтын хөтөлбөрийн PLO-той уялдуулан шинэчилж боловсруулснаар суралцахуйн үр дүнг үнэлэх тогтолцоо бий болсон. Нэг кредит

хичээлд оногдох танин мэдэхүйн түвшин тус бүрийн даалгаврын тоог хэвийн тархалтын хувийг баримтлан боловсруулснаар гүйцэтгэлд суурилсан үнэлгээг түлхүү ашиглах болсон байна.

“Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийн үнэлгээний даалгаврын сангийн статистикт шинжилгээ хийж үзвэл, танин мэдэхүйн түвшин бүрд даалгавар боловсруулсан байна. Тухайлбал, судалгаанд хамруулсан 9 хичээлээр нийт үнэлгээний даалгавар боловсруулсны % 13.1 нь сэргээн санах, 13% нь ойлгох, 24.1% нь хэрэглэх, 26.3% нь задлан шинжлэх, 15.8% нь үнэлэх, 8.0% нь бүтээх түвшний даалгаврыг баталгаажуулсан. (Хавсралт 3.1). Үүнийг тохиромжтой гэж үзсэн бөгөөд бакалаврын түвшний үнэлгээний даалгаврын сангийн үнэлэх, бүтээх түвшний даалгавар 5-8% илүү байгаа нь ахисан түвшний сургалттай холбоотой гэж үзэж байна.

***Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал***

Магистрын үнэлгээг хичээлийн стандартын “Үнэлгээний хэлбэр, жин”, “Бие даах ажлын үнэлгээ” гэсэн хэсэгт тодорхойлдог “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын төлөвшлийг хичээл бүрийн үнэлгээнд олон аргуудаар хэрэглэж байгаа нь суралцагчдын хөгжилд дэмжлэг үзүүлж байна (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1 Хичээл тус бүрийн үнэлгээний арга, хэлбэр

| Хичээлийн нэр | Код | Үнэлгээ | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бие даалт | | | | | | | | Явцын шалгалт | | | | | | |
| | | Сорил, дасгал | Дүрс бичлэг | Арга боловсруул | Хэлэлцүүлэг, | Хөтөлбөр болов | Дүн шинжилгээ | Илтгэл тавих | Бүтээлийн сан | Тест авах | Дасгал ажил | Хэлэлцүүлэг | Практик үйл | Ярилцлага | Хичээл | Бичил судалгаа |
| **А.Мэргэжлийн суурь хичээл** | | | | | | | | | | | | | | | | |
| **Заавал судлах** | | | | | | | | | | | | | | | | |
| Шинжлэх ухааны судалгааны арга зүй | N.SCM-700 | 1 | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | 1 | | | 1 | | | |
| Биеийн тамирын боловсролын менежмент | N.MPE-706 | 1 | | | | | 1 | | | 1 | | | 1 | 1 | | 1 |
| Боловсрол судлалын үндэс | N.PES-702 | 1 | | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | | 1 |
| **Сонгон судлах** | | | | | | | | | | | | | | | | |
| Боловсролын философи | N.EPH-705 | | | | | 1 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | | | 1 |
| Биеийн тамир спортын хэмжил зүй | N.MPS-709 | 1 | 1 | | | | 1 | 1 | 1 | 1 | | | | 1 | | |
| **Б. Мэргэшүүлэх хичээл** | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эрүүл мэндийн боловсрол | N.HED-704 | | | | 1 | | 1 | 1 | | 1 | | | | | | 1 |
| Биеийн тамирын судалгааны онол, арга зүй | N.TMR-701 | 1 | | | | | 1 | | | 1 | | | 1 | 1 | | 1 |
| Биеийн тамир спортын сэтгэл судлалын үндэс | N.PPE-707 | 1 | | 1 | | | | 1 | | 1 | | 1 | 1 | 1 | | 1 |
| Биеийн тамирын боловсролын онол арга зүй | N.TPE-708 | 1 | 1 | 1 | | 1 | 1 | 1 | | | 1 | | 1 | | | 1 |

Дээрх хүснэгтээс харахад магистрантын мэргэжлийн заавал судлах 6, сонгон судлах 2 хичээлийн явцын 7, бие даалтын 8 үнэлгээний төрөл, арга, хэрэгслийг ашиглаж байна. Эндээс 60% нь дүн шинжилгээ, 40% нь илтгэл, хэлэлцүүлэг байгаа нь ахисан түвшний суралцахуйд нийцэж байна. Цаашид бид үнэлгээний орчин үеийн арга хэрэгслийг ашиглан, өөрийн үнэлгээний арга, аргачлал боловсруулан түүнийгээ хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

***Хэрэглэдэг үнэлгээний арга, аргачлал***

Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэхдээ үнэлгээг ҮБТДС-ийн суралцагчийг үнэлэх журмаар зохицуулдаг (ҮБТДС-ийн магистрын сургалтын журам). Эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд боловсруулсан “Сургалтын үнэлгээний удирдамж ба үнэлгээний шалгуур үзүүлэлт” удирдамжийг баримталж ирсэн. Үнэлгээний төрөл болох гарааны, явцын, эцсийн үнэлгээ хийдэг.

Тус хөтөлбөрийн хувьд гарааны үнэлгээг нэгдсэн байдлаар мэргэжлийн хичээлийн хувьд хийж байгаагүй боловч 2022-2023 оны хичээлийн жилээс гадаад оюутнууд ихээр элссэнтэй холбоотойгоор гарааны үнэлгээг улирлын эхэнд монгол хэлний түвшнийг тогтоох шалгалт авдаг. Шалгалтад 75 онооноос дээш үнэлгээ авсан тохиолдолд тухайн бүртгүүлсэн хөтөлбөрөөр элсэн суралцахыг зөвшөөрдөг.

Явцын үнэлгээ нь тухайн оюутны эзэмшиж буй мэдлэг, чадвар, ахицыг илрүүлэх багшийн үнэлгээ юм. Сургалтын төлөвлөгөө дэх хичээлээр оюутны үнэлгээний хэлбэр, жинг биеийн тамирын сургалтын онцлогт нийцүүлэн тогтоосон. Лекц, семинарын хичээлд оюутны ирц оролцоо 30%, бие даалт 30%, явцын үнэлгээ 10%, улирлын шалгалт 30%-ийг эзлэх бол практик, лаборатори хичээлд ирц оролцоо 20%, бие даалт 30%, явцын үнэлгээ 50%-ийг эзлэхээр тогтоосон. Явцын үнэлгээг багш бүр өөрийн хичээлийн стандартын дагуу үнэлдэг.

Эцсийн (нэгдсэн) үнэлгээ буюу төгсөлтийн шалгалтыг магистрант 21 кредит хичээлийг амжилттай судалсны дараа урьдчилсан хамгаалалтын хэлэлцүүлэгт орох эрхтэй.

***Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал***

ҮБТДС-н магистрын сургалтын журмын 8-р заалтад магистрантын мэдлэг чадвар хандлагыг үнэлэх заалтад тусгасан байна.

Магистрантын мэдлэг, чадвар хандлагыг үнэлэхдээ сургалтын нэгэн ижил төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн агуулгаар дүгнэж үнэлэн, шинжлэх ухааны үндэстэй, бодитой шударга, ил тод дүгнэдэг. Сургалтын төлөвлөгөөнд хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, дүгнэх гол хэлбэр нь явцын

үнэлгээ байх ба хүрсэн түвшин болон үр дүнгийн үнэлгээг хичээл заасан багш 100 хувь хийнэ. магистрын эзэмшиж буй мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх хэлбэрийг хичээлийн стандартад тусгасан байна.

Сургалтын журмын 8-д “Магистрантын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байвал зохино” гэж заасан байдаг. Магистрантуудын тухайн улирлын дүнг багш сургалтын журамд заасны дагуу тухайн улирлын шалгалтын 7 хоногт багтаан, сургалтын удирдлага мэдээллийн системд оруулж, хэвлэн, баталгаажуулж бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгнө. Дүн оюутны вебийн дүн цэсэд дараах байдлаар оюутанд нээлттэй шууд харагдах байдлыг үзүүлэв Зураг 3.1

Тухайн улирлын дүн SUS-д харагдах байдал: Сургалтын албанаас багш нарт улирлын шалгалтаас авснаас 7-10 хоногийн хугацаа өгч тухайн багш заасан хичээлийнхээ дагуу дүнг хугацаанд дотоод удирдлагын системд оруулна. Заасан хугацаа дууссан тохиолдолд дүн оруулах боломжгүй. Багш дүн оруулахдаа дүнгийн задаргааны дагуу улирлын шалгалт, ирц, бие даалт, идэвх гэх мэт задлан оруулна.



*Зураг 3.1 Багшийн дүнгийн задаргаа оруулах хэсэг*

Багш дүнгээ оруулж дууссаны дараа оюутан бүр өөрийн оюутны вебд нэвтрэн орж, өөрийн дүнгээ харах боломжтой.

Улирлын төгсөлд дүн баталгаажуулах 7 хоногт ҮБТДС-ийн хяналт үнэлгээ чанарын баталгаажуулалтын албанаас хичээл орсон багш бүр дээр оюутны сэтгэл ханамжийн судалгааг оюутны вебээр дамжуулан авдаг.

Суралцагчийн үнэлгээний ил тод, найдвартай, шударга, ижил тэгш шаардлагыг хэрхэн хангаж байгааг Биеийн тамирын сургуулийн магистрантуудын дунд явуулсан бичил судалгааны дүнгээр харуулъя. Судалгаанд ҮБТДС-ийн 1-2 курсийн нийт 40 магистрант, үүнээс 1-р курс 25%, 2-р курс 75% тус тус хамрагдсан.




*Зураг 3.2 Суралцагчийн мэдлэг, чадварыг ил тод, бодитой үнэлдэг эсэхэд өгсөн оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ*

Багш оюутны мэдлэг, чадварыг ил тод, бодитой үнэлдэг үү? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан оюутны 70% нь тийм, 18% нь ихэнхдээ тийм гэж хариулснаас "оюутныг бодитой үнэлж" байгааг харж болохоор байна. Энэ асуултад курсийн ялгаа ажиглагдаагүй болно.

***Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл***

ҮБТДС-д 2024 оны хичээлийн жилээс хөтөлбөр болон, сургалтын чанарт шинэчлэл хийж кредит системд шилжсэнээр мэдээлэл технологийн шинэ шийдэл бүхий сургалт, удирдлагын үйл ажиллагаа дэмжих, оюутан багш, мэргэжилтнүүдэд хүртээмжтэй сургалт, удирдлага мэдээллийн систем (SUS) нэвтрүүлсэн болно. Ингэснээр оюутан бүр өөрийн суралцах үйл явцыг хариуцан хичээл, өдөр, цаг, багшаа сонгох, төлөвлөлт хийх, хичээл судалсан үнэлгээ, улмаар голч дүнд анализ хийж, тухайн хичээлээр болон хөтөлбөрөөр ямар эрэмбэд байгаагаа харах бүрэн боломжтой болсон. (Зураг 3.3.)

Дүнгийн мэдээлэл

2022-2023 НАМАР

| № | ХИЧЭЭЛИЙН КОД | ХИЧЭЭЛИЙН НЭР | КРЕДИТ | ОНОО | ҮНЭЛГЭЭ | БАГШИЙН КОД | БАГШИЙН НЭР |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | HIST101 | Монголын түүх соёл, ёс заншил | 3 | 91 | A | | |
| 2 | PHIL111 | Философи | 3 | 64 | D | | |
| 3 | PSYC108 | Сэтгэл судлалын үндэс | 3 | 83 | B | | |
| 4 | ICIT103 | Мэдээллийн технологи мэдээллийн систем | 3 | 74 | C | | |
| 5 | MILL112 | Цэргийн эрдэм | 1 | 72 | C | | |
| 6 | ENGL114 | Англи хэл II | 2 | 47 | F | | |
| 7 | ENGL104 | Англи хэл I | 2 | 50 | F | | |
| 8 | EDST110 | Багш мэргэжлийн удиртгал | 1 | 58 | F | | |
| 9 | MONG110 | Монгол хэл бичиг, найруулга зүй | 3 | 70 | C | | |
| 10 | HEAL116 | Хүүхдийн бие бялдарын анатоми, физиологи | 3 | 80 | B | | |
| | Нийт | | 24 | 71.25 | | | Улирлын голч дүн: 1.7 |

2022-2023 ХАВАР

| № | ХИЧЭЭЛИЙН КОД | ХИЧЭЭЛИЙН НЭР | КРЕДИТ | ОНОО | ҮНЭЛГЭЭ | БАГШИЙН КОД | БАГШИЙН НЭР |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | EDST212 | Судалгааны арга зүй II | 2 | 60 | D | | |
| 2 | MONG209 | Монгол бичиг | 2 | 90 | A | | |
| 3 | SPRT102 | Биеийн тамир, эрүүл ахуй /спорт аялал/ | 1 | 85 | B | | |
| 4 | PSYC115 | Бага насны хүүхдийн сэтгэл судлал | 3 | 54 | F | | |
| 5 | HDEV109 | Хүний хөгжил харилцааны ёс зүй, эрх зүй | 3 | 57 | F | | |
| 6 | INTE221 | Танилцах дадлага | 1 | 91 | A | | |
| | Нийт | | 12 | 67.42 | | | Улирлын голч дүн: 1.3 |

*Зураг 3.3 Оюутан системээс хичээлийн дүн харагдах хэсэг*

Дээрх дүнгийн график үзүүлэлтүүд суралцагч бүрийн вебийн "дүн" цэсэд нээлттэй, ил тод харагддаг.

### 3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

*Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-ийг дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.*

***Өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцох тогтолцоог хэрэгжүүлж буй байдал***

БШУ-ны сайдын 2024 оны 05-р сарын 06-ны өдрийн А/216-р тушаал болон 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/147-р тушаалын дагуу багц цагийг дүйцүүлэх журмыг баримталдаг. Шилжин суралцаж байгаа оюутнуудад өмнөх сургуулийн судалсан хичээлийн дүйцүүлэгчийг ҮБТДС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 83 дугаар шинэчлэн батлагдсан тушаалаар дүйцүүлэн шилжин суралцах боломжоор хангадаг. Биеийн тамирын боловсролын магистрын хөтөлбөрт шилжиж ирж, дүйцүүлэлд хийлгэсэн оюутан одоогоор байхгүй байна.

### 3.3 Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ

*Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжих төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээг нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээт гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.*

БШУ-ны сайдын 2024 оны 05-р сарын 06-ны өдрийн А/216-р тушаал болон 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/147-р тушаалын дагуу бусад газраас шилжиж ирсэн магистрантуудын багц цагийг дүйцүүлэх журмыг баримталдаг.

Магистрантууд “Мэргэжлийн суурь хичээл”-ийн 12 кредитийг гүйцэд судалсны дараа мэргэших хичээлүүдийг судалдаг. Магистрантуудад зөвлөн туслах үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлдэг. Үүнд:

- Сургалтын зохион байгуулалт, хэлбэрийг танилцуулах
- Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх
- Бусад мэдээлэл түгээх, харилцах
- Боловсролын бусад үйлчилгээ үзүүлэх

Сургалтын зохион байгуулалт, хэлбэр нь ҮБТДС-ийн сургалтын журамд зааснаар сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба нь төгсөлтийн дараах сургалтын бүртгэл, элсэлт, үндсэн суурийн хичээлийг зохион байгуулах хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг. Харин сургуулийн хөтөлбөрийн алба төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулдаг. Жил бүр хөтөлбөрийн алба, оюутны хөгжлийн албаны ажлын төлөвлөгөөнд оюутныг хөгжүүлэх, тэднийг дэмжин туслах чиглэлийн олон ажлыг төлөвлөдөг бөгөөд мөн ийм чиглэлийн ажлууд багшийн ажлын төлөвлөгөөнд ч заавал тусгагддаг. Мөн магистрын сургалтын хэлбэр, зохион байгуулалт, үр дүнгийн үнэлгээ, магистрын ажлыг бичих, хамгаалах, судалгааны ажлын удирдагчийг сонгох талаар анхан шатны мэдээлэл хүргэх уулзалтыг зохион байгуулж багш нарыг танилцуулдаг.

ҮБТДС-ийн төгсөлтийн дараах сургалтын журам, эрхзүйн бичиг баримтын талаар мэдээлдэг. Мөн магистрын гарын авлагыг танилцуулж, түүнийг хэрхэн хэрэглэх талаар зөвлөдөг.

Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхийг Магистрантын эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих ажлын “Оюутны журам” (2015.09.09, Захирлын тушаал №А/172)-аар зохицуулдаг. Үүний дагуу жил бүр ҮБТДС-аас гурван үе шаттай зохион байгуулдаг магистр, докторантын эрдэм шинжилгээний хуралд оролцогчдод зөвлөн тусалж, дэмжин оролцуулдаг. Сургалтын явцад магистрантуудыг эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад оролцуулж, судалгааны арга, мэдээлэл цуглуулах, боловсруулах, үр дүнг танилцуулах зэрэг арга зүйд суралцахад чиглүүлдэг. Тус хурлаар дамжуулан бусад оюутнууд, судлаачидтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг.

Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, тайлагнах арга барилд сурахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс магистрын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтад оролцуулан, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн тавьж буй асуулт, магистрантын хариулт, хурлын үйл явцыг хэлэлцэх үйл ажиллагааг зохион байгуулж, цаашид анхаарах зүйлийг тодруулахад чиглүүлдэг.

ҮБТДС-аас магистрантуудад мэдээлэл түгээх, зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд жил бүр хөтөлбөрийн албаны мэргэжилтэн шинэ элсэгчдийг бүртгэж, хичээл сонголт хийхэд нь зөвлөн тусалж, бүх талын зөвлөгөө өгөх, оюутны мэдээллийг системд оруулах, хамтран хичээл сонголтыг нь хийх, баталгаажуулах зэрэгт тусалж ажилладаг. Магистрантад санал болгох төлөвлөгөөг 1-2 хувилбараар боловсруулан оюутны вебд байршуулан, мөн оюутны мэдээллийн самбарт хадах зэргээр сургалтын бүх хэлбэрийн боломжийг танилцуулж зөвлөн тусалдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд Өвөр Монгол магистрантууд их суралцах болсонтой холбоотойгоор тэдний суралцах, судалгааны ажлаа хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх профессор Р.Лхагвасүрэн багшийг томилон дагалдуулан ажиллуулж байна.

Оюутны хөгжлийн албанаас мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, хэрэгцээт мэдээллийг суралцагчдад шуурхай түгээдэг ба мэдээллийн самбарыг шинэчлэн санал хүсэлтийн хайрцаг хийж, оюутнуудын саналыг хүлээн авч байна. Тус сургуулийн фейсбүүк хуудсанд шинээр элсэгчдийг бүртгэхээс гадна доорх хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг хүргэдэг (https://www.facebook.com/Үндэсний биеийн тамирын дээд сургууль).

ҮБТДС-ийн магистрын сургалттай холбоотой мэдээллийг https://student.nipe.edu.mn хаягаар түгээж, аль болох мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Боловсролын бусад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр номын санд магистрант, докторантуудад зориулсан уншлагын болон цахим мэдээллийн танхимаар үйлчилгээ үзүүлж байна. Мөн магистрант нь тус сургуулийн судалгааны төвд ажиллан интернэт сүлжээ, удирдлага мэдээллийн систем ашиглах, тус сургуульд хамгаалсан магистрын дипломын ажлыг судлах зэрэг мэдээлэл цуглуулах,

боловсруулах үйлчилгээ авах боломжтой. Бакалаврын боловсролын үнэлгээний голч дүн 3.7 дээш магистрантууд төрийн сангийн хөнгөлөлттэй зээл авч болох ба энэхүү журмын дагуу магистрант Б.Баасандорж энэ зээлд хамрагдсан. Мөн магистрант Д. Жавхлантөгс, С.Оюун-Эрдэнэ нар хөгжлийн бэрхшээлтэй тул төрийн сангийн буцалтгүй тусламжид хамрагдан 100 хувь төлбөрөө даалган суралцан төгссөн болно.

Гадаад суралцагчдын хамгийн чухал нийгмийн асуудлын нэг нь байр, орон сууц байдаг. Бид ҮБТДС-ийн оюутны 1-р дотуур байр, “Оюутны өргөө” зэрэг дотуур байрны нөхцөл байдалтай танилцаж, магистрантуудыг дотуур байранд орох хүсэлтийг өргөдлөөр авч хуваарилалт хийн, хяналт тавьж, зөвлөж байна. Хөдөө, орон нутгаас ирж суралцаж буй суралцагчдыг байраар хангах үйлчилгээ үзүүлдэг. Оюутны байр нь амьдрах өрөө, соёл олон нийтийн ажил явуулах өрөө, спорт тоглоомын өрөө болон халуун усны өрөөгөөр үйлчилдэг. Интернэт орчин бүрдсэн.

Өвөр Монгол оюутнуудтай wechat апликейшн ашиглан байнгын харилцаа холбоотой байж, хичээл бүрээр дундын бүлэг үүсгэн асуудлуудыг түргэн шуурхай шийдэж ажилладаг.

***Суралцагчийн суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэдэг байдал.***

Сургууль, тэнхимээс явуулж буй бодлого шийдвэрийг шуурхай хэрэгжүүлснээр, сургалтын үйл ажиллагаанд оролцогч, багш, суралцагчийн уялдаа холбоог бэхжүүлэх, багшийн ёс зүйн болон зан харьцааны үлгэр дуурайл үзүүлэхэд ихээхэн нөлөөлдөг.

Сургуулиас зохион байгуулж буй спортын уралдаан тэмцээн болон бусад үйл ажиллагаанд суралцагчдыг оролцох болон суралцах үйлийг дэмжих зорилгоор нөхцөл боломжийг хангаж ажилладаг. Мөн хичээл сонголт хийх, амжилттай суралцахад нь дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөгөө чиглүүлэг өгч ажилласаар ирсэн.

Фейсбүүк болон вичат (wechat) аппикейшин ашиглан бүлэг үүсгэж холбоо тогтоох, ганцаарчлан уулзах зэрэг хэлбэрээр оюутан бүрийн хичээл тасалсан цаг, улирлын эцэст шалгалтын үр дүнгийн судалгааг хийж ажилладаг. Сургууль төгсөх үед дүнгийн тулгалт хийж, баталгаажуулан төгсөх суралцагчдын ажил байдлын тодорхойлолтыг гаргаж өгдөг.

***Магистрантын санал, хүсэлт гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байдал***

ҮБТДС-ийн сургалтын журам, ҮБТДС-ийн ёс зүйн хорооны ажиллах журам, оюутны ёс зүйн журмын дагуу оюутнаас ирсэн санал, гомдлыг сургуулийн захиргаа, ҮБТДС-н ёс зүйн хороо, бүрэлдэхүүний ёс зүйн хороо зэрэг холбогдох байгууллага нь шийдвэрлэдэг ба одоогоор магистрантаас ийм төрлийн гомдол ирээгүй болно.

Оюутны чөлөө, сургалтын үйл ажиллагаатай холбоотой ирдэг өргөдөл хүсэлтийг зохих шатны удирдлагын шийдвэрийн дагуу тухай бүрд нь шийдвэрлэн

ажилладаг. 2021 оноос ҮБТДС-ийн хөтөлбөрийн албанд ирж буй магистрантуудын санал, хүсэлтийн 54% нь хангалтгүй үнэлгээтэй буюу хичээлээ дахин судлах, 21% нь жилийн чөлөөнөөс эргэн суралцах, 17% нь сургалтын төлбөрийг хойшлуулах, 8% нь жилийн чөлөө авах хүсэлт ирүүлсэн байна. Уг хүсэлтүүдийг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тухай бүрд нь шийдвэрлэдэг. Хөтөлбөрийн албанд ирсэн өргөдөл, хүсэлтийн биелэлт 95%-тай шийдвэрлэгдсэн байна.

### 3.4 Судалгааны санхүүжилт

*Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.*

***Магистрантын судалгаа, шинжилгээний ажлыг хийх, хэлэлцүүлэх, хэвлүүлэхэд хэрхэн дэмжин тусалдаг байдал***

ҮБТДС нь судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих үзэл баримтлалд суурилан үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Магистрантын удирдагч багш нар болон сургуулийн захиргаанаас тэдний судалгаа хийх боломж нөхцөлөөр хангах, судалгааны лабораторид ажиллах боломж олгох, арга зүйгээр хангах зэргээр тусалж дэмждэг. Энэхүү хөтөлбөрөөр суралцагч магистрантууд өөрийн судалгааны ажлаар боловсрол судлалын болон биеийн тамир, спортын чиглэлийн эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлдэг. Ингэснээр магистрын судалгааны ажлын 1-2 кредитийг тооцуулах боломж үүсдэг. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн хугацаанд эрдэм шинжилгээний хуралд 17 илтгэл, 28 гаруй өгүүлэл хэлэлцүүлсэн байна.

ҮБТДС-ийн 2019-2024 оны байдлаар жилийн нийт орлогын 15,25% нь магистрын сургалтын төлбөрөөс ордог бөгөөд үүний дотоодын магиструудаас 2%, гадаад магиструудаас 13,25% бүрдүүлсэн байгаа нь гадаад магиструудын төлбөр дотоодын магиструудаас өндөр байгаа нь харагдаж байна /Хүснэгт 3.2/.

Хүснэгт 3.2 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд харилцах дансанд төвлөрсөн оюутны төлбөрийн орлого



ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ОЮУТНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ДҮН

| № | Орлогын төрөл | 2019-2020 | | | 2020-2021 | | | 2021-2022 | | | 2022-2023 | | | 2023-2024 | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь |
| 1 | Бакалаврын орлого | 456 | 394,099,500.00 | 87.68 | 482 | 439,240,500.00 | 89.32 | 452 | 498,520,600.00 | 86.03 | 428 | 488,650,000.00 | 84.68 | 400 | 738,332,360.00 | 84.75 |
| 2 | Дотоодын магистрийн орлого | 25 | 55,350,000.00 | 12.32 | 18 | 52,500,000.00 | 10.68 | 11 | 2,400,000.00 | 0.41 | 6 | 18,540,500.00 | 3.21 | 12 | 17,465,000.00 | 2.00 |
| 3 | Гадаад магистрийн орлого | - | - | - | - | - | - | 19 | 78,520,000.00 | 13.55 | 32 | 69,850,200.00 | 12.10 | 29 | 115,420,000.00 | 13.25 |
| | **Магистрийн нийт дүн** | **25** | **55,350,000.00** | **12.32** | **18** | **52,500,000.00** | **10.68** | **30** | **80,920,000.00** | **13.97** | **38** | **88,390,700.00** | **15.32** | **41** | **132,885,000.00** | **15.25** |
| | **Нийт дүн** | **481** | **449,449,500.00** | **100.00** | **500** | **491,740,500.00** | **100.00** | **482** | **579,440,600.00** | **100.00** | **466** | **577,040,700.00** | **100.00** | **441** | **871,217,360.00** | **100.00** |

МЭДЭЭ ГАРГАСАН ............ НЯ-БО А. АМАРМАНДАХ

Хүснэгт 3.3 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрийн сургалтад зарцуулсан тооцоо

ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МАГИСТРИЙН ОЮУТНУУДАД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ТҮҮВЭР

| № | Зардлын ангилал | 2019-2020 он | 2020-2021 он | 2021-2022 он | 2022-2023 он | 2023-2024 он |
|---|---|---|---|---|---|---|
| | | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал |
| 1 | Цалинд | 14,280,500.00 | 17,580,750.00 | 15,420,350.00 | 14,568,950.00 | 14,550,600.00 |
| 2 | Суутган татвар | 714,025.00 | 879,037.50 | 771,017.50 | 728,447.50 | 727,530.00 |
| 3 | Ном сурах бичиг | 1,000,000.00 | 1,255,100.00 | 500,000.00 | 450,000.00 | 600,000.00 |
| 4 | БҮТЭЗ | 4,500,000.00 | 1,150,000.00 | 850,000.00 | 1,240,000.00 | 1,520,000.00 |
| 5 | Түрээс, халаалт, ашиглалтын зард | 11,520,000.00 | 1,150,000.00 | 9,900,000.00 | 11,520,000.00 | 12,540,000.00 |
| 6 | Бичиг хэрэг | 155,000.00 | 126,450.00 | 182,520.00 | 250,400.00 | 230,500.00 |
| 7 | Хэвлэл захиалга | 402,560.00 | 250,000.00 | 180,500.00 | 450,200.00 | 320,100.00 |
| 8 | ЭША, Хамтарсан төслийн судалгааны ажилд | 711,800.00 | 750,200.00 | 1,250,000.00 | 840,500.00 | 759,100.00 |
| 9 | Тэмцээн уралдаан | 850,000.00 | 650,000.00 | 500,000.00 | 350,000.00 | 710,000.00 |
| 10 | Оюутны үйчилгээ | 1,259,000.00 | 856,000.00 | 485,300.00 | 700,000.00 | 654,000.00 |
| 11 | Суртачилгаа | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 12 | Холбоо, интернэт | 540,000.00 | 520,000.00 | 420,000.00 | 500,000.00 | 540,000.00 |
| 13 | Тэтгэмж оюутан, ажилчин, бусад | 900,000.00 | 3,400,000.00 | 2,700,000.00 | 500,000.00 | 3,400,000.00 |
| 14 | Хоол, ёслолын ажиллагаа | 150,000.00 | 200,000.00 | 120,000.00 | 135,000.00 | 250,000.00 |
| 15 | Бусад сургалтын зардалд | 14,530,000.00 | 15,200,500.00 | 35,400,000.00 | 34,560,000.00 | 54,250,000.00 |
| 16 | Цэвэрлэгээ, хангамж , ариутгал | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 |
| | | 52,662,885.00 | 45,118,037.50 | 69,829,687.50 | 67,943,497.50 | 92,201,830.00 |

МЭДЭЭ ГАРГАСАН:........................../НЯ-БО А. АМАРМАНДАХ/

2019-2024 оны эхний 6 сарын байдлаар ҮБТДС-ийн нийт орлогын 10%-ийг магистрын хөтөлбөрт зарцуулсан байна/Хүснэгт 3.3/.

### 3.5 Тэтгэлэг, тэтгэмж

*Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.*

Сургуулийн магистрын зэргээр сурч буй магистрантууд танхимын сургалтаар 1,5 жил суралцах хугацаандаа сургуулийн төсөлт судалгааны ажлын бүрэлдэхүүнд орж, гардан судалгааны ажилд суралцах болон хичээлээс гадуур бие даан судалгаа шинжилгээний ажлыг хийж, судлах ур чадвараа ахиулж дээшлүүлдэг тогтолцоо бүхий онцлог сургалттай. Магистрантууд сургууль дээр хэрэгжиж буй гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хамтарсан төсөлт ажлуудын багийн бүрэлдэхүүнд багтаж амжилтынхаа үр дүнгээр төр засгаас олон сая төгрөгийн шагнал, урамшуулал авдаг нь сургуулийн бас нэг онцлог юм. Тухайлбал, 2019 онд Японы Хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтарсан эрдэм шинжилгээний төсөлт ажлын хүрээнд СБД-ийн 11 сургуулийн биеийн тамирын багш нарт тус бүр 50%-н сургалтын төлбөрийн хөнгөлөлт тэтгэлэгт хамруулсан, бөгөөд сургуульд нь иж бүрэн хөгжим хандивласан байдаг.

Манай сургууль биеийн тамирын боловсрол, спортын дасгалжуулагч мэргэжлээр магистрын сургалт явуулж байгаа бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар 4000 гаруй мэргэжилтэн, 340 гаруй магистр төгсгөөд байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагааны үндсэн нэгж нь тэнхимүүд бөгөөд сургалт, судалгаа, дасгалжуулалт, биеийн тамирын арга зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын анхдагч нэгж нь профессорын баг, сургалтын лаборатори, мэргэжлийн баг, сургалтын тусгай тоног төхөөрөмж бүхий заал, танхим, кабинетууд юм.

Жилээс жилд эрдэм шинжилгээний бага хуралд оролцож илтгэл тавих магистрантын тоо нэмэгдэж байгаа нь судалгаа шинжилгээний ажил хийх сонирхол өсөж байгаагийн илрэл юм.

***Тэтгэлэг, урамшууллын бодлого, зохицуулалт***

Суралцагчдын амжилтыг дэмжих урамшууллын тогтолцоо бүрдсэн. ҮБТДС-ийн оюутнуудад 2 төрлийн тэтгэлэг, урамшуулал олгож байна. Үүнд:

А. ҮБТДС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг

Б. ҮБТДС-ийн шилдэг оюутны урамшуулал

Тухайлбал, Парисын Олимпын алтан медальт У.Сүрэнжавт захирлын нэрэмжит тэтгэлэг болох 100 хувь сургалтын төлбөрийн хөнгөлөлт урамшуулав үзүүлэв.

Үүнээс гадна оюутны хөгжлийг дэмжих дараах тэтгэлгүүд байдаг. Үүнд:

- Элсэлтийн өндөр онооны тэтгэлэг
- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж
- Оюутны хөгжлийн зээл
- Бусад тэтгэлэг /Банкны тэтгэлэг,бусад төрийн байгуулга болон төрийн бус байгууллагуудын тэтгэлэг гэх мэт/

Суралцагчдад тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон бусад дэмжлэг үзүүлдэг байна.

**Тэтгэлэг, хөнгөлөлтийн өөрчлөлт**

Сурлага спортын өндөр амжилт гаргасан суралцсан 94 оюутан сүүлийн 5 жилд сургуулиас буцалтгүй тусламжид хамрагдаж 106,1 сая төгрөгийн тэтгэлэг олгосон бөгөөд үүний 20,3% г-ийн магистрантуудад үзүүлсэн тэтгэлэг эзэлж байна. “Оюутны хөгжлийн зээл”-ээр 124 оюутан 220,1 сая төгрөгөөр сурсан байгаагаас 12,7% магистрант оюутнууд эзэлж байна.

Хүснэгт 3.4 Сургуулийн өөрийн санхүүжилтээр олгосон тэтгэлгийн хэмжээ /сүүлийн 5 жил/

| № | 2018-2019 | | 2019-2020 | | 2020-2021 | | 2021-2022 | | 2022-2023 | | Нийт дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн |
| Бакалавр | 43 | 50,250,000 | 5 | 6,135,000 | 19 | 16,627,500 | 3 | 2,925,000 | 7 | 8,620,000 | 77 | 84,557,500 |
| Магистр | 11 | 14,850,000 | 0 | - | 2 | 1,400,000 | 1 | 900,000 | 3 | 4,400,000 | 17 | 21,550,000 |
| | **54** | **65,100,000** | **5** | **6,135,000** | **21** | **18,027,500** | **4** | **3,825,000** | **10** | **13,020,000** | **94** | **106,107,500** |

Хүснэгт 3.5 Оюутны хөгжлийн зээлээр олгосон тэтгэлгийн хэмжээ /сүүлийн 5 жил/

| № | 2020-2021 | | 2021-2022 | | 2022-2023 | | Нийт дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн | Оюутны тоо | Мөнгөн дүн |
| Бакалавр | 69 | 105,600,000 | 35 | 64,350,000 | 11 | 23,100,000 | 115 | 193,050,000 |
| Магистр | 5 | 15,000,000 | 4 | 12,000,000 | 0 | - | 9 | 27,000,000 |
| | **74** | **120,600,000** | **39** | **76,350,000** | **11** | **23,100,000** | **124** | **220,050,000** |

### 3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

*Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоодын болон гадны судалгааны нэгж, байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.*

ҮБТДС нь өнгөрсөн жилүүдэд 16ш гадаад болон дотоодын 26ш мэргэжлийн байгууллагууд, их дээд сургуулиуд, судалгааны байгууллагууд, Төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж багш, суралцагч солилцоо,тэтгэлэгт хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр, сургалт-судалгаа, эрдэм шинжилгээний ажил, сургалт-семинарыг зохион байгуулж ажилласан. Сүүлийн 5 жилийн хугацаанд дотоодын их, дээд сургууль, ЕБС, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, хэлэлцүүлэг, хурал зөвлөгөөн зохион байгуулах, мэдээлэл солилцох багш, оюутны хөгжлийг хангах, дадлагажуулах, хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжүүлэх, хамтран дэмжлэг үзүүлэх зэрэг 10 гаруй байгууллагатай, 2019 оноос Нийслэл, болон орон нутгийн 60 гаруй ЕБС-ийн сургуулиуд дээр танилцах ба багшлах дадлагуудыг хамтран зохион байгууллаа.

**Гадаад харилцааны хүрээнд хийсэн ажлуудаас:**

1. Бээжингийн Спортын их сургуульд оюутан солилцооны хүрээнд магистрантаар суралцахаар 2016 оны төгсөгч Д.Шинэцэцэгийг сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэгтэй суралцуулахаар явуулсан, мөн төгсөгчГэрэл-Од магистрт суралцаж байна. Тус оюутан 4 жилийн хугацаатай суралцан спортын сэтгэл судлалаар магистрын зэрэг хамгаалахаар суралцаж байгаа. Мөн хамтын ажиллагааны хүрээнд багш нар Бээжингийн спортын их сургуулиас 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр онлайн-аар зохион байгуулагдсан ОУЭШ хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн.
2. Германд төвтэй ICSSPE /ОУ-ын Спортын Шинжлэх Ухаан Биеийн Тамир Боловсролын зөвлөл/- өөс сар бүр цахимаар мэдээлэл гаргадаг. Энэ мэдээллийг сар бүр орчуулан танилцуулдаг болно. Мөн энэ байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд шуурхай цаг үеийн мэдээллийг хүлээн авч хариу өгсөн байгаа. Жишээ нь жил бүр албан ёсны гишүүнчлэлийн татвар төлдөг.
3. ОУ-ын биеийн тамир, спортын их дээд сургуулиудын холбооны “Оюутны спорт:Үндэсний эрүүл мэнд, хөгжил дэвшил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний VIII хурлыг 2018 оны 4-р сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус хуралд 14 орны 30 гаруй сургуулийн эрдэмтэн аспирант, магистр, магистрант, бакалаврын түвшний оюутнууд, докторууд илтгэлээ явуулснаас 30 гаруй эрдэмтэд хүрэлцэн ирж илтгэлээ хэлэлцүүллээ. Бид нийтдээ энэхүү хурлын хүрээнд албан ёсны 300 гаруй цахим захианд хариу өгсөн.
4. NITTAIDA буюу Японы спортын шинжлэх ухааны сургуультай хамтын ажиллагааны хүрээнд эмчилгээ арга зүйн тэнхимийн багш Норико манай сургуульд зочин профессороор ажилласан.
5. Солонгос улсын Инчоны Биеийн Тамирын Ахлах сургуультай 2019 оны 10 дугаар сарын 28-нд хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулийн 2 төлөөлөгч манай чөлөөт бөхийн аварга шалгаруулах тэмцээнд ирж оролцсон.
6. Япон улсын Кумамото Чуо ахлах сургуультай 2021 оны 7 сарын 1-ний өдөр хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зуран хамтран ажиллаж тус сургуулийн дэд захирал ноён Фурусава болон жүдо бөхийн багш дасгалжуулагч Тадаши нар манай сургууль дээр 2022 оны 10 сард айлчилж хамтарсан бэлтгэл хийсэн . Мөн 2023 оны 09 дүгээр сарын 7-9-ний хооронд “Такенори Шимузи Жүдо – Кап-2023”

тэмцээнийг хамтран зохион байгуулж хамтарсан бэлтгэл хийсэн. Одоо тус сургуулийн 120 жилийн ойн арга хэмжээнд оролцохоор манай сургуулийн төлөөлөгчид урилгаа аваад байна.

**7.** БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны “Монгол Бридж Групп”-тэй 2022 оны 3 сараас хамтран ажиллаж байна.Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд одоогийн байдлаар тус орны 28 оюутан манай сургуульд магистрантаар суралцаж байгаагийн 15 оюутан нь 2023 оны 6 сард магистрын зэргээ хамгаалаад буцсан.

**8.** ОХУ-ын Якутскийн Саха хотын “Чурапчинскийн Биеийн Тамир, Спортын Дээд Сургууль”-тай 2022 оны 10 сарын 26-нд гэрээгээ дахин шинэчлэн хамтран ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд 2 оюутан магистрын хөтөлбөрөөр сурч байгаа.

**9.** М.К.Аммосовагийн нэрэмжит Якутын Улсын Их сургуультай 2022 оны 10 сард уулзан хамтын ажиллах гэрээгээ сунган ажиллах талаар уулзалт зохион байгуулсан.

**10.** ОХУ-ын Улаан-Үдийн “Доржи Банзарова”-гийн нэрэмжит Бурядын Их Сургуультай 2023 оны 3 дугаар сарын 23-нд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.

**Дээрх байгууллагуудтай хамтарч ажилласнаар дараах үр дүнд хүрч байна.**

- Багш нар тодорхой хугацаанд гадаадын их сургуульд сургалтад хамрагдсанаар тэдний мэргэжлийн мэдлэг чадвар дээшилж, заадаг хичээлийн нь хөтөлбөрийн агуулга, арга зүй сайжирч байна.
- Багш нарын судалгааны ажлын чадвар дээшилж, олон улсын нэр хүндтэй зөвшөөрөгдсөн сэтгүүлүүдэд хамтарсан судалгааны өгүүлэл, төслийн үр дүнгийн талаар хэвлүүлэх боломж нээгдсэн.
- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Япон, БНСУ-ын Биеийн тамир, спортын Их сургуулиудаас Жүдо бөхийн иж бүрэн татами, Таеквондо дэвжээгээр хөрөнгө оруулалт хийсэн.
- 2019 онд Японы Хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтарсан эрдэм шинжилгээний төсөлт ажлын хүрээнд СБД-ийн 11 сургуулийн биеийн тамирын багш нарт тус бүр 50%-н сургалтын төлбөрийн хөнгөлөлт тэтгэлэгт хамруулсан, бөгөөд сургуульд нь иж бүрэн хөгжим хандивласан байдаг.

**Дээрх сургуулиудтай хамтарч ажилласнаар дараах үр дүнд хүрч байна**.

- Багш нар урт, богино хугацаагаар гадаадын сургалтад хамрагдсанаар тэдний мэргэжлийн мэдлэг, чадвар дээшилж, багш нарын хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүй сайжрах болсон.
- ҮБТДС-нь БМДИ-тэй хамтран ЕБС-ийн биеийн тамирын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж ирсэн уламжлал, туршлагатай билээ.Боловсролын хүрээлэн тэйхамтран "Монгол хүүхдийн шалгуур үзүүлэлт" төсөлд хамтран орецож судалгааны удирдамжаар зөвлөгөө семинар зохион .байгуулж байсан
- ҮБТДС-нь хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд, Шилдэг хичээлийн хөтөлбөр шалгаруулах аян, Шилдэг судлаач багш, шилдэг

залуу судлаач багш, Оны шилдэг оюутныг шалгаруулах аян зэрэг арга хэмжээнүүдийг санхүүгийн талаар болон материаллаг, моралийн чиглэлээр бүх талаас нь байнга дэмжин ажиллаж ирсэн.

- ҮБТДС-ийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг зохицуулагчаар тус сургуулийн 2009 оны төгсөгч, Д.Өлзийжаргал ажиллаж байна. Одоогоор ҮБТДС-ийн төгсөгчдийн facebook-ийн групп ажиллуулж, судалгаа, санал, хүсэлтийг хүлээн авч байна. Төгсөгчид маань төгсөгчдийн дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, давтан сургалтад хамрагдах хүсэлтэйгээ илэрхийлж, цаашид дэмжин ажиллахыг хүсдэг. Цаашид Төгсөгчдийн холбоог албан ёсны дарга, удирдлагатай байгуулах шаардлагатай гэж үзэж, Сургалтын алба болон хөтөлбөрийн алба, оюутны зөвлөл хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гэрээтэй, дотоодын болон гадна судалгааны нэгж байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.
- ҮБТДС-ийн Биеийн тамирын сургууль гадаад, дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон хувийн байгууллагатай хамтран ажиллаж багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинарыг зохион байгуулж ирсэн.
- Багш нарын судалгааны ажлын чадвар дээшилж, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хамтарсан судалгааны өгүүлэл хэвлүүлэх эхлэл тавигдсан.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд дотоодын их дээд сургууль, мэргэжлийн бусад байгууллагуудтай холбогдох судалгаа-хөгжүүлэлтийн ажил эрхлэх, хэлэлцүүлэг, хурал зөвлөгөөн зохион байгуулах, мэдээлэл солилцох, салбарын албан хаагчдыг чадавхжуулах, оюутны хөгжлийг хангах, дадлагажуулах, хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжүүлэх харилцан дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр 10 гаруй байгууллагатай хамтран ажиллаж байна.
- Тус сургуулийн багш нар хөл бөмбөг, гимнастик, волейбол, сагсан бөмбөг, чөлөөт бөх, хөнгөн атлетикийн спортын холбоодын удирдах зөвлөл, шүүгчийн зөвлөлд гишүүнчлэлтэй байгаа нь тухайн холбоодын хэрэгцээ, шаардлагыг мэдэрч, тэдэнд нийцсэн хичээлийн хөтөлбөр боловсруулах, сайжруулах, тус холбооноос магистрантууд олноор элсэх, төгсөх зэрэг ихээхэн ач холбогдолтой юм.

### 3.7 Магистрын ажлын хамгаалалт

*Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м)-ийг магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.*

***Магистрын ажлын хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилдог байдал***

ҮБТДС-ийн “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-тэй бөгөөд энэхүү дүрэм журмын дагуу магистрын зэрэг хамгаалуулах үйл ажиллагаа явагддаг. Тухайлбал, 2021 оны 01-р сарын 27-ны өдрийн ҮБТДС-ийн Магистрын зэрэг хамгаалуулах комиссын хурлын хурлын тогтоолыг үндэслэн, захирлын тушаалаар магистрын зэргийг олгодог. Зураг 3.4., 3.5.



ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 27 өдөр | Дугаар 004 | Улаанбаатар хот

Магистрын зэрэг олгох тухай

ҮБТДСургуулийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. ҮБТДС-ийн магистрантурт 2019-2021 онд суралцаж магистрын зэрэг горилсон ажлаа амжилттай хамгаалсан магистрантуудад “Багш, биеийн тамирын боловсрол”, “Спортын дасгалжуулагч”-ийн магистрын зэрэг олгож нэрсийг хавсралтаар батлсугай.

Хоёр. Магистрын зэрэг хүртэгсдэд магистрын диплом, энгэрийн тэмдэгийн хамт олгохыг магистрын алба /Л.Гүндэгмаа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Магистрын зэрэг хүртэгсдэд баяр хүргэж цаашдынх нь эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь өндөр амжилт хүссүгэй.

ЗАХИРАЛ | ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР Л.АЛТАНЦЭЦЭГ

NATIONAL INSTITUTE OF PHYSICAL EDUCATION УХД 0157



ҮБТДС-ийн 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 004 тоот тушаалын хавсралт

2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МАГИСТРЫН ЗЭРЭГ ОЛГОХ ОЮУТНУУДЫН НЭРС

| | Овог | Нэрс |
|---|---|---|
| 1. | Хүрэлбаатар | Анхбаатар |
| 2. | Мөнх-Эрдэнэ | Бадамхонд |
| 3. | Бууч | Эрдэнэтогтох |
| 4. | Бор | Батбаяр |
| 5. | Ганбат | Бат-Эрдэнэ |
| 6. | Улаанхүү | Цэрэнбаатар |
| 7. | Батсайхан | Одгэрэл |
| 8. | Умбаахүү | Лхам-Эрдэнэ |

*Зураг 3.4 ҮБТДС-ийн захирлын магистрын зэрэг хамгаалуулах комиссын хурлын тогтоол*



ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН МАГИСТРИЙН ЗЭРЭГ ХАМГААЛУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр | № 002 | Улаанбаатар хот

Багш, биеийн тамирын боловсрол, спортын дасгалжуулагч мэргэжлээр магистрийн зэрэг хамгаалах оюутнуудыг магистрийн хамгаалалтанд оруулсан тухай

Шалгалтын комиссын хуралдааныг Доктор (ScD), профессор Л.Алтанцэцэг даргалав.

Хуралдаанд орлогч дарга Доктор (PhD), профессор Л.Гүндэгмаа, нарийн бичгийн дарга Доктор (PhD) Д.Баасанхүү, гишүүд, Доктор (PhD), профессор Д.Бордух, Доктор (PhD) Р.Ганбаатар, Доктор (PhD) Ц.Оюунбат, Доктор (PhD) Ш.Долгор, Доктор (PhD) Р.Түвшинжаргал нар оролцов.

Диплом хамгаалалт 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11 цаг 00 минутаас эхлэж 12 цаг 30 минутанд дуусав.

Диплом хамгаалалтанд нийт ...... магистрант шалгагдахаас ........ шалгагдаж дор дурьдсан үнэлгээг авлаа

Үүнд: A ..........
B ..........
C..........
D ..........
F ..........



| | |
|---|---|
| Комиссын дарга: | Доктор (ScD), профессор Л.Алтанцэцэг |
| Орлогч дарга: | Доктор (PhD), профессор Л.Гүндэгмаа |
| Нарийн бичгийн дарга: | Доктор (PhD) Д.Баасанхүү |
| Гишүүд: | Доктор (PhD), профессор Д.Бордух |
| | Доктор (PhD), профессор Р.Ганбаатар |
| | Доктор (PhD), профессор Ц.Оюунбат |
| | Доктор (PhD), дэд профессор Ш.Долгор |
| | Доктор (PhD) Р.Түвшинжаргал |

*Зураг 3.5 ҮБТДС-ийн захирлын тушаал*

Сүүлийн 5 жилд 87 магистрантын 100% нь судалгааны магистрын зэрэг хамгаалсан. 2020-2022 онуудад “Ковид” цар тахлын улмаас магистрын сургалт онлайнаар зохион байгуулах болсонтой холбоотойгоор ӨМӨЗО-ны олон оюутнууд элссэн.

***Магистрын ажил хамгаалахад тусгай шалгуур, шаардлага байдаг эсэх***

ҮБТДС-ийн магистрын сургалтын журамд зааснаар магистрын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээ, онол, арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, тухайн асуудлын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн дүгнэлт зэрэг үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

Магистрын ажил нь төсөл, нэг сэдэвт бүтээл байж болох ба энэ тохиолдолд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо хэрэгжүүлэх арга зам, хүлээгдэж буй үр дүнг тодорхой томьёолж, туршилт судалгаа хийсэн байна.

Магистрын зэрэг горилсон бүтээлийг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцэж хамгаална. Урьдчилсан хамгаалалтыг тэнхимийн өргөтгөсөн их семинараар хийнэ. Өргөтгөсөн их семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколыг хамгаалуулах зөвлөлд хүргэсний дараа хамгаална.

Шалгалтыг ҮБТДС-ийн захирлын тушаалаар байгуулсан 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна. Тус шалгалтад хангалттай үнэлгээ авч чадаагүй бол хамгаалалтад орох эрхгүй болох ба төлбөртэйгөөр дараагийн улиралд дахин шалгалт өгч болно.

Магистрын ажлаа хамгаалж чадаагүй бол хоёр жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтад орох хүсэлтээ магистрант хамгаалуулах зөвлөлд гаргаж болно.

***Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах мэдээлэл, удирдамж, дүрэм нь магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдаг эсэх***

Магистрант нь сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийг бүрэн судалж зохих кредитийг цуглуулсан, гадаад хэлний шалгалтыг амжилттай өгсөн, сургалтын төлбөрийг бүрэн төлсөн, судалгааны ажлаа мэргэжлийн тэнхимээр урьдчилан хэлэлцүүлсэн, бүтээлийн хуулбарлалтыг шалгах программаар уншуулж зохих шаардлага хангасан зэргийг үндэслэн хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга магистрантын судалгааны ажлыг хамгаалуулах зөвлөлд уламжилна. Их семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Хамгаалуулах зөвлөлийн хуралдаан хичээлийн жилд хоёр удаа болох ба тухай бүрд тэнцсэн эсэх талаар тогтоол гаргана.

Магистрын ажил хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах талаар ҮБТДС-ийн сургалтын журамд тодорхой заасан байдаг ба энэхүү журам нь оюутны веб файл хэлбэрээр байршдаг. Мөн хөтөлбөрийн албаны магистр хариуцсан мэргэжилтэн хамгаалуулах зөвлөлийн хуралдааны зарыг оюутны веб болон wechat аппликейшн ашиглан түгээдэг.

Хамгаалуулах зөвлөлийн нарийн бичиг магистрын хамгаалалтын хуралд хэрхэн бэлтгэх, танилцуулга (PPT) ямар бүтэц, агуулгатай байх талаар мэдээлэл бэлтгэн онлайнаар болон биечлэн зөвлөгөө өгч ажилласаар ирсэн.

**3.8 Төгсөлтийн баримт бичиг**

*Төгсөгчид, суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.*

***Төгсөлтийн баримт бичгийг батлагдсан дүрмийн дагуу олгодог байдал***

Хөтөлбөрийг бүрэн судалсны эцэст төгсөлтийн үйл ажиллагааны зохицуулалтыг ҮБТДС- ийн магистрын сургалтын журам”-ын 12-д тусгайлан оруулсан байна.

“Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг амжилттай судалж, 30-аас доошгүй кредит цуглуулсан, сургалтын төлбөрөө төлсөн, магистрын судалгааны ажлаа хамгаалуулах зөвлөлд амжилттай хэлэлцүүлсэн (ҮБТДС-ийн сургалтын журмын 12-14 заалт) магистрантад ҮБТДС-ийн магистрын зэрэг олгоно.

ҮБТДС-ийн сургалтын журмын 12-14 заалтад Магистрын судалгааны ажлаа амжилттай хамгаалсныг баталсан Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ҮБТДС-ийн захирлын тушаалаар магистрын зэрэг олгох шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг үндэслэн ҮБТДС магистр зэрэг олгосон дипломыг бичиж, гардуулах ажлыг зохион байгуулдаг. Магистрын зэрэг олгох төгсөлтийг хичээлийн жилд хоёр удаа буюу 1 ба 6-р сард хийдэг.

Төгсөлтийн дараах бичиг баримтад, төгссөн магистрантуудын нэрс, дүнгийн хавтгай, дипломын нүүр (хувилсан), дипломын хавсралт (хувилсан), суралцах эрхийн бичиг зэргийг хавсарган архивд хүлээлгэн өгдөг.

Хөтөлбөрийн албаны мэргэжилтэн магистрантуудын бичиг баримтыг 2014 оноос хойш цахимд оруулан, цаасаар давхар баримтжуулан, он дараалаар нь цэгцэлж сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Магистрын төгсөлт жилд өвөл, хавар 2 удаа зохион байгуулагддаг. Сургалтын төлөвлөгөөний дагуу 26-30 кредит хичээлийг бүрэн судалж 71 С-ээс дээш үнэлэгдсэн магистрант судалгааны ажлын 8 кредит сонголтыг сүүлийн улиралд сонгож 2 шатны хамгаалалтад орж 75 С-ээс дээш үнэлгээтэйгээр амжилттай хамгаалж чадсан тохиолдолд ҮБТДС-ийн ректорын төгсөгчдөд магистрын зэрэг олгох тушаал гардаг.




*Зураг 3.6 “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн тоо*

Хамгаалалтад орж төгсөх боломжтой болсон магистрантад ахисан түвшний хөтөлбөрийн албанаас баталсан тойрох хуудсыг зуруулдаг. /Тойрох хуудсыг хавсралт хэсэгт оруулав./

Төгсөлтийн улирал бүрд Сургалтын удирдлага мэдээллийн системээс хэвлэгдэж, гарын үсэг тамгаар баталгаажсан магистрын дипломын нүүр болон дүнтэй хавсралтыг хуулбарлаж ҮБТДС-ийн архивын эрхлэгч Б.Пүрвээ-л архивлан хүлээлгэж өгдөг.

***Төгсөлтийн баримт бичгийн баяжилт, албажуулалд нь олон улсын жишигт нийцсэн байдал***

Магистрын диплом нь ҮБТДС-ийн Удирдах зөвлөлийн дарга, ҮБТДС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга буюу сургалт эрхэлсэн дэд захирал,

бүрэлдэхүүний сургуулийн захирлын гарын үсэг, ҮБТДС-ийн тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байна. Диплом хавсралттай байх бөгөөд түүнд эзэмшсэн үндсэн болон хавсарга мэргэшил, суралцах хугацаанд судалсан хичээлүүд, тэдгээрийн кредит, судалгааны ажлын сэдэв, судалгааны ажлын дүн, голч дүн, оноог бичихээс гадна эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцүүлэн бусад бичиглэлийг хийдэг.

Дипломын загвар нь БШУЯ-наас гаргасан загварын дагуу монгол, англи, уйгуржин монгол гурван хэлээр хэвлэгдэн гардаг. /Загварыг хавсаргав. /

Дипломын хавсралтыг ҮБТДС-ийн хөтөлбөрийн нэгдсэн алба болон бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албаны даргын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулах ба хавсралт нь дипломын хамт хүчинтэй. Дипломын хавсралтыг 2014-2016 онд монгол – англи хэлээр; 2017 оноос монгол – англи – уйгуржин бичгээр хэвлэдэг болсон.


МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛЬ
МАГИСТРЫН ДИПЛОМ
Дугаар:7202504493

Монгол улсын иргэн Эрдэнэчулуун овогтой Рэнцэн-Очир нь БИЕИЙН ТАМИРЫН БОЛОВСРОЛ E011410 хөтөлбөрөөр суралцан төгссөн тул захирлын 2025 оны 06 сарын 10-ны өдрийн 28 тоот тушаалаар БИЕИЙН ТАМИРЫН БОЛОВСРОЛЫН МАГИСТР зэрэг олгов.

Сургуулийн захирал
Доктор(Sc.D), профессор
Л.Алтанцэцэг

7202504493
Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛЬ
7202504493 дугаартай магистрын дипломын хавсралт
Бүртгэлийн дугаар: 519

Эцэг/Эх/-ийн нэр: Эрдэнэчулуун
Нэр: Рэнцэн-Очир
Регистр: УП97010636
Хөтөлбөрийн нэр: Биеийн тамирын боловсрол
Төрөлжсөн чиглэл: 011 Боловсрол
Өмнөх зэргийн дипломын дугаар: D202110193
Төгссөн он: 2025
Тушаалын дугаар: 28

| № | Судалсан хичээлийн нэр | Кредит цаг | Сурлагын Оноо | Сурлагын Дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Шинжлэх ухааны судалгааны аргазүй | 2 | 90 | A |
| 2 | Биеийн тамирын шинжлэх ухааны онол аргазүй | 3 | 95 | A |
| 3 | Боловсрол судлалын үндэс | 3 | 84 | B |
| 4 | Бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн боловсрол | 2 | 85 | B |
| 5 | Боловсролын философи | 3 | 80 | B |
| 6 | Биеийн тамир боловсролын менежмент | 2 | 95 | A |
| 7 | Биеийн тамирын боловсролын сэтгэл зүйн үндэс | 3 | 86 | B |
| 8 | Биеийн тамирын боловсролын онол арга зүй | 4 | 90 | A |
| 9 | Магистрын судалгааны ажлын арга зүй, зохион байгуулалт | 3 | 88 | B |
| 10 | Магистрын ажил | 5 | 94 | A |

Магистрын төгсөлтийн ажил /диссертацийн нэр: "АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН ДУНДАХ СТРЕССИЙН ТҮВШИНГ ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭТЭЙ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ"

Нийт багц цаг: 30 Голч дүн: 3.5 Сургалтын хэл: Монгол

Сургуулийн дэд захирал
Доктор (Sc.D), профессор
Л.Гүндэгмаа

Энэхүү хавсралт 2025 оны 7202504493 дугаартай дипломын хамт хүчинтэй

*Зураг 3.7 “Биеийн тамирын боловсрол” магистрын дипломын нүүр, хавсралт*

***Төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагааны хяналт***

ҮБТДС-ийн магистрын диплом олголт нь МУ-ын БШУЯ-ны шийдвэр, дүрэм журам хуулийн хүрээнд явагддаг үйл ажиллагаа юм. Магистрын диплом дээр бичих мэдээллүүдийг ҮБТДС-ийн хөтөлбөрийн алба бэлтгэдэг. Дипломын үнэт цаасыг БШУЯ-ны зөвшөөрөлтэй тусгай эрх бүхий компаниуд бэлтгэдэг.

Төгсөгчийн мэдээлэл, дипломын дугаар нь БШУЯ-ны ДБУМС-д https://www.hemis.edu.mn/ бүртгэгдэх бөгөөд төгсөгчийн бичиг баримт, мэдээллийг цахим хэлбэрээр шалгах боломжтой. 2022-2023 оны хаврын улирлаас эхлэн бүх төгсөгчдийн дипломын цахим хуулбарыг цахим архивын нэгдсэн систем болох www.certify.mn блокчэйнд байршуулдаг болсон бөгөөд e-mongolia платформ системд мөн бүртгэгдэх болсон.

### 3.9 Шалгуур 3 SWOT, TOWS шинжилгээ

| Давуу тал/S | Сул тал/W |
|---|---|
| • Ил тод, шударга үнэлгээний систем: Суралцагчийн гүйцэтгэлийг ил тод, шударгаар үнэлдэг бөгөөд суралцахуйн үр дүнг хангах дэмжлэгийг үзүүлдэг.<br>• Шинэлэг үнэлгээний арга: Үнэлгээний олон хэлбэрийг ашиглан суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.<br>• Дэмжлэг, зөвлөх үйлчилгээ: Суралцагчдын сургалтын явцад үзүүлж буй зөвлөн туслах | • Сурлагын ахиц, амжилтад дүн шинжилгээ хийж, үр дүнг нь ашиглах үйл ажиллагаа дутмаг байна.<br>• Суралцагчдын оролцооны хязгаарлалт: Бага хэмжээний суралцагчид хамрагдсан байж болох бөгөөд, зөвлөн туслах үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байх |

| | |
|---|---|
| болон санхүүгийн дэмжлэг үйлчилгээ нь суралцахуйд дэмжлэг үзүүлж, хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.<br>• Гадаад, дотоод хамтын ажиллагаа: Багш нар болон магистрантууд олон улсын болон дотоодын хамтын ажиллагааны хүрээнд боловсрол, судалгаа, сургалтын амжилттай хамтран ажилладаг.<br>• Магистрын ажил хамгаалах, төгсөлтийн баримт бичиг олгох ажил журмын дагуу, ил тод, нээлттэй зохион байгуулагддаг. | магадлалтай - . Магистрант, багш нарын шилжилт: Багш нар болон магистрантуудын шилжилт хөдөлгөөн нь хөтөлбөрийн тасралтгүй байдлыг алдагдуулж магадгүй. |
| **Боломж/O** | **Эрсдэл/T** |
| • Олон улсын түншлэл: Олон улсын их дээд сургуулиудтай хамтран суралцагч солилцоо, судалгаа хийх боломж нь сургалтын чанарыг сайжруулахад тусална.<br>• Багш биеийн тамирын боловсрол бакалаврын голч хангасан оюутныг магистрт элсүүлэх замаар тэтгэлэгтэй суралцах магистрын тоог нэмэх.<br>• Эрдэм шинжилгээ инновацын албанаас хэрэгжүүлэх төслийн тендерт оролцож, магистрын судалгааны ажлыг санхүүжүүлэх. | • Оюутны үнэлгээнд бичгийн сорилыг их ашиглах нь олон мэдээллийг цээжилж тогтоох шаардлагатай болох учраас багш боловсролын шинэчлэлийн үзэл санааны хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.<br>• Эдийн засгийн хямрал: Санхүүгийн хязгаарлалтууд нь сургалтын төсөв болон үүний дагаад судалгааны төсөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх боломжийг хязгаарлах магадлалтай.<br>• Өрсөлдөөн: Бусад сургуулиуд болон хөтөлбөрүүдийн өрсөлдөөн нь суралцагчдын татах болон оролцоог бууруулах эрсдэлтэй. |
| **OS стратеги** | **OW стратеги** |
| • Бакалаврын оюутнуудын дунд хэрэгцээний судалгаа зохион байгуулж, магистрантын тоо болон тэтгэлэгт хамрагдан суралцах боломжийг бүрдүүлэх стратеги хэрэгжүүлэх.<br>• Олон улсын хамтын ажиллагаа: Хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, гадаадын их сургуультай эрдэм шинжилгээний төсөлд хамтран оролцож, магистрантуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх.<br>• Дижитал сургалтыг хөгжүүлэх: Технологийн шинэчлэл, онлайн платформуудыг ашиглан, сургалтын ачааллыг зохистой хуваарилж, үр дүнг дээшлүүлэх. | • ҮБТДС-ийн дотоод санхүүжилтээр магистрын судалгааны ажил, хамтын үйл ажиллагааг дэмжих стратеги боловсруулах<br>• Шинэчлэл хийх: Сургалтын орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд дижитал сургалт, онлайн платформуудыг хөгжүүлэх замаар боломжуудыг ашиглах. |
| **TS стратеги** | **TW стратеги** |

| | |
|---|---|
| • Хичээл хоорондын интеграцийг хангасан бие даалтын ажлын тоог нэмэгдүүлэх.<br>• Сонгон судлах хичээлийг спортын тодорхой төрлийн онол, арга зүйгээр гүнзгийрүүлэн судлах хэлбэрээр өргөжүүлэх.<br>• Санхүүгийн эх үүсвэр нэмэгдүүлэх: Эдийн засгийн хямралыг даван туулахын тулд гадаад хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээг өргөжүүлж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх. | • Хичээл бүрийн хөтөлбөрийг байнга сайжруулахдаа: явцын үнэлгээний даалгаврыг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй нягт уялдуулах, мэргэжлийн сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлэх, оюутан бие дааж суралцах, хамтран мэдлэг бүтээх арга зүйн шинэчлэлийг дэмжих зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх.<br>• Оюутны үнэлгээний статистик үзүүлэлтийг тогтмол шинжилж, "C" үнэлгээнээс доогуур үнэлэгдсэн шалтгааныг олж тогтоох |

### 3.10 Сайжруулах арга зам

Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийн "Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил"-д өөрийн үнэлгээ хийсний дүнд сул талуудыг үндэслэн сайжруулах арга зам, үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Магистрантуудыг судалгааны баг бүрдүүлэх, төсөл хөтөлбөрт оролцуулж, хамтран гүйцэтгэх.
- Сургууль, тэнхимийн тэргүүлэх, хавсарга судалгааны чиглэлээр судалгаа хийх, үр дүнд суурилан магистрын дипломын ажил хамгаалуулах.
- Е-сорилын даалгаврын тавилыг сайжруулж, бүтээх, үнэлэх түвшний даалгаврыг илүү тодорхой хэрэглэх, явцын үнэлгээнд Е-сорилыг ашиглах тоог нэмэгдүүлэх.
- Дижитал сургалтыг хөгжүүлэх: Технологийн шинэчлэл, онлайн платформуудыг ашиглан, сургалтын ачааллыг зохистой хуваарилж, үр дүнг дээшлүүлэх.

### 3.11 Үнэлгээ

Хүснэгт 3.6 Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжилд хийсэн өөрийн үнэлгээ

| Шалгуур | Үзүүлэлт | Хэмжээс | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 3.1 | Магистрантын үнэлгээнд үнэлгээний олон төрөл, хэлбэрийг ашигладаг эсэх | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг хангаан тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг<br><br>**Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан | **Хангалттай сайн** |
| | Үнэлгээ нь ил тод, үнэлгээг тасралтгүй сайжруулахад чиглэсэн эсэх | | |
| 3.2 | Өөр сургууль, хөтөлбөрөөр суралцсан суралцагчдын үр дүнг хүлээн зөвшөөрдөг эсэх | | **Хангалттай сайн** |
| | Холбогдох дүрэм журам нь суралцагчийн эрх ашигт нийцсэн эсэх | | |
| 3.3 | Магистрантад дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг | | **Хангалттай сайн** |

| | | | |
|---|---|---|---|
| | тогтмол үзүүлдэг эсэх | **Сайжруулах шаардлагатай:**<br>Нэг үзүүлэлтийг хангасан<br><br>**Хангалтгүй:**<br>Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | |
| | Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагчдын ялгаатай хэрэгцээ, шаардлага (тусгай хэрэгцээ, гадаад оюутан г.м)-ыг хангадаг эсэх | | |
| **3.4** | Магистрын судалгааны ажлыг санхүүжүүлдэг байх | | **Хангалттай** |
| | Санхүүжүүлэх үйл ажиллагаа нь ил тод, бодлого журмын дагуу хэрэгждэг эсэх | | |
| **3.5.** | Магистрантад тэтгэлэг олгох журам дүрэм үйлчилдэг байх | | **Хангалттай сайн** |
| | Сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг олгох нөхцөл, болзолтой эсэх | | |
| **3.6.** | Хөтөлбөрийн түвшинд байгууллага, их сургуультай гэрээтэй ажилладаг эсэх | | **Хангалттай сайн** |
| | Багш магистрантууд судалгааны багт оролцдог эсэх | | |
| **3.7.** | Магистрын хамгаалах зөвшөөрөл олгох шалгуур ойлгомжтой байх | | **Хангалттай сайн** |
| | Магистрын ажил хамгаалах журам, үйл явц тодорхой, ил тод байх | | |
| **3.8.** | Төгсөлтийн баримт бичиг 3 хэлээр бичигдсэн байх | | **Хангалттай сайн** |

### 3.12 Дүгнэлт

Биеийн тамирын боловсролын "Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил" шалгуурын дагуу өөрийн үнэлгээнд суурилан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Магистрын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, магистрантын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны өөрийн үнэлгээний бүх шалгуурыг хангалттай сайн хэрэгжүүлж байна.
2. Магистрын ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, хамтын судалгааны баг бүрдүүлэх, төсөл хөтөлбөрт магистрантуудыг оролцуулж ажиллахад анхаарах шаардлагатай.

## ШАЛГУУР 4. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

### 4.1 Багшийн нөөц

*Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш судлаачийн нөөцтэй байна. Багш, магистрантын тооны харьцааг зохистой тогтоосон байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулах боломжийг бүрдүүлсэн байна.*

**Багшийн сонгон шалгаруулалт.** Тус сургууль мэргэшсэн, өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэхдээ Захирлын 2016.06.10 өдөр баталсан "ҮБТДС-ийн дотоод журам" -ын 2.1.-2.8-р заалт, "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-т үндэслэн сонгон шалгаруулалтыг явуулдаг. Ажлын байрны шаардлагад нийцсэн боловсрол, мэргэжлийн түвшин, мэргэжлийн авьяас сонирхол, хувийн соёл, зан харилцаа, нийгмийн идэвх, ажил үүрэг гүйцэтгэх чадамж (эрүүл мэнд) ёс суртахууны байдлыг харгалзан явуулдаг бөгөөд жилээс жилд сонгон шалгаруулалтад оролцогчдын чадвар сайжирч, ажил олгогчдын ажлын байрны шаардлагыг хангаж байна. Нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар сургуулийн хүний нөөцийн бүрдүүлэлт, эрх зүйн хэм хэмжээнд чанартай явагдаж байна гэж дүгнэж байна.

Гадаадын их сургуулиудын туршлагаас харахад их дээд сургуулиудын багшийг сонгон шалгаруулж авах үзүүлэлтүүдээс улс орон бүрийн нийтлэг шаардлага байгаа ч багшийн ур чадвараас гадна хүн хүмүүжүүлэх үүрэг, харилцааны ур чадварыг харгалзан үзэхийг чухалчилжээ.

Манай сургууль ч энэ үзүүлэлтийг боловсон хүчнээ сонгох үндсэн үзүүлэлтийн нэг болгон үздэгээс гадна нийт багш нар дараах шаардлагыг хангасан байх ёстойг сургуулийн багшид тавигдах шаардлагатаа тодорхой тусгасан. Тухайлбал, багш сонгон шалгаруулах зард дараах шалгууруудыг заадаг.

**Тавигдах шаардлага:**

- Мэргэжлийн сургуулийг төгссөн, дээд боловсролын хуульд заасан, Доктор түүнээс дээш боловсролын зэрэгтэй
- Англи хэл, компьютерын дундаас дээш түвшний мэдлэгтэй

Туршлага

- ЕБСургуульд багшилж байсан бол давуу тал болно
- Спортын өндөр зэрэгтэй бол давуу тал болно /мэргэжлийн хичээлээр/

Ур чадвар

- Багаар ажиллах чадвартай
- Хүмүүсийг сонсох, ойлголцох, нээлттэй харилцах, хамтран ажиллах чадвартай, ажилд хариуцлагатай хандах чадвартай

**Ажилд орохыг хүссэн багш, ажилтан, ажилчид доорх бичиг баримтыг бүрдүүлнэ.**Үүнд:

а. Ажилд орохыг хүссэн өргөдөл

б. Биеийн байцаалт (маягт №1), товч намтар
в. Иргэний үнэмлэх (хуулбар)
г. Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар
д. Боловсролын диплом
е. Мэргэжлийн гэрчилгээ, зэрэг цолны үнэмлэх
ж. Бүтээлийн жагсаалт (зөвхөн багш, ажилтан)

**Багшлах бүрэлдэхүүн**

Хүснэгт 4.1 Багш нарын албан тушаалын ангилал

| № | Багшийн ангилал | Хичээлийн жил | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 | 2024-2025 |
| 1 | Нийт үндсэн багш | 23 | 23 | 26 | 24 |
| 1.1. | Доктор, профессор зэрэгтэй үндсэн багш | 5 (21.8%) | 9 (39.19%) | 9 (34.6%) | 10 (41.6%) |
| 1.2. | Дэд профессор, ахлах багш | 7 | 5 | 5 | 8 |
| 1.3. | Магистр, багш | 11 | 9 | 12 | 6 |

Дээрх хүснэгтээс үзэхэд ЗГ-ын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 253 дугаар тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-д заасны дагуу багш, магистрантын харьцааг зохистой түвшинд байгаа нь харагдаж байна.

Тус сургууль дараах багшлах бүрэлдэхүүнтэйгээр (Зураг 4.2 А Багшлах бүрэлдэхүүн) сургалт хүмүүжлийн үндсэн үйл ажиллагааг явуулж ирсэн бөгөөд эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь 41.6% болж өссөн үзүүлэлттэй байна (Зураг 4.2 Доктор зэрэгтэй багшийн эзлэх хувь). Мөн мэргэжлийн ур чадвар сайтай багш сонгон ажиллуулах бодлого баримталдаг. Жишээ нь: Давхардсан тоогоор доктор зэрэгтэй 10 багш үүнээс шинжлэх ухааны доктор 2, спортын олон улсын хэмжээний мастер 8 үүнээс Гавьяат дасгалжуулагч 1, олон улсын дасгалжуулагч 1, докторант 2, спортын мастер 5, спортын 1-р зэрэгтэй 2 багш сурган хүмүүжүүлэгч, дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Хүснэгт 4.2 Багшлах бүрэлдэхүүн

| Овог нэр | Эрдмийн цол, зэрэг | Албан тушаалын зэрэглэл | Ажилласан жил | Заадаг хичээлийн нэр | Мэргэжлийн чиглэл |
|---|---|---|---|---|---|
| Л.Алтанцэцэг | Доктор ScD | Профессор | 35 | Шинжлэх ухааны судалгааны арга зүй<br>Биеийн тамирын боловсролын онол арга зүй | 1. Биеийн тамирын багш<br>2. Спортын дасгалжуулагч |
| Л.Гүндэгмаа | Доктор ScD, | Профессор | 34 | Биеийн тамирын шинжлэх ухааны онол, арга зүй | 1. Биеийн тамирын багш<br>2. Спортын биохимич |
| Ц.Оюунбат | Доктор Ph.D | Профессор | 10 | Боловсрол судлалын үндэс<br>Боловсролын философи | Монгол хэл, уран зохиолын багш |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ш.Бат-Эрдэнэ | Доктор Ph.D | Дэд профессор | 24 | Эрүүд мэндийн боловсрол | Хүний их эмч |
| Н.Мягмарзул | Доктор Ph.D | Дэд профессор | 10 | Биеийн тамирын боловсролын менежмент | Менежмент |
| С.Зоригт | Доктор Ph.D | Ахлах багш | 2 | Биеийн тамир спортын сэтгэл судлалын үндэс | Сэтгэл судлал |
| Р.Ганбаатар | Доктор Ph.D | Профессор | 25 | Биеийн тамир спортын хэмжил зүй | Биеийн тамирын багш |
| Д.Жаргалсайхан | Доктор Ph.D | Профессор | 3 | Эрдэм шинжилгээ, судалгаа | Спортын дасгалжуулагч |
| Т.Ганчимэг | Доктор Ph.D | Дэд профессор | 3 | Эрдэм шинжилгээ, судалгаа | Хүний их эмч |
| Ш.Долгор | Доктор Ph.D | Ахлах багш | 10 | Эрдэм шинжилгээ, судалгаа | Багш |

Хүснэгт 4.3 Хөтөлбөрийн нэг багшид ноогдох магистрантын тооны харьцаа

| № | Хичээлийн жил | Үндсэн багшийн тоо | Гэрээт багшийн тоо | Нийт багшийн тоо | Нийт оюутны тоо | Үүнээс Багш, биеийн тамирын хөтөлбөрийн | Нийт багш оюутны харьцаа | Дундаж харьцаа | Үндсэн багш оюутны харьцаа | Дундаж харьцаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2011-2022 | 5 | 3 | 8 | **25** | 16 | 2,0 : 1 | 1,9:1 | 3,2 : 1 | 2,3:1 |
| 2 | 2022-2023 | 9 | 0 | 9 | **18** | 17 | 1,8 : 1 | | 1,8 : 1 | |
| 3 | 2023-2024 | 9 | 0 | 9 | **30** | 18 | 2,0 : 1 | | 2,0 : 1 | |
| 4 | 2024-2025 | 10 | 0 | 9 | **38** | 20 | 2,2 :1 | | 2,2 :1 | |

Биеийн тамирын боловсрол хөтөлбөрийн магистрантуудад ҮБТДС-ийн үндсэн багш А буюу сургалтын цагийн ачааллын 63.35%-ийг зарцуулдаг. Багш суралцагчдын харьцааг сүүлийн 5 жилээр нэгтгэвэл “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг үндсэн болон гэрээт нийт багшийн тоогоор харьцуулбал нэг багшид 1,9 магистрант ноогддог, үндсэн багшийн тоотой харьцуулбал 2,3 : 1 магистрант, ҮБТДС-ийн хэмжээнд нийт оюутан, үндсэн багшийн харьцааг дундажлавал нэг багшид 24.5 оюутан ноогдохоор байгаа нь багшийн ачаалал, хөтөлбөр хэрэгжих зохист түвшинд байгааг илтгэнэ. Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд багшийн сургалтын цагийн ачааллыг зохих журамд нийцүүлэн оновчтой тогтоохад тэнхим, сургалтын алба анхаарч ирсэн.

### 4.2 Багшлахуйн үнэлгээ

*Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний систем нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.*

***Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан, багш нарыг урамшуулдаг байдал***

Сургуулийн зүгээс багш нартаа дараах цалин хөлс, урамшуулал, гавьяа шагнал олгох, дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг дотоод журмаараа зохицуулдаг. Үүнд:

- Профессор, дэд профессор, ахлах багш цол олгох
- Боловсрол, эрүүл мэнд, спортын төв байгууллага, бусад байгууллагын шагналд тодорхойлох;
- Төрийн дээд шагнал, олон улсын байгууллагын шагналд тодорхойлох;
- Мөнгөн шагнал олгох, материаллаг урамшуулал үзүүлэх
- Эрдэмтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан сургуулийн захиргаатай гэрээ байгуулан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр нэг жил хүртэл хугацаагаар бүтээлийн чөлөө авч болох бөгөөд энэ хугацааны цалинг батлагдсан дүрэм, журам, сургуулийн дотоод журмын дагуу олгоно. Бүтээлийн чөлөөтэй байсан хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцдэг.
- Сургуулийн захиргаа багш, ажилчдад мэргэжил боловсролоо дээшлүүлэх, хүүхдээ болон өвчтөн асрах, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зэрэг шалтгаанаар нэг жил хүртэл хугацааны цалингүй (тэтгэмжгүй) чөлөө олгож болно.
- Түүнчлэн тус сургуулийн багш нар гадаад дотоодын, сургалт, спортын уралдаан тэмцээнд дасгалжуулагчаар, эмчээр, зөвлөхөөр ажиллах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах тохиолдол олноор гардаг бөгөөд энэ үед ҮБТДСургууль албан ёсны цалинтай чөлөө олгож дэмждэг

***Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, багшийн ажлын үнэлгээ***

ҮБТДСургуулийн Хөтөлбөрийн хороо, сургалтын алба, санхүүгийн алба, оюутны зөвлөл, тэнхим, профессор багш бүр ҮБТДСургуулийн хөгжлийн бодлого, ҮБТДС-ийн багш хөгжлийн хөтөлбөр дээр тулгуурлан, өөрсдийн ажлаа өмнөх хичээлийн жилийн эцэст хэлэлцдэг, ирэх хичээлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөж, тэрхүү төлөвлөгөөнд үндэслэн, тэнхимийн, ҮБТДС-ийн хичээлийн жилийн төлөвлөгөө боловсруулдаг.

Төлөвлөснөө хэрхэн биелүүлсэн тухайгаа эргээд улирлын төгсгөлд, хичээлийн жилийн эцэст, гурван жилд нэг удаа өөрийн үнэлгээний тайланг бичиж ажлаа дүгнүүлдэг уламжлал тогтсон. Багш ажлаа тайлагнахдаа: сургалтын талаар (A), эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар (B), бүтээлч ажлын талаар (C), бусад гэсэн чиглэлээр тайлангаа бичиж, тэнхимийн хамт олондоо хэлэлцүүлж цаашид хийх ажлаа төлөвлөдөг.

“ҮБТДС-ийн захирлыг 2006 оны 02-р сарын 10-ны өдрийн тушаалаар батлагдсан “ҮБТДС-н багшийн үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох журам” -ыг /Албан хөтөч 75-80-р хуудас/ үндэслэн багш нарыг үнэлж үздэг бөгөөд бүх багш A, B, C, цагийн нормыг жил бүр биелүүлж ирсэн. Зарим тохиолдолд тэмцээн уралдаанд их

цаг зарцуулан эрдэм шинжилгээний цаг биелээгүй тохиолдлууд байдаг. Үүнийг дараагийн жилд нь тухайн багш нь нөхөж гүйцэтгэдэг.

***Багшлахуйн үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлсэн байдал***

ҮБТДС-ийн захирлын 2024 оны -р сарын 10-ны өдрийн тушаалаар батлагдсан "ҮБТДС-н багшийн үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох журам" -ыг /Албан хөтөч 75-80-р хуудас/ үндэслэн багш нарыг үнэлж үздэг. Биеийн тамирын сургуулийн "Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багш болон магистрантуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дундаж үзүүлэлтийг сүүлийн хичээлийн жилээр гаргахад нийт 11 багш хамрагдсан ба 80-аас доош оноогоор үнэлэгдсэн багш байхгүй байна.

### 4.3 Багшийн хөгжил

*Багш нарын мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.*

Тус сургуулийн Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих зорилготойгоор Захирлын 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн тушаалаар баталсан "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийг албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. 2024 оны 9-р сарын 5-с "Багшийн хөгжлийн төв" албан ёсоор байгуулагдан ажиллаж байна.

"ҮБТДС-ийн багшийн ажлын үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох журам"-ын 2.3.2-ын дагуу 2020-2021 оны хичээлийн жилд Б.Мөнгөнтуяа, Р.Лхагвасүрэн, Д.Баасанхүү нар, 2023-2024 оны хичээлийн жилд Ц.Цэрэнгаваа, Д.Шүрэнцэцэг багш нар дэд профессор багшийн зэрэглэлд ажиллах болсон.

Хүснэгт 4.4 Багшийн эрдмийн цол зэргээ ахиулахад дэмжих бодлогын төлөвлөлт

| № | Хичээлийн жил | Багшийн нэр | Эрдмийн зэрэг, цол | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | 2023-2025 | С.Зоригт, Ш.Батэрдэнэ | Доктор Ph.D | Хамгаалсан |
| 2 | 2025-2027 | Ц.Баярсайхан, Э.Золжаргал, Элбэгзаяа | Доктор Ph.D | Судалгааны ажлаа хамгаалахад бэлдэж байгаа. |
| 3 | 2027-2029 | Р.Лхагвасүрэн, Б.Мөнгөнтуяа | Доктор Ph.D | Сургуульдаа бүртгүүлсэн |

Тус сургууль багшийн хөгжлийн төвийн төсвийг хичээлийн жил бүр тусгадаг (Хүснэгт 4.5).

Хүснэгт 4.5 Багшийн хөгжлийн төвийн төсөв

| 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 | 2024-2025 |
|---|---|---|---|
| 20 сая | 20 сая | 25 сая | 50 сая |

Хүснэгт 4.6 Судалгаа хийгдэн 2025-2026 оны хичээлийн жил хамтран ажиллах эрдэмтэн багш нар ажлын байрны төлөвлөлт

| № | 2025-2026 | Эрдмийн зэрэг, цол | Харьяалагдах тэнхим |
|---|---|---|---|
| **1** | Н. Долингор түүхийн багш | Түүхийн ухааны Доктор Ph.D | Онол арга зүй<br>Спортын түүх |
| **2** | Б.Билэгдэмбэрэл Тод манлай уяач | Хөдөө аж ахуйн ухааны Доктор Ph.D | Онол арга зүй<br>Морин спортын сургалт дасгалжуулалт |

Тус сургуулийн **2025-2030 оны стратеги төлөвлөгөөний 3-р зорилго нь**: "Багш, ажилтны чадавхыг тасралтгүй хөгжүүлж, бүтээлч хамт олны соёлыг төлөвшүүлэх" гэж тавьсан бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүллээ.




*Зураг 4.1 Хүний нөөцийн стратегийн зорилтууд*

Л.Гүндэгмаа ОХУ-ын Санкт-Петербург хотын Хүүхдийн Анагаах ухааны их сургуулийн Эрдмийн Зөвлөлд 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр Биологийн Шинжлэх ухааны докторын зэргээ "Монгол тамирчдын морфофункциональ онцлогийн бүрэлдэлт: нас зүй, орчны болон удамшлын хүчин зүйлээс хамаарах нь" сэдвээр хамгаалсан.

Онол арга зүйн Тэнхимийн багш С.Зоригт нь "Тамирчдын түгшүүрийг хянах сэтгэл зүйн бэлтгэл хөтөлбөрийн судалгаа" сэдэвт диссертацийн ажлаа МУБИС-ийн Сэтгэл судлалын тэнхимийн эрдмийн зөвлөлийн 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хурлаар ажилттай хэлэлцүүлэн докторын зэрэг хамгаалсан.

2025 онд тус сургуулийн БТЭАЗүйн тэнхимийн эрхлэгч, Хүний их эмч Ш.Бат-Эрдэнэ "Монголын өндөр зэрэгтэй тамирчдын морфофмзиологийн зарим үзүүлэлтүүдийн судалгаа" сэдэвт диссертацийн ажлаа АШУҮИС-н 2025 оны 02-р сарын 13-ны өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар амжилттай хэлэлцүүлж Анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Засгийн газрын багшийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд 2018 онд БСШУСЯ-ны сайдын тушаалаар Багшийн хөгжлийн хөтөлбөрийг баталсан. Энэ дагуу 2019 оны 12 сарын 28-нд багшийг үе шаттай хөгжүүлэх "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийг баталсан. Үүнийг үндэс болгон 2019-2020, 2021-2025 он хүртэлх дэс дараатай хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Хүснэгт 4.7 Мэргэжил дээшлүүлсэн багш нарын тоо

| Он | Дотоодод | Гадаадад |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 2019-2020 | 2 | 5 |
| 2020-2021 | 2 | 2 |
| 2021-2022 | 1 | 4 |
| 2022-2023 | 2 | 2 |
| 2023-2024 | 2 | 2 |
| 2024-2025 | 22 | 3 |

Багш нар боловсрол судлал болон мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодод мэргэжил боловсролоо дээшлүүлж ирсэн нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багшийн мэргэжлийн мэдлэг, чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ биеийн тамирын боловсролын олон улсын чиг хандлага, өөрийн орны боловсролын бодлого ҮБТДС-ийн бодлогод уялдуулан хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч, шинэ зууны мэргэжилтэн бэлтгэхэд чухал ач холбогдолтой байгаа нь харагдсан. Цаашид багш нарын мэргэжлийн мэдлэг боловсролыг “Багшийн хөгжлийн тухай хууль”, өөрийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-т тулгуурлан үе шаттай тасралтгүй хөгжүүлэх нь зүйтэй.

2025 онд “ЮНЕСКО” олон улсын байгууллага, Боловсролын Ерөнхий Газар болон ШУТИС-с хамтран зохион байгуулсан олон улсын танхимийн болон цахим хэлбэрийн “Хиймэл оюун ухааны платфоруудыг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх” сургалтанд тус сургуулийн 21 багш, удирдах ажилтнууд хамрагдаж, шалгалтаа цахимаар өгч сертификат авсан болно. Мөн Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс зохион байгуулдаг дотоодын болон олон улсын шинжээчийн сургалтад ШУ-ны доктор, профессор Л.Гүндэгмаа багш хамрагдаж, шалгалт өгөөд шинжээчийн эрхээ авсан.




*Зураг 4.2 “Хиймэл оюун ухаан”-ыг сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх сургалт*

Багш нарын хувьд сургуулийн онцлогоос хамаарч ихэвчлэн спортын мэргэжлийн сургалтуудад хамрагддаг бөгөөд тэдний хэрэгцээ ч энэ чиглэлдээ түлхүү анхаардаг болох нь тэднээс ирдэг санал, төлөвлөгөөнөөс харагддаг. Мөн өөрийн хувь хүний хөгжил, байгууллагын соёл, гадаад хэлний мэдлэгээ сайжруулах зэрэгт анхаарлаа хандуулдаг нь 50 хувьтай, багш мэргэжлийн ур чадвар, арга зүйгээ сайжруулах тэмүүлэлтэй 70 хувьтай, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, дэлхийн жишигт хүрсэн судалгаа хэвлэн нийтлүүлэх, эрдмийн зэрэг цолоо ахиулах хүсэл, эрмэлзэл багш нарын хувийн төлөвлөгөөнд 90 хувьтай тусгагдсан үзүүлэлт ажиглагдсан.

### 4.4 Судалгаа ба хөгжил

*Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.*

ҮБТДСургууль “**Судалгааны ажлын чанар**”-ыг тухайн судалгааны төслийн үр дүнд гарсан бүтээлийн тоо, оролцсон хамрагдсан хүний тоогоор үнэлдэг 2015 оны 11-р сарын 10-ны өдрийн 01 тоот захирлын тушаалаар батласан журамтай бөгөөд “Оны шилдэг судлаач багш”-ийг жил бүр шалгаруулдаг.

Бид хүний бие бялдрын хөгжил, хөдөлгөний чадварын түвшинг тодорхойлох, судлах эрдэм шинжилгээ, иновацийн технологи арга зүйн удирдамж боловсруулж магистр, бакалаврын хөтөлбөрт суралцагчдаас гадна, бусад байгууллага, дүүрэг аймгийн биеийн тамирын багш нарт, спорт холбоодын дасгалжуулагчдад зориулсан судалгааны арга зүйн сургалтуудыг жил бүр зохион байгуулж **иновацийн технологийг түгээдэг**. Тухайлбал, Баянхонгор аймгийн БТСХ, “Эрдэнэ-Мандал “ сургууль, Нийслэлийн БГД, СХД, ЧД-ийн ЕБС-ийн биеийн тамирын багш нар, Спорт холбоодын дасгалжуулагч, арга зүйч, Нийслэлийн цагдаагийн газрын арга зүйчид сургалтад зэрэг хамрагдаад байна.




*Зураг 4.3 ҮБТДС-тай хамтарч эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд*

Дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлж үр дүнгээр нь тайлагнаж хүлээлгэн өгдөг. Үүнд:

- БТСУХ-н захиалгаар 16 яамны төрийн албан хаагчдын ББХ, БББэлтгэлжилтийн судалгааг зохион байгуулсан, дата базыг бүрдүүлж тайлагнасан.
- БШУСЯамны ШУТСангийн санхүүжилттэй суур судалгааны “Тамирчдын биеийн бүтэц үйд ажиллагааны бүрэлдэх онцлогийн судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний захиалгат төслийг амжилттай хэрэгжүүлсэн. ҮБТДС-ийн судалгааны баг нь биеийн тамирын боловсрол, биеийн тамирын дасгал, хөдөлгөөн, спортын анхан шатны тусламж үзүүлэх арга зүй, спортын дасгалжуулалтын тодорхой асуудал, сэдэв, төсөл дээр мэргэшин ажилласаар ирлээ.

Тус сургуулийн биологийн ШУ-ны доктор Л.Гүндэгмаа тэргүүтэй биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхимийн баг БШУЯамны Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй 3ш хамтарсан төсөл, 1 суурь судалгааны төсөл амжилттай хэрэгжүүлсэн. 2022 онд ШУ-ны Академийн Нийгмийн салбарын бага чуулганаар “Тамирчдын бие бялдрын бүтэц-үйл ажиллагааны онцлог бүрэлдэхийг иж бүрэн судлах” сэдэвт суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн тухай 318 хуудас бүхий тайланг хэлэлцүүлж амжилттай хамгаалж хүлээлгэн өгсөн. Төслийн ажлын хүрээнд судлаач эрдэмтдийн баг морфофункциональ онцлогийн иж бүрэн цогц судалгааг явуулах **арга зүйн удирдамж** боловсруулж, **шалгуур** үзүүлэлтүүдийг гаргаж, **модель загварыг** тодорхойлж зөвлөмж гаргав. Судалгаандаа асуумж, антропометр, био-импедансиометр, спирометр, бие бялдрын сорил тест, математик боловсруулалтын аргуудыг хэрэглэсэн.

- ҮБТДС-ийн үүсгэн байгуулагч, Монгол Улсын Гавьяат багш, Шинжлэх ухааны доктор, профессор Г.Лхагвасүрэнгийн нэрэмжит уламжлалт **эрдэм шинжилгээний хурлыг** тогтмол 4 сарын 22-нд зохион байгуулдаг. 2024 онд “Спортын дасгалжуулалтад гарч буй өөрчлөлт, шинэчлэлт” нэртэйгээр 2024 оны 04 сарын 05 өдөр Оюутны VI наадмын өмнө ЭШХурлын зохион байгуулсан.
- “Оюутны спорт, биеийн тамирын боловсрол 2024” эрдэм шинжилгээний хурлыг ҮБТДСургууль гардан удирдан зохион байгуулж, эмхэтгэлийг эмхэтгэн хэвлүүлсэн.
- ҮБТДСургууль нь 2021 онд цар тахлын хорио цээрийн үед “Үндэсний спортын түүхэн өв уламжлал, хөгжлийн хандлага – II” олон улсын эрдэм шинжилгээний онлайн хурлыг амжилттай зохион байгуулсан.

Судалгааны тухайд сургуулийн нийт тэнхим, албадын багш, ажилтнуудыг нэгтгэсэн тус бүрдээ тэргүүлэх чиглэл бүхий профессорын, судлаачдын гэсэн хоёр үндсэн баг ажилласаар ирсэн. Профессорын баг нь мэргэжлийн суурь судалгаа, онол, арга зүйн асуудалд үйл ажиллагаагаа чиглүүлдэг бөгөөд судлаачдын баг нь хавсрага судалгааны чиглэлээр ажиллаж байна. Тодруулбал:

- Онол арга зүйн тэнхим “Бие бялдрын онол арга зүйн” чиглэлийн судалгаануудыг хийж, дотоод, гадаадад зохион байгуулах эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулан сурталчилдаг.

- Үндэсний спорт мэргэжлийн тэнхимийн харьяанд спортын клубүүд ажиллаж төрөл бүрийн уралдаан тэмцээнд оролцох ажлыг удирдан явуулж, тамирчдын гадаад, дотоод хамтарсан бэлтгэлийг зохион байгуулдаг бөгөөд сургалтын технологийн судалгааг баримталж хийдэг.
- Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим дэргэдээ биеийн тамирын эмчилгээ, чийрэгжүүлэлтийн кабинет ажиллуулахын зэрэгцээгээр спортын уралдаан, тэмцээнүүдийн эмч, шүүгч нарын багт ажиллах, мөн тамирчдын бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн түвшин тогтоох сорил авах буюу анагаах биологийн чиглэлийн судалгаануудыг гардаж хийдэг.

Хүснэгт 4.8 ҮБТДС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн тоо

| Нэр | Хичээлийн жил | | | | | Нийт | Ишлэгдсэн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 | 2024-2025 | | |
| Эрдэм шинжилгээний бүтээл | 4 | 8 | 12 | 8 | 3 | 34 | 80 |
| Үүнээс /Scopus, WoS/ | 1 | 4 | 2 | 0 | 1 | 8 | 60 |
| ЭШХурлалд /олон улсын/ | 8 | 3 | 3 | 4 | 7 | 25 | 50 |

***Суралцагч судалгааны ажлаараа эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн хэлэлцүүлэгт оролцох оролцоог хангадаг байдал***

ҮБТДС-ийн магистрын төгсөлтийн сургалтын журамд “Магистрантын судалгааны ажлын ийг төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон, туршилт, судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний хурал, семинарт хэлэлцүүлсэн, ЭШ-ний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн зэргээр удирдагч үнэлж, тэнхим, профессорын баг баталгаажуулна” гэж заасан байдаг.

Энэхүү хөтөлбөрөөр сурч байгаа магистрантууд нь өөрийн судалгааны ажлаар боловсрол судлалын болон БТС-ын чиглэлийн эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлдэг. Энэ нь магистрын судалгааны ажлын 1-2 ийг тооцуулах боломжийг олгодог. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн хугацаанд эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4.9 Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн оюутны тоо

| № | Эрдэм шинжилгээний Хурал | 2018-2019 | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БТС-ийн салбар сургуулийн ОЭШХ | | 9 | | 6 | 8 | **23** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Улсын хэмжээний ОЭШХ | | | 5 | | | **5** |
| 3 | Олон улсын хэмжээний ОЭШХ | 3 | | | | | **3** |
| **Бүгд** | | **3** | **9** | **5** | **6** | **8** | **31** |

Эрдэм шинжилгээ судалгааны ажил нь их, дээд сургуулийн үндсэн чиглэлийн нэг бөгөөд Багшийн ажиллах журамд заасны дагуу багш бүр хичээлийн жилийн эхэнд сургуулийн зорилготой холбогдуулан өөрийн гүйцэтгэх ажлаа А, В, С цагийн хүрээнд төлөвлөж хагас жил, бүтэн жилээр сургуулийн удирдлага, сургалтын алба, тэнхимийн багш нарын хүрээнд тайлагдаж, үнэлж дүгнэдэг. Багш бүр журамд заасны дагуу гадаад, дотоодын мэргэжлийн чиглэлийн эрдэм шинжилгээний бичигт хэвлэгдсэн бүтээлүүдийг тооцуулах журамтай байдаг. Багш бүр өөрийн цол, зэрэглэлд хамаарах эрдэм шинжилгээний цагийг заавал гүйцэтгэх ёстой.

**Судалгааны төсөл хөтөлбөрүүд**

- Эрүүл мэндийн яам, АНУ-ын Мянганы сорилтын сантай хамтран эрүүл мэндийн төсөлт ажил - 2 цогц
- БСШУЯамны ШУТСан болон ОХУ-ын Суурь судалгааны сангийн санхүүжилтээр Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Антропологийн хүрээлэнтэй хамтран хамтарсан судалгааны төсөлт ажил-3 цогц
- БСШУЯамны харьяа Боловсролын хүрээлэнтэй хамтарсан "Монгол хүүхдийн шалгуур үзүүлэлт" төслийн "Хүүхдийн бие бялдрын хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох" судалгааны багийн удирдамж арга зүйг 2014 -2023 онд боловсруулж удирдан оролцсон.-1 цогц
- Соёл спорт аялал жуулчлалын яамны харьяа Спортын бэлтгэлийн төвийн эрдэм шинжилгээний албатай хамтран "Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа" төсөлт ажил -1 цогц
- Эрүүл мэнд спортын яамны харьяа Биеийн тамирын хөгжлийн төвийн эрдэм шинжилгээний албатай хамтран "Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа" төсөлт ажил -1 цогц
- Японы хүүхдийн хөгжлийн үндэсний төвтэй хамтарч "Хөдөлгөнт-хөгжимт дасгалаар хүүхдийн биеий бялдрын чанар, сэтгэхүйн хурдыг дээшлүүлэх нь" төсөлт ажил 1 цогц
- БСШСЯ, ШУТСангаас "Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа" суурь судалгааны төсөл ажил 1 цогц
- БСШСЯ, ШУТСангаас "Тамирчдын биеийн бүтэц үйл ажиллагааны онцлог бүрэлдэх нь" суурь судалгааны төсөл ажил 1 цогц
- Чех улсын Чарльстоны Их сургуулийн хамтарсан төсөл ажил 1 цогц

Нийтдээ 12 томоохон төсөлт эрдэм шинжилгээ судалгааны цогц төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

## 4.5 Шалгуур 4 SWOT, TOWS шинжилгээ

| Давуу тал/S | Сул тал/W |
| --- | --- |
| • Эрдмийн зэрэгтэй багш нарын тоо жилээс жилд нэмэгдэж байна.<br>• Багш нарын сонгон шалгаруулалтын журам боловсронгуй.<br>• Гадаад болон дотоодын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд идэвхтэй явагддаг.<br>• Багшийн хөгжлийг дэмжих урамшууллын систем үр дүнтэй. | • Багшийн ачаалал харьцангуй өндөр болох магадлалтай.<br>• Залуу багш нарын туршлага дутмаг байдал.<br>• Судалгааны төсөлд оролцох боломж хязгаарлагдмал. |
| **Боломж/O** | **Эрсдэл/T** |
| • Гадаадын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.<br>• Эрдэм шинжилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар судалгааны ажлыг дэмжих.<br>• Цахим сургалтын орчныг сайжруулж, багшийн ур чадварыг нэмэгдүүлэх. | • Суралцагчдын тооны бууралт нь санхүүгийн дарамт үүсгэх магадлалтай.<br>• Сургуулийн хүний нөөцийн урт хугацааны төлөвлөлт хангалтгүй байж болзошгүй.<br>• Хурдтай өөрчлөгдөж буй боловсролын бодлого, шаардлагууд. |
| **OS стратеги** | **OW стратеги** |
| • Олон улсын их сургуулиудтай хамтарч судалгааны төслийн тоог нэмэгдүүлэх.<br>• Гадаадын санхүүжилттэй төсөлд хамрагдаж багшийн хөгжлийг дэмжих.<br>• Цахим сургалтын хөтөлбөрт туршлагатай багш нарын оролцоог нэмэгдүүлэх. | • Залуу багш нарт туршлага хуримтлуулах боломж олгох замаар тэдний олон улсын хөтөлбөрт татан оролцуулах.<br>• Судалгааны төсөлд санхүүжилт олох механизмыг сайжруулах.<br>• Ачаалал ихтэй багш нарт зориулсан сургалт, менежментийн дэмжлэг үзүүлэх. |
| **TS стратеги** | **TW стратеги** |
| • Багш нарын эрдмийн зэрэг, судалгааны ажлыг сурталчилж сургуулийн нэр хүндийг нэмэгдүүлэх.<br>• Багшийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн уян хатан болгох. | • Багшийн нөөцийг оновчтой төлөвлөх, залуу багш нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах.<br>• Багш нарын ачааллыг бууруулж, эрдэм шинжилгээний ажилд илүү анхаарах боломжийг бүрдүүлэх. |

## 4.6 Сайжруулах арга зам

- **Судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэх:** Гадаадын санхүүжилт бүхий төслүүдийг эрэлхийлэх, үүнд багш нарыг идэвхтэй оролцуулах.
- **Багшийн хөгжлийг дэмжих:** Залуу багш нарт зориулсан ур чадвар хөгжүүлэх сургалтуудыг олон улсын түвшинд зохион байгуулах.

- **Оюутны тоог нэмэгдүүлэх стратеги:** Сургуулийн нэр хүндийг нэмэгдүүлэх маркетингийн ажлууд зохион байгуулж, орчин үеийн сургалтын арга барил нэвтрүүлэх.
- **Ачааллыг бууруулах шийдэл:** Цахим сургалт, ажлын уян хатан зохицуулалтыг нэвтрүүлэх.

### 4.7 Үнэлгээ

“Биеийн тамир боловсрол”-ын магистрын хөтөлбөрийн “Багшлах бүрэлдэхүүн” хэсгийн өөрийн үнэлгээний тайлан нь их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн магадлал итгэмжлэлийн шаардлагыг хангахуйц түвшинд бичигдсэн байна

<table>
<tr><th>Шалгуур</th><th>Үзүүлэлт</th><th>Хэмжээс</th><th>Өөрийн үнэлгээ</th></tr>
<tr><td rowspan="6">4.1</td><td>Хөтөлбөрийн зорилгод нийцсэн хүний нөөцийн цогц бодлоготой эсэх</td><td rowspan="11">Хангалттай сайн: Өгсөн үзүүлэлтийг хангаж тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг<br><br>Хангалттай: Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан<br><br>Сайжруулах шаардлагатай: Нэг үзүүлэлтийг хангасан<br><br>Хангалтгүй: Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй</td><td rowspan="6">Хангалттай сайн</td></tr>
<tr><td>Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь багшийг сонгон шалгаруулах, хөгжүүлэх төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлдэг байдал</td></tr>
<tr><td>Докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин</td></tr>
<tr><td>Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба магистрантын тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй эсэх</td></tr>
<tr><td>Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг хэрхэн мөрддөг байдал</td></tr>
<tr><td>Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан, багш нарыг урамшуулдаг байдал</td></tr>
<tr><td rowspan="3">4.2</td><td>Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлж, багшийн ажлын үнэлгээ</td><td rowspan="3">Хангалттай сайн</td></tr>
<tr><td>Багшлахуйн үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлсэн байдал</td></tr>
<tr><td>Үнэлгээний систем нь багшийн хөгжлийг дэмжихэд хэрхэн эерэг нөлөө үзүүлж буй байдал</td></tr>
<tr><td rowspan="2">4.3</td><td>Багшийн өөрийн үнэлгээний тайланд тогтмол шинжилгээ хийдэг байдал</td><td rowspan="2">Хангалттай сайн</td></tr>
<tr><td>Багшийн хөндлөнгийн үнэлгээг /суралцагч, удирдлага, багш/ хийж буй байдал</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | Багшийн үйл ажиллагааны баримт материалыг хэрхэн бүрдүүлж, баяжуулалт хийж буй байдал | | |
| **4.4.** | Багшийн нийгмийн үйлчилгээг хэрхэн удирдаж зохицуулдаг, ажлыг үнэлж буй байдал | | **Хангалттай сайн** |
| | Багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр байдаг уу? Энэ нь тэнхим, сургууль, багшийн хөгжлийн ерөнхий хөтөлбөртэй уялдаж буй байдал | | |
| | Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг хийж буй байдал | | |
| | Төслийн судалгааны ажлын багт магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байдал | | |
| | Үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын гишүүнээр ажиллаж буй багшийн тоо, эзлэх хувь | | |

**4.8 Дүгнэлт**

1. Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлснээр эрдмийн зэрэгтэй багшийн хувь 41.6% болтлоо өссөн үзүүлэлттэй байгаа нь магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай хүний нөөцтэй байна.
2. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрдөж, багш өөрийн зэрэглэлээ ахиулах боломж нээлттэй байна.
3. Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан, багш нарыг урамшуулдаг нь багшийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулдаг.
4. Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил нь сургуулийн тэргүүлэх болон хавсарга судалгааны чиглэл рүү хийгдэж, чансаа өндөртэй сэтгүүлд өгүүлэл бичих, дэд болон профессор багш нарт судалгааны ажлын тэтгэлэг олгон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болсон нь судалгааны ажлын үр дүнг дээшлүүлсэн байна.
5. ҮБТДС нь өөрийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан багш нар төсөл хөтөлбөр удирдах, зохион байгуулах, туршилт судалгаа хийх арга зүйд сургаж хөгжүүлж хоёр профессорын багт хуваан суурь судалгааны төсөл хэрэгжүүлсэн байна.
6. Сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг багш, тэнхим, сургууль жил, гурван жилээр төлөвлөн үр дүнг багш бүр өөрийн үнэлгээний тайланг хагас жил, бүтэн жил, 3 жилээр бичиж тухай бүрд мэргэжлийн тэнхим, сургууль, ҮБТДС-ийн чанарын баталгаажуулалт, мониторингийн албаар ажлаа үнэлүүлж, гаргасан шийдвэрийг ажилдаа тусган ажиллаж заншсан.

## ШАЛГУУР 5. НӨӨЦ БА САНХҮҮЖИЛТ

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

### 5.1 Сургалт, судалгааны орчин

*Тухайн хөтөлбөр шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж багш суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.*

ҮБТДС нь сүүлийн таван жилд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, багш, суралцагчдын тав тухтай, хүртээмжтэй байх боломжоог хангах үүднээс томоохон бүтээн байгуулалт бүхий ажлуудыг хийлээ.

2019 оноос сургуулийн шинэ цогцолбор барилгын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эхэлж, 2023 оны 12-р сарын 23-ны өдөр спортын 5 заалтай 4 давхар 6370 кв.м талбай бүхий шинэ хичээлийн байрыг улсын комисс хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэхүү барилга нь А, Б блокоос бүрдсэн бөгөөд А блок нь 36м х 18м харьцаатай 3200 кв.м талбайтай, хичээлийн танхим, багш ажилчдын өрөө, цайны газар, ариун цэврийн өрөө, номын сан зэргийг багтаасан 800-1000 хүүхэд хичээллэх боломжтой, 5 давхар хичээлийн байр юм. Харин Б блок нь 42м х 36м харьцаатай 2 давхар спорт тоглоомын 2 талбай бүхий заал, чөлөөт, жүдо, фитнес, таеквондо, аэробик, бүжгийн зэрэг 6 заалтай, 600-800 хүүхэд хичээллэх боломжтой, анагаах ухаан нөхөн сэргээлтийн төв, эрэгтэй эмэгтэй шүршүүр, хувцас солих өрөө гэх мэт багтсан 3100 кв.м талбайтай юм.

Бид шинэ хичээлийн байрны бүтээн байгуулалтын зардалд нийт 5,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.




*Зураг 5.1 Сургуулийн шинэ барилгын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын дүн*

Хүснэгт 5.1 Анги танхим, спорт заал, лабораторийн жагсаалт

| № | Зориулалт | Танхимын дугаар | Суудлын тоо | Хичээлийн байр |
|---|---|---|---|---|
| 1 | Семинарын өрөө | 502 | 20 | Хичээлийн I байр |
| 2 | Семинарын өрөө | 503 | 20 | Хичээлийн I байр |
| 3 | Компьютерын лаборатори | 505 | 20 | Хичээлийн I байр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Лекцийн танхим | 506 | 80 | Хичээлийн I байр |
| 5 | Лекцийн танхим | 507 | 80 | Хичээлийн I байр |
| 6 | Семинарын өрөө | 508 | 20 | Хичээлийн I байр |
| 7 | Лекцийн танхим | 511 | 80 | Хичээлийн I байр |
| 8 | Хурлын өрөө | 410 | 20 | Хичээлийн I байр |
| 9 | Спорт заал | | 80 | Хичээлийн I байр |
| 10 | Бөхийн заал | | 50 | Хичээлийн I байр |
| 11 | Фитнес | | 30 | Хичээлийн I байр |
| 12 | Хичээлийн өрөө | 305 | 27 | Хичээлийн II байр |
| 13 | Компьютерын өрөө | 404 | 15 | Хичээлийн II байр |
| 14 | Лекц, Уншлагын танхим А | 406 | 72 | Хичээлийн II байр |
| 15 | Спорт заал А | А | 250 | Хичээлийн II байр |
| 16 | Спорт заал 2 -аэробик | В3 | 120 | Хичээлийн II байр |
| 17 | Хичээлийн өрөө | 307 | 27 | Хичээлийн II байр |
| 18 | Лекц, Уншлагын танхим Б | 407 | 72 | Хичээлийн II байр |
| 19 | Спорт заал 3 (Фитнесс) | В5 | 55 | Хичээлийн II байр |
| 20 | Спорт заал Б | Б | 250 | Хичээлийн II байр |
| 21 | Лаборатор | 101 | 15 | Хичээлийн II байр |
| 22 | Лекцийн танхим | 308 | 27 | Хичээлийн II байр |
| 23 | БТЭАЗ | В1 | 85 | Хичээлийн II байр |
| 24 | Спорт заал 1 -теннис | В2 | 39 | Хичээлийн II байр |
| 25 | Хичээлийн танхим | 205 | 27 | Хичээлийн II байр |
| 26 | Хичээлийн танхим | 208 | 27 | Хичээлийн II байр |
| 27 | Хичээлийн танхим | 202 | 27 | Хичээлийн II байр |
| 28 | Хичээлийн танхим | 207 | 27 | Хичээлийн II байр |
| 29 | Бөхийн заал -жудо | В4 | 120 | Хичээлийн II байр |
| 30 | Лекцийн танхим | 306 | 27 | Хичээлийн II байр |
| 31 | Хичээлийн танхим | 401 | 27 | Хичээлийн II байр |
| 32 | Хичээлийн танхим | 205 | 27 | Хичээлийн II байр |
| 33 | Хичээлийн танхим | 410 | 27 | Хичээлийн II байр |

Сүүлийн 5 жилд хөтөлбөр хэрэгжих сургалтын орчныг сайжруулах чиглэлийн ажлуудыг сургуулийн хичээлийн жилийн төлөвлөгөө, чанарын дотоод баталгаажуулалтын ажлын төлөвлөгөө зэрэгт тусгахын зэрэгцээ суралцагч оюутнуудаас санал асуулга авч дүгнэлт хийн ажиллаж байна.




*Зураг 5.2 Анги танхимд өгсөн оюутны үнэлгээ*




*Зураг 5.3 Спорт заалнуудад өгсөн оюутны үнэлгээ*




*Зураг 5.4 Сургуулийн гадаад орчинд өгсөн оюутны үнэлгээ*

Магистрын сэтгэл ханамжийн судалгааны дунд сургалтын орчин 74-82% сайн, маш сайн түвшинд үнэлэгдсэн. Орчны сэтгэл ханамжийн судалгаа чанарын баталгаажуулалтын албанаас жил бүр авдаг бөгөөд гарсан санал хүсэлт дээр

үндэслэж дараа жилийн төлөвлөгөөндөө тусгадаг. Жишээ нь 2021-2022 оны хичээлийн жилд хичээлийн бус цагаар магистрант оюутанд зөвлөгөө, давтлага өгөх танхимыг бий болгосон, шинэ сургуулийн барилгын ажлыг эрчимжүүлсэн, бөмбөг, хичээлийн хэрэглэгдэхүүн нэмж авсан, цайны газарт зохих шаардлагыг тавьж ариун цэвэр дээр нь анхаарч, засвар хийсэн шинэ хэсэгт орсон, номын санг цагийн хуваарийн дагуу ажиллуулсан.

Үйл ажиллагааг илүү хүртээмжтэй байхад анхаарсан зэрэг ажлуудыг хийсэн. Магиструудаас хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, коридор, анги танхим, заал зэргийг 7 хоног тутамд хлорамины уусмалаар цэвэрлэгээ хийж, жилдээ 2 удаа мэргэжлийн байгууллагатай хамтарч ариутгал халдваргүйжүүлэлт хийж сургалтын ариун цэвэрч эрүүл ахуйн орчныг бий болгодог.

### 5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

*Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэхүүнийг хангалттай бүрдүүлж судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.*

ҮБТДСургууль нь 637 нэр төрлийн 2168 ш 725,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, биеийн тамир спортын сургалт-судалгаанд зайлшгүй хэрэгцээт 201 нэр төрлийн 1829 ширхэг 69,4 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж хэрэгслүүдийг улсын стандартын дагуу зохих тоо хэмжээгээр нь спортын заал танхимд (зориулалтын тоног төхөөрөмж, дэвжээ, матраас, бөмбөг, цана тэшүүр, зээрэнцэг бөөрөнцөг) бүрэн бэлтгэж хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч байна. Тус сургууль сүүлийн 5 жилд материаллаг баазаа нэмэгдүүлэх зардалд 220,2 сая төгрөг зарцуулсан байна.




*Зураг 5.5 Материаллаг нөөцийн зардал*

Материаллаг нөөцийн зардлын энэхүү графикийн үр дүнгээс үзвэл хичээлийн жил бүрд сургалтын орчныг сайжруулахад хөрөнгө тусгаж зарцуулсан байгаа нь харагдаж байна. Хичээлийн хоёрдугаар байрны бүтээн байгуулалтын төсөв зардал өндөр үнэтэй учир хичээлийн нэгдүгээр байранд шаардлагагүй зардал гаргахаас аль болох татгалзсан. Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангагдсан байна.

"Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд спортын тусгай тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 5.2 Хөтөлбөрийн биеийн тамир, спортын хичээлийн хэрэгсэл материалын үндсэн үзүүлэлт

| Хичээлийн төрөл | Заалны хэмжээ, м2 | Хичээлийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн тоо | | |
|---|---|---|---|---|
| | | Нэр төрөл | Тоо, нэгж | Мөнгөн дүн |
| Чөлөөт бөх | 392 | 21 | 109 ш | 9,486,000 |
| Жүдо бөх | 388 | 10 | 390 ш | 140,000,000 |
| Үндэсний бөх | 200 | 3 | 200 м2 | 13,000,000 |
| Таеквондо | 350 | 1000 | 1000ш | 70,000,000 |
| Сагсан бөмбөг | 1524 | 48 | 55ш | 4,245,000 |
| Волейбол | 1524 | 19 | 62ш | 6,655,000 |
| Аэробик | 200 | 82 | 82 | 6,195,000 |
| Хөнгөн атлетик | 1524 | 48 | 55ш | 4,245,000 |
| Фитнес | 250 | 39 | 65ш | 6,655,000 |
| Хичээлийн танхим | 620 | 21 | 396ш | 35,056,766 |
| | 6352 | | | 295,538,000 |

Хүснэгт 5.3 Сургалт, судалгааны зориулалттай лаборатори,туршилтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний судалгаа

| № | Багажны нэр | Үнэ | Ширхэг | Үйлдвэрлэсэн орон | Ямар хэмжилт хийх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Пульс оксиометр | 40000 | 9 | Америк | судасны лугшилт, хүчилтөрөгчийн хэмжээ |
| 2 | Пульс оксиометр | 35000 | 2 | Хятад улаан | судасны лугшилт, хүчилтөрөгчийн хэмжээ |
| 3 | OMRON АД хэмжигч цахилгаан | 120000 | 2 | Америк | АД дээд доод даралт хэмжигч |
| 4 | Мөнгөн устай АД хэмжигч гараар | 25000 | 2 | Хятад | АД дээд доод даралт хэмжигч |
| 5 | Чагнуур | 10000 | 2 | Хятад | Зүрх болон амьсгал сонсох |
| 6 | Зүрхний цохилт тоологч цаг | 25000 | 1 | Чех | Зүрхний цохилт тоолох |
| 7 | Зүрхний монитор Wellue фирм | 250000 | 2 | Америк | Зүрхний цохилт болон бичлэг хийх |
| 8 | MEDIKRO Амьсгалын ү/а-г хэмжигч | 4000000 | 1 | Финлянд | Амьсгалын үйл ажиллагааг цогцоор нь шинжлэх |
| 9 | Астма илрүүлэгч | 10000 | 4 | Америк | Амьсгал гаргах хурдыг хэмжигч |
| 10 | Фиклометр | 10000 | 2 | Швед | Амьсгал гаргах хурдыг хэмжигч |
| 11 | “Медасс” АВС-02 | 4000000 | 1 | ОХУ | Биеийн дотоод бүтцийн 22 үзүүлэлт гаргах |
| 12 | INNER-SCAN | 200000 | 1 | Америк | Биеийн дотоод бүтцийн 9 үзүүлэлт гаргах |
| 13 | TANITA BC-705N | 200000 | 1 | Япон | Биеийн дотоод бүтцийн 9 үзүүлэлт гаргах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | GPM Антропометрийн ком багаж | 14000 доллар | 1 | Швейцар | Биеийн бүх хэсгийн антропометрийн хэмжилт хийх |
| 15 | Туузан даавуун метр | 40000 | 2 | ОХУ | Биеийн хэсгүүдийн хэмжилт |
| 16 | Антропометрийн ком багаж | 350000 | 1 | ОХУ | Биеийн бүх хэсгийн антропометрийн хэмжилт хийх |
| 17 | GPM өөхөн давхаргын зузаан хэмжигч | 200000 | 1 | Швейцар | Биеийн өөхөн давхаргыг хэмжих |
| 18 | КАФА | 300000 | 1 | ОХУ | Үений өргөн хэмжигч |
| 19 | УДЗ | 100000 | 1 | ОХУ | Үений өргөн хэмжигч /гар хийц/ |
| 20 | HOBBY VERNIER CALIPERS | 10000 | 4 | Хятад | Үений өргөн , өөхөн давхарга хэмжигч |
| 21 | Гониометр | 7000 | 22 | Хятад | Үений далайц хэмжих |
| 22 | Курвиметр КУ-А | 20000 | 1 | ОХУ | Өргөн хэмжигч |
| 23 | SOKKIA-Elson | 60000 | 2 | Япон | Урт хэмжигч |
| 24 | ДК 100 | 120000 | 2 | ОХУ | Насанд хүрэгч гарын атгах хүч хэмжигч |
| 25 | ДК 50 | 120000 | 2 | ОХУ | Ахлах ангийн хүүхдийн гарын атгах хүч хэмжигч |
| 26 | ДК 25 | 120000 | 1 | ОХУ | Бага ангийн сурагчдын гарын атгах хүч хэмжигч |
| 27 | Шүгэл | 5000 | 3 | Хятад | Сорил авахад дуут дохио өгөх |
| 28 | Ягаан туяа | 150000 | 1 | Солонгос | Богино долгионы ягаан туяа үрэвсэл дарах |
| 29 | Дижитал массаж EA-F21 | 100000 | 1 | Хятад | Дижитал 6 горимоор массаж хийх |
| 30 | Дулаацуулах халуун хөнжил HB-10S | 50000 | 1 | Солонгос | Дулааны аргаар эмчлэх |
| 31 | УВЧ-30 | 3500000 | 1 | ОХУ | Богино долгионы тусламжаар үрэвсэл намдаах |
| 32 | Цахилгаан бумба Noel | 200000 | 1 | Солонгос | Үрэвслийг дарах, хуян тараах |
| 33 | Ердийн гар бумба | 30000 | 1 | Хятад | Үрэвслийг дарах, хуян тараах |
| 34 | Ультра соунд Sam | 450000 | 1 | Америк | Үрэвслийг дарах, хаванг бууруулах |
| 35 | Цэгэн массаж аппарат | 25000 | 1 | Солонгос | Цэгэн массаж хийх, цочроох |
| 36 | BRUN | 250000 | 1 | Хятад | Мөс үйлдвэрлэх |
| 37 | Uro-Meter 120 | 1500000 | 1 | Солонгос | Шээсний хурдавчилсан тестийн аппарат |
| 38 | Uro-Color 10 тест | 1 хайрцаг 15000 | 4 | Солонгос | Шээсний шинжилгээ авах тест индикатор |
| 39 | LACTAT PLUS аппарат | 500000 | 1 | Америк | Цусанд лактат дахь хэмжих |
| 40 | LACTAT test strips | 80000 | 17 хайрцаг | Америк | Цусанд лактат дах хэмжихэд хэрэглэх тест |
| 41 | LACTAT test хянагч | 100000 | 2 | Америк | Цусанд лактат хэмжихийн өмнөх индикатор буюу шалгагч уусмал |
| 42 | SD CodeFree аппарат | 150000 | 1 | Солонгос | Цусанд глюкозын хэмжээ тодорхойлогч |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 43 | Glucose test strips | 60000 | 2 | Солонгос | Цусанд глюкозын хэмжээ тодорхойлоход хэрэглэх тест |
| 44 | Өндөг цоологч | Хайрцаг 5000 | 1 | Хятад | Өндөг хатгах зориулалт |
| 44 | Шээсний шинжилгээний сав | 500 | 20 | Хятад | Шээсний шинжилгээ авах |

Хүснэгт 5.4 Сургалт, судалгаанд ашиглах компьютер, программ хангамжийн судалгаа

| № | Эд хогшил | Тоо ширхэг | Нийт үнэ |
|---|---|---|---|
| 1 | Компьютер | 16 | 16977941 |
| 2 | Зөөврийн компьютер | 5 | 14910000 |
| 3 | Компьютерын ширээ | 1 | 930000 |
| 4 | Компьютерын дагалдах хэрэгсэл /рүүтер, модем, cd рам, свич, DVR, урт залгуур/ | 9 | 923000 |
| 5 | Принтер | 1 | 195000 |
| 6 | Проектор | 1 | 1250000 |
| | ДҮН | | 34185941 |

Хүснэгт 5.5 Сургалт судалгаанд ашиглах ном, сурах бичиг, бусад цахим эх үүсвэрийн судалгаа

| Үндсэн сурах бичгийн нэр | Хамаарах хичээлийн код | Хэвлэгдсэн он | ISBN | Хэвлэг дсэн хэл | Номын санд хэвлэмэл хэлбэртэй тоо ширхэг | Цахим хэлбэрээр байгаа эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| “Биеийн тамирын онолын арга зүй” | N.TPE-707 | 2022 | 978-99929-0-827-0 | Монгол хэл | 70 | Үгүй Өөрийн багш) |
| Бие бялдрын хүмүүжлийн онол, арга зүй | N.TPE-708 | 2015 | 978-99929-0-827-0 | Монгол хэл | 20 | Үгүй (Өөрийн багш) |
| Спортын дасгалжуулалтын онолын үндэс | N.TMR-701 | 2002 | 99929-0-124-1 | Монгол хэл | 30 | Үгүй (Өөрийн багш) |
| Спортын менежмент | N.MPE-706 | 2014 | 978-99929-3-026-8 | Монгол хэл | 46 | Үгүй (Өөрийн багш) |
| Спортын биохими | N.TMR-701 | 2005 | 99929-0-598-0 | Монгол хэл | 99 | Үгүй (Өөрийн багш) |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Спортын сэтгэл судлал | N.PPE-707 | 2012 | 978-99962-986-9-1 | Монгол хэл | 15 | Үгүй (Өөрийн багш) |
| Спортын анхны тусламж | N.HED-704 | 2024 | 978-9919--0-3517-4 | Монгол хэл | 50 | Үгүй (Өөрийн багш) |
| Биеийн тамирын эмчилгээ | N.HED-704 | 2002 | - | Монгол хэл | 34 | Үгүй (Өөрийн багш) |

Хүснэгт 5.6 Биеийн тамир, спортын чиглэлийн номын судалгаа

| № | Дасгалжуулагч мэргэжлийн хичээл | Монгол хэл дээрх ном, сурах бичиг | Орос хэл дээрх ном, сурах бичиг | Англи хэл дээрх ном, сурах бичиг |
|---|---|---|---|---|
| 1 | Спортын дасгалжуулалтын онол | 242 | 89 | 27 |
| 2 | Спортын физиологи | 321 | 63 | 8 |
| 3 | Спортын сэтгэл судлал | 150 | 42 | 6 |
| 4 | Спортын төрлийн мэргэжлийн онол | 1059 | 93 | |
| 5 | Спортын төрлийн мэргэжлийн сургалтын арга зүй | 140 | | |
| 6 | Эмчилгээний биеийн тамир /сонгон суралцах хичээл/ | 500 | 80 | 22 |
| 7 | Спортын биомеханик | 29 | 14 | 15 |

Хүснэгт 5.7 Сургалт судалгаанд ашиглах цахим өгүүллийн судалгаа

| № | Үндсэн сурах бичгийн нэр | Хэвлэгдсэн хэл | Номын сан хэвлэмэл хэлбэрээр байгаа тоо ширхэг | Цахим болон хэвлэмэл хэлбэрээр байгаа эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Pdfdrive.com | Англи хэл | **PDF Drive** is your search engine for PDF files. | 75,028,925 eBooks |
| 2 | Судалгааны ажлууд | Монгол хэл | УБТДСургуулийн номын сангийн фондод хэвлэмэл хэлбэр | Магистрын бүтээл 147 ш, Докторын бүтээл 5 ш<br>Шинжлэх ухааны докторын бүтээл-3 |
| 3 | Сэтгүүлүүд | Орос | www.dissercat.com, https://www.rsl.ru/ https://www.teoriya.ru/ru | (Өөрийн багш) Цахим өгүүлэл – 50 ш |

## 5.3 Төсөв, санхүүжилт

*Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуй хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.*

ҮБТДС-ийн 2019-2024 оны байдлаар жилийн нийт орлогын 15,25% нь магистрын сургалтын төлбөрөөс ордог бөгөөд үүний дотоодын магиструудаас 2%, гадаад магиструудаас 13,25% бүрдүүлсэн байгаа нь гадаад магиструудын төлбөр дотоодын магиструудаас өндөр байгаа нь харагдаж байна /Хүснэгт 5.8./.

Хүснэгт 5.8 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд харилцах дансанд төвлөрсөн оюутны төлбөрийн орлого

ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ОЮУТНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГИЙН ДҮН

| № | Орлогын төрөл | 2019-2020 | | | 2020-2021 | | | 2021-2022 | | | 2022-2023 | | | 2023-2024 | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь | Суралцаж буй оюутны тоо | Мөнгөн дүн | Хувь |
| 1 | Бакалаврын орлого | 456 | 394,099,500.00 | 87.68 | 482 | 439,240,500.00 | 89.32 | 452 | 498,520,600.00 | 86.03 | 428 | 488,650,000.00 | 84.68 | 400 | 738,332,360.00 | 84.75 |
| 2 | Дотоодын магистрийн орлого | 25 | 55,350,000.00 | 12.32 | 18 | 52,500,000.00 | 10.68 | 11 | 2,400,000.00 | 0.41 | 6 | 18,540,500.00 | 3.21 | 12 | 17,465,000.00 | 2.00 |
| 3 | Гадаад магистрийн орлого | - | - | - | - | - | - | 19 | 78,520,000.00 | 13.55 | 32 | 69,850,200.00 | 12.10 | 29 | 115,420,000.00 | 13.25 |
| | **Магистрийн нийт дүн** | **25** | **55,350,000.00** | **12.32** | **18** | **52,500,000.00** | **10.68** | **30** | **80,920,000.00** | **13.97** | **38** | **88,390,700.00** | **15.32** | **41** | **132,885,000.00** | **15.25** |
| | **Нийт дүн** | **481** | **449,449,500.00** | **100.00** | **500** | **491,740,500.00** | **100.00** | **482** | **579,440,600.00** | **100.00** | **466** | **577,040,700.00** | **100.00** | **441** | **871,217,360.00** | **100.00** |

МЭДЭЭ ГАРГАСАН: ........ /НЯ-БО А. АМАРМАНДАХ

Хүснэгт 5.9 ҮБТДС-ийн 2021-2024 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрийн сургалтад зарцуулсан тооцоо

ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД СУРГУУЛИЙН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МАГИСТРИЙН ОЮУТНУУДАД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ТҮҮВЭР

| № | Зардлын ангилал | 2019-2020 он | 2020-2021 он | 2021-2022 он | 2022-2023 он | 2023-2024 он |
|---|---|---|---|---|---|---|
| | | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал | Магистрт зарцуулсан зардал |
| 1 | Цалинд | 14,280,500.00 | 17,580,750.00 | 15,420,350.00 | 14,568,950.00 | 14,550,600.00 |
| 2 | Суутган татвар | 714,025.00 | 879,037.50 | 771,017.50 | 728,447.50 | 727,530.00 |
| 3 | Ном сурах бичиг | 1,000,000.00 | 1,255,100.00 | 500,000.00 | 450,000.00 | 600,000.00 |
| 4 | БҮТЭЗ | 4,500,000.00 | 1,150,000.00 | 850,000.00 | 1,240,000.00 | 1,520,000.00 |
| 5 | Түрээс, халаалт, ашиглалтын зард | 11,520,000.00 | 1,150,000.00 | 9,900,000.00 | 11,520,000.00 | 12,540,000.00 |
| 6 | Бичиг хэрэг | 155,000.00 | 126,450.00 | 182,520.00 | 250,400.00 | 230,500.00 |
| 7 | Хэвлэл захиалга | 402,560.00 | 250,000.00 | 180,500.00 | 450,200.00 | 320,100.00 |
| 8 | ЭША, Хамтарсан төслийн судалгааны ажилд | 711,800.00 | 750,200.00 | 1,250,000.00 | 840,500.00 | 759,100.00 |
| 9 | Тэмцээн уралдаан | 850,000.00 | 650,000.00 | 500,000.00 | 350,000.00 | 710,000.00 |
| 10 | Оюутны үйчилгээ | 1,259,000.00 | 856,000.00 | 485,300.00 | 700,000.00 | 654,000.00 |
| 11 | Суртачилгаа | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 12 | Холбоо, интернэт | 540,000.00 | 520,000.00 | 420,000.00 | 500,000.00 | 540,000.00 |
| 13 | Тэтгэмж оюутан, ажилчин, бусад | 900,000.00 | 3,400,000.00 | 2,700,000.00 | 500,000.00 | 3,400,000.00 |
| 14 | Хоол, ёслолын ажиллагаа | 150,000.00 | 200,000.00 | 120,000.00 | 135,000.00 | 250,000.00 |
| 15 | Бусад сургалтын зардалд | 14,530,000.00 | 15,200,500.00 | 35,400,000.00 | 34,560,000.00 | 54,250,000.00 |
| 16 | Цэвэрлэгээ, хангамж , ариутгал | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 | 150,000.00 |
| | | 52,662,885.00 | 45,118,037.50 | 69,829,687.50 | 67,943,497.50 | 92,201,830.00 |

МЭДЭЭ ГАРГАСАН: ........ /НЯ-БО А. АМАРМАНДАХ/

2019-2024 оны эхний 6 сарын байдлаар ҮБТДС-ийн нийт орлогын 10%-ийг магистрын хөтөлбөрт зарцуулсан байна ./Хүснэгт 5.13/.

Дээрх орлого зарлагын төсвийн үзүүлэлтийг сүүлийн 5 хичээлийн жилийн үзүүлэлтээр жил ирэх тутам нэмэгдэж байгаа харуулж байгаа нь энэхүү хөтөлбөр сайжирч амжилттай хэрэгжиж эрэлттэй нэмэгдэж, суралцагсдын тоо хэмжээ байгаа илэрхийлж байна / зураг 5.18./. Нөгөө талаар ҮБТДСургууль сургалтын орчны сайжруулж шинэ 6 спортын заалтай, орчин үеийн стандарт шаардлага хангасан нөхөн сэргээлт, эрдэм шинжилгээний төв лаборатор нээж ажиллуулсан, мөн олон улсын судалгааны санхүүжилттэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэний үр дүн гарч байгааг тэмдэглэж байна.




*Зураг 5.6 Магистрын хөтөлбөрийн орлого зардал /2019-2024/*

### 5.4 Шалгуур 5 SWOT, TOWS шинжилгээ

| Давуу тал/S | Сул тал/W |
|---|---|
| • **Сургалтын орчны сайжруулалт:** Сүүлийн 5 жилд спортын шинэ барилга, орчин үеийн тоног төхөөрөмж, нөхөн сэргээлт лаборатори, спорт заалнуудыг ашиглалтад оруулсан.<br>• **Тоног төхөөрөмжийн хангалттай байдал:** Мэргэжлийн хичээлийн болон спортын хичээлийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг олон улсын стандартын дагуу хангаж байгаа.<br>• **Цахим орчны хүртээмж:** Удирдлагын систем хэрэгждэг<br>• **Санхүүгийн хариуцлагатай удирдлага:** Төсвийн 10-с дээш хувийг Магистрын сургалт, судалгаа, сургалтын орчин сайжруулахад зориулдаг.<br>• **Оюутны сэтгэл ханамж өндөр:** Хөтөлбөр хэрэгжих орчин бүрдсэн | • **Санхүүжилтийн хязгаарлагдмал байдал:** Шинэ барилга, тоног төхөөрөмжид ихээхэн хөрөнгө зарцуулж, бусад чухал зардлыг танах шаардлага гарсан.<br>• **Олон улсын хөтөлбөрийн хамтын ажиллагаа хязгаарлагдмал:** Магистрын сургалтын олон улсын төсөл, тэтгэлгийн хүрээ өргөжих шаардлагатай.<br>• **Цахим номын фондын дутагдал:** Цахим номын фондын хэмжээ өргөжүүлэх |
| **Боломж/O** | **Эрсдэл/T** |
| • **Олон улсын хамтын ажиллагаа:** Гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар магистрын сургалтыг өргөжүүлэх.<br>• **Судалгааны баазын шинэчлэл:** Олон улсын санхүүжилттэй төслүүдээр дамжуулан судалгааны лаборатори, тоног төхөөрөмжийг өргөжүүлэх.<br>• **Оюутны тэтгэлэг, дэмжлэг нэмэгдүүлэх:** Төр болон хувийн хэвшлийн санхүүжилт, хандивын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх. | • Магистрын хөтөлбөр хэрэгжилтэд зарцуулж буй төсвийг нэмэгдүүлэх<br>• Техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломжийг судалж, багш оюутан, цахимаар сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, арга хэмжээ авах<br>• Орчин үеийн судалгааны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх |

| OS стратеги | OW стратеги |
|---|---|
| • **Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх:** Сургалтын орчин, тоног төхөөрөмжийн давуу талыг ашиглан олон улсын судалгааны төсөл, хөтөлбөрт оролцох боломжийг нэмэгдүүлэх.<br>• **Цахим орчныг хөгжүүлэх:** Цахим орчныг өргөжүүлж, олон улсын мэдээллийн сан, онлайн сургалтад хандах боломжийг нэмэгдүүлэх.<br>• **Оюутны тэтгэлэг, дэмжлэг нэмэгдүүлэх:** Санхүүгийн эх үүсвэрүүдийг үр ашигтай ашиглан оюутнуудад илүү олон тэтгэлэг олгох. | • **Номын сангийн хүрэлцээг сайжруулах:** Цахим болон үндсэн номын фондыг нэмэгдүүлэх замаар оюутны судалгааны хэрэгцээг хангах.<br>• **Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх:** Гадаадын байгууллага, түншүүдээс санхүүгийн дэмжлэг авах хөтөлбөрүүдийг санаачлах.<br>• **Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх:** Багшлах боловсон хүчний сургалт, хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг сайжруулах. |
| **TS стратеги** | **TW стратеги** |
| • **Санхүүгийн эрсдэлийг бууруулах:** Давуу тал болох сургалтын орчин, тоног төхөөрөмжийг ашиглан нэмэлт орлого олох бизнес санаачилга гаргах.<br>• **Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх:** Сургалтын чанарт суурилсан маркетингийн стратегийг хэрэгжүүлж, өөрийн онцлогийг өрсөлдөх давуу тал болгон ашиглах.<br>• **Технологийн дэд бүтцийг бэхжүүлэх:** Цахим орчин, мэдээллийн технологийн давуу талуудыг өрсөлдөх чадварын түлхүүр болгон хөгжүүлэх. | • **Багшлах боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх:** Олон улсын сургалт, туршлагаас суралцах, мэргэжил дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх.<br>• **Санхүүгийн зохицуулалтыг оновчтой болгох:** Шаардлагагүй зардлыг бууруулах замаар санхүүгийн хүндрэлийг даван туулах.<br>• **Мэдээллийн технологийн хөгжлийг хурдасгах:** Олон улсын стандартын программ, технологийг нэвтрүүлэх замаар сургалтын орчныг сайжруулах. |

### 5.5 Сайжруулах арга зам

1. Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн шинэ цогцолбор барилгын тохижилтын ажлыг амжилттай хийж, сургалт судалгааны төвийг тогтмол нээлттэй ажиллуулах.
2. Цахим мэдээллийн системийг илүү боловсронгуй болгох
3. Номын сангийн фондыг нэмэгдүүлэх

### 5.6 Үнэлгээ

"Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийг  үр дүнтэй хэрэгжүүлэхэд анги танхим, спорт заалнууд, лаборатори, чийрэгжүүлэх өрөө, спортын анагаах ухааны төв, багаж хэрэгсэл, материаллаг бааз, багшийн ажиллах орчин нь шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл сайжруулалт хийдэг гэж үнэллээ.

Хүснэгт 5.10 "Нөөц ба санхүүжилт"ийн өөрийн үнэлгээ

| Шалгуур | Үзүүлэлт | Хэмжээс | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **5.1.** | Магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх сургалтын орчин нөхцөл бүрдүүлсэн байх | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг ханган тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг<br>**Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан<br>**Сайжруулах шаардлагатай:** Нэг үзүүлэлтийг хангасан<br>**Хангалтгүй:** Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | **Хангалттай сайн** |
| | Сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулдаг байх | | |
| **5.2.** | Ахисан түвшний сургалт явуулахад шаардлагатай ном, үндсэн сурах бичиг, гарын авлага, сэтгүүл хангалттай эсэх | | **Хангалттай** |
| | Сургууль, тэнхимээс хөтөлбөр дагасан сурах бичиг, гарын авлага, шинээр боловсруулах, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг байх | | |
| **5.3.** | Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулахаар төсөвлөсөн байна. | | **Хангалттай** |
| | Багш нарын хөгжилд тодорхой төсөв зарцуулдаг байх | | |

### 5.7 Дүгнэлт

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг бааз, технологийн дэвшлийг тасралтгүй сайжруулж, магистрант, багш нартаа зориулан цогцолбор барилга байгууламж барьсан нь энэхүү хөтөлбөрийг цааш хэрэгжүүлэхэд орчны нөхцөлийг бүрэн хангах боломжтой болж байна гэж дүгнэлээ. Мөн цахим технологи, мэдээллийн хэрэгслүүдээ улам сайжруулан мэргэжлийн хүмүүсээс заавар зөвлөгөө авч энэ талын баазыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

## ШАЛГУУР 6. УДИРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захирганы зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

### 6.1 Засаглал ба удирдлага

*Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоотой, захирганы бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.*

Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

Сургууль нь үндэсний болон олон улсын стандарт, мөн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, чанартай үйлчилгээ үзүүлдэг.

**Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааны журам, үүрэг:**

Сургууль нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх явц, үр дүнг хянах, үнэлэх, чанарыг баталгаажуулах бодлого, эрх зүйн зохицуулалтыг хариуцсан хороодыг байгуулж хөтөлбөрийн багуудын ажлын уялдааг хангаж, удирдан зохион байгуулдаг.

**ҮБТДС-ийн хөтөлбөрийн хорооны бүтэц**




*Зураг 6.1 ҮБТДС-ийн хөтөлбөрийн хорооны бүтэц*

Сангийн сайдын 1997 оны 138/198, БСШУ-ны сайдын 1996 оны 84, 2011 оны 217 тоот тушаалаар батлагдсан 10 мэргэжлийн индекс, хөтөлбөрийг хэрэглэн мөрдөж, сургалтын үйл ажиллагааг явуулж ирсэн. “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал (2022 он, №А/343) гарсантай холбогдуулан бид сургуулийнхаа хэв шинж, уламжлал, залгамж чанар, биеийн тамир, спортын салбарын мэргэжлийн хэтийн хэрэгцээ,

шаардлагыгаа харгалзан 2022-2023 оны хичээлийн жилээс үйл ажиллагаандаа дараах мэргэжлийн хөтөлбөр, индексийг шинээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Хүснэгт 6.1 ҮБТДС-н хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөр

| № | Хөтөлбөрийн индекс | Мэргэжлийн чиглэл | Сургалтын агуулгын багтаамж /Багц цаг/ | Төгсөгчдөд олгох боловсролын зэрэг /Бакалавр/ | Мэргэжлийн чиглэлээр сургалт эрхлэх зөвшөөрөл олгосон шийдвэрийн он, сар, өдөр, дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 011437 | Багш, биеийн тамирын боловсрол | 124 кр | Бакалавр | БСШУС-ын 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн А/343 тоот тушаал |
| 2 | 101401 | Спортын дасгалжуулагч | 129 кр | Бакалавр | |
| 3 | 101402 | Биеийн тамирын арга зүйч | 129 кр | Бакалавр | |
| 4 | 101503 | Спорт аялал жуулчлал | 129 кр | Бакалавр | |
| 5 | 041303 | Менежмент | 129 кр | Бакалавр | |
| 6 | 011438 | Биеийн тамирын боловсрол | 32 кр | Магистр | |
| 7 | 101401 | Спортын дасгалжуулагч | 32 кр | Магистр | |

***Хөтөлбөрийн хороо, дэд хороод***

ҮБТДС-ийн сургалтын хөтөлбөр боловсруулах Хөтөлбөрийн хороо, дэд хороодыг 2016 оны 05 дугаар сарын 03-ны Захиргааны Зөвлөлийн хурлын шийдвэрээр 9 төлөөлөлтэй байгуулсан бол 2018 онд бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж дэд хороодын бүрэлдэхүүнд 3 хүнийг шинээр нэмсэн.Үүнд:

**Хөтөлбөрийн хороо**-9 хүний /төлөөллийн/бүрэлдэхүүнтэй

1.Хөтөлбөрийн Хорооны дарга-ҮБТДС-ийн захирал

2.Даргын туслах- Хөтөлбөрийн албаны дарга

Гишүүд:

3.ЭЗ-ийн төлөөлөл-Эрдэмтэн н/б-ийн дарга

4.СА-ны төлөөлөл-Сургалтын албаны дарга

5.ЧБА-ны төлөөлөл-Чанарын баталгаажуулалтын албаны дарга

6.ОАЗТ-ийн эрхлэгч

7.ҮСМТ-ийн эрхлэгч

8.БТЭАЗТ-ийн эрхлэгч

9.Төгсөгчийн төлөөлөл

**Дэд хороодод:**

1. ОАЗТ-ийн дэд хороо – Р.Ганбаатар – 4 багшийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн хөтөлбөрийн баг
2. ҮСМТ-ийн дэд хороо – Б.Хэрлэн – 4 багшийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн хөтөлбөрийн баг
3. БТАЗТ-ийн дэд хороо- Ш.Бат-Эрдэнэ – 4 багшийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн хөтөлбөрийн баг

***Хөтөлбөрийн баг, зохицуулагчдын чиг үүргийн оновчтой байдал, хэрэгжилтийн түвшин***

Сургуулийн Сургалтын алба болон Хөтөлбөрийн алба хамтран хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулж, салбарын мэргэжилтнүүд, багш, оюутнууд зэрэг оролцогч талуудын саналыг мэргэжлийн тэнхимүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ажиллаж ирлээ.

Сургуулийн удирдлагын бүх шатанд шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд оролцогч талууд болон багш, ажилчин, суралцагчдын санал хүсэлтийг харгалзан тусгадаг байдал уламжлагдан залгамж чанартай явагдаж байна.




*Зураг 6.2 Хөтөлбөрийн шинэчлэл хийгдсэн байдал*

Хүснэгт 6.2 Хөтөлбөрийн хорооны бүтэц

| **Хөтөлбөрийн хорооны бүтэц зохион байгуулалт** | |
|---|---|
| БШУЯ-ны сайдын **2024 оны А/147** тоот тушаалын дагуу "ДБС-ын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага" -ыг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой дараах шийдвэрүүд гарсан. | |
| /ҮБТДС-ийн дүрэм, 2018 оны 05-р сарын 18-ны өдрийн Захиргааны Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн баталсан захирлын тушаал/ | Захирлын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 18 тоот тушаалын хавсралтаар сургалтын хөтөлбөр хороо байгуулагдсан бөгөөд хянан шалгах Хөтөлбөрийн хороо, дэд хороод өргөтгөн зохион байгуулсан. Дэд хороод нь хөтөлбөрийн зорилго, гарах үр дүн, эрх зүйн баримт бичгийн хэрэгжүүлэлт, хичээлийн стандартын шалгуурт нийцсэн, сургалтын арга зүйд тулгуурлагдсан эсэхийг хянаж ажиллана. |
| /ҮБТДС-ийн дүрэм, 2024 оны оны 03-р сарын 11-ны өдрийн Эрдмийн Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн баталсан захирлын тушаал/ | 2023-2024 оны хичээлийн жилд "Багш, биеийн тамирын боловсрол", "Спортын дасгалжуулагч", "Биеийн тамирын арга зүйч хөтөлбөрүүдийг БМИҮЗөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн. |

| | |
|---|---|
| /ҮБТДС-ийн дүрэм, 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн Захиргааны Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн баталсан захирлын тушаал/ | Бодлого, эрх зүйн бичиг баримтуудын чанар, хэрэгжилтийн түвшин “Дээд боловсролын тухай” хуульд заасны дагуу “Багш, биеийн тамирын боловсрол”, “Менежмент”, “Аялал жуулчлалын менежмент”, “Спортын дасгалжуулагч”, “Биеийн тамирын арга зүйч хөтөлбөрүүдээр "Сургалтын төлөвлөгөө"-үүдийг эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн захирлын ҮБТДС -ийн дүрэм, 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн Захиргааны Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн баталсан захирлын тоот тушаалаар баталж, шинэчлэн боловсруулалт хийж 2025-2026 оны хичээлийн жилээс мөрдөхөөр ажиллаж байна. |

| Хөтөлбөрийн Хороо-9 хүний /төлөөллийн/ бүрэлдэхүүн | Дэд хороод | |
|---|---|---|
| 1.Хөтөлбөрийн Хорооны дарга-ҮБТДС -ийн захирал<br>2.Даргын туслах- Хөтөлбөрийн албаны дарга<br>Гишүүд:<br>1.ЭЗ-ийн төлөөлөл-Эрдэмтэн н/б-ийн дарга<br>2.СА-ны төлөөлөл-Сургалтын албаны дарга<br>3.ЧДБА-ны төлөөлөл-Чанарын дотоод баталгаажуулалтын албаны дарга<br>4.ОАЗТ-ийн эрхлэгч<br>5. ҮСМТ-ийн эрхлэгч<br>6. БТЭАЗТ-ийн эрхлэгч<br>7.Төгсөгчийн төлөөлөл | 1. ОАЗТ-ийн дэд хороо<br>2. ҮСМТ-ийн дэд хороо<br>3. БТЭАЗТ-ийн дэд хороо | Бакалаврын боловсрол- МХБ<br>1. Багш,биеийн тамирын боловсролын МХБ<br>2. Спортын дасгалжуулагчийн МХБ<br>3. Биеийн тамирын арга зүйчийн МХБ<br>4. Аялал, жуулчлал, Спортын менежментийн МХБ<br><br>Магистрын боловсрол- МХБ<br>1. Багш,биеийн тамирын боловсролын МХБ<br>2.Спортын дасгалжуулагчийн МХБ |




*Зураг 6.3 Хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хянах, сайжруулах үйл явцын мөчлөг*

Бид багш бэлтгэдэг байгууллагууд, оролцогч талууд, багш, магистрантуудын саналыг хөтөлбөртөө тусган удирдлагаар хангаж, хөтөлбөрийг боловсруулах шинэлэг шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийг сайжруулан шинэчлэн боловсруулах ажлыг 2018 онд хийсэн. 2018-2022 онуудад шинээр боловсруулсан хөтөлбөрүүдээ сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн юм. 2022 оноос хэрэгжилтийн явцад илэрсэн засварлаж өөрчлөх, сайжруулах шаардлагатай асуудлуудыг мэргэжлийн тэнхимүүдээр хэлэлцүүлэн улмаар хөтөлбөрийн хороо, дэд хороод, эрдмийн зөвлөлийн хурлаар оруулан баталгаажуулан ажиллаж ирсэн. Дээрх хугацаанд тэнхим, багш нарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаа.

Хөтөлбөрийн багийн үндсэн үүрэг нь тэнхимүүдээр дамжуулан хөтөлбөрийн бүрэлдэхүүний иж бүрдлийг хангуулах, хамгийн чухал нь сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг тэргүүн ээлжид шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахад чиглэгдэнэ. Энэ шаардлагыг хангасан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг эхний ээлжид мэргэжлийн багш нарын оролцоотойгоор дэд хороод тэнхимийн хэмжээнд хэлэлцүүлж, боловсруулан Хөтөлбөрийн Хороогоор /“Хөтөлбөрийн баг”-аар/ хянуулан, мэргэжлийн зөвлөгөө өгөх эрдэмтдийн бүлгийн саналыг тусган боловсруулав ҮБТДС-ийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 35 тоот тушаалын хавсралт “ ҮБТДС-ын магистрын сургалтын журам”-д “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг хөтөлбөрийн алба зохион байгуулж, удирдлагаар хангана” гэж заасны дагуу “Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрийг боловсруулах баг, хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх багш нар, хөтөлбөрийг сонгон суралцаж буй оюутнууд болон бусад оролцогч талуудын дэвшүүлсэн саналуудыг хөтөлбөртөө тусган удирдлагаар хангаж, ҮБТДС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын удирдамж, заавар, багш боловсролын шинэчлэлийн бодлого, МИҮЗ болон олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн мэргэжлийн байгууллагуудын шаардлага, олон улсын багш бэлтгэдэг Их, дээд сургуулиудын хөтөлбөрийн шаардлагын түвшинд ойртуулан сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулах ажлыг тодорхой үе шаттайгаар хийж байна.

Дээрх хугацаанд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх багш нарын бүрэлдэхүүнийг МИҮЗ-өөс зохион байгуулсан хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн болон хөтөлбөрийг боловсруулах мэдээллээр хангах, зөвлөмж өгөх сургалт семинарт 4 удаа оролцууллаа. Мөн хөтөлбөрийн албанаас хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх багш нартай хамтран ажиллах, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн дэд хороодоор хэлэлцүүлэн санал, зөвлөмжүүдийг хүргүүлэн дахин сайжруулах хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлыг тасралтгүй хийж ирсний зэрэгцээ хичээлийн жишиг хөтөлбөрийн загварыг лекц, семинар, дадлагын хичээлүүдээр гаргаж тэнхим, хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт хүргүүлж ажилласан. Цуврал хэлэлцүүлгээс хөтөлбөрт тусган сайжруулах саналуудыг тэнхим, багш нарт хүргүүлсэн. Тухайлбал;

- Хөтөлбөрийн нийт хуудасны багтаамж, хичээлийн тодорхойлолт, үсгийн фонд
- Хичээлийн төлөвлөлт, арга зүй, ерөнхий үр дүн
- Хичээлийн агуулга
- Хичээлийн үнэлгээ

- Үндсэн сурах бичгийн жагсаалт, суралцагсдын бие даан судлах ном, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж зэргийн талаар нэгдсэн ойлголт өгч, удирдлагаар ханган ажиллаа.

"Биеийн тамирын боловсрол" магистрын сургалтын хөтөлбөрийн ерөнхий танилцуулга, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, сургалтын төлөвлөгөө, сургалтын арга зүй, сургалтын орчин, элсэгчдэд тавих шаардлага, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх багш нарын судалгаа, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, харилцаа хамтын ажиллагаа зэрэг чиглэлүүдийг тодорхойллоо.

ҮБТДС-ийн дүрэм, 2022 оны 12 дугаар сарын 22-ны Захиргааны Зөвлөлийн хурлын шийдвэрт заасны дагуу өмнөх онд гаргасан хичээлийн хөтөлбөрийг сайжруулан боловсруулах ажлын удирдамж, заавры үндэслэн нийт 8 хичээлийн хөтөлбөрийг мэргэжлийн тэнхимүүд боловсруулан хөтөлбөрийн хороо болон салбар хороогоор хэлэлцүүлэн батлуулж, сургалтад мөрдөж эхэлсэн.

### 6.2 Ажилтнууд

*Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.*

**ҮБТДС-ийн захиргаанд 15 хүн ажилладаг.** Үүнд: Захирал-1, дэд захирал-1, нарийн бичиг-1, нягтлан бодогч-1, сургалтын менежер-1, мэдээлэл технологийн инженер-1, номын сан -1, барилга хариуцсан дарга-1, барилгын хяналтын инженер-1, цахилгаан дулааны инженер ажилтан-1, харуул хамгаалалтын ажилтан-2, үйлчлэгч-3 хүн үндсэн орон тоон дээр ажилладаг бөгөөд сургалтын хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэвийн нөхцөл байдлыг хангадаг.

Багш, ажилтнуудыг өсөж дэвжих, тогтвортой хөгжихөд зориулж мэргэжлийн болон чиглүүлэх, хувь хүний хөгжлийн сургалтуудыг жил бүр зохион байгуулдаг. Сүүлийн таван жилийн хугацаанд мэргэжилтэн, захиргааны ажилтнуудын хамрагдсан мэргэжлийн болон чиглүүлэх томоохон сургалтаас дурдвал; нягтлан бодогч А.Амармандах нийгмийн даатгалын болон татварын хуулийн шинэчилсэн агуулгаар богино хугацааны сургалт, нягтлан бодох бүртгэлийн шинэчлэгдсэн программын сургалт зэрэгт хамрагдсан байна

Тус сургуулийн номын санч Б.Пүрэв номын сангийн шинэчилсэн цахим системийн сургалтад хамрагдсан, хяналтын инженер Ч.Тэмүүлэн мэргэшсэн инженерийн болон барилгын төсөвчний сургалтад хамрагдсан байна

ҮБТДС-н дэд захирал Л.Гүндэгмаа боловсролын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн сургалтад хамрагдсан.

Хөтөлбөрийн албаны мэргэжилтнүүд хичээл сургалтын үйл ажиллагаатай холбоотой болон хөгжүүлэх, мэргэжлийн чиглэлийн сургалтуудад тогтмол идэвхтэй оролцож, ажил мэргэжилдээ өсөн дэвжиж, мэргэжлийн хувьд мэргэшин чадваржсаар байна. БТЭАЗүйн тэнхимийн эрхлэгч Ш.Бат-Эрдэнэ АШУҮИСургуулийн докторын сургалтын дүүргэв.

### 6.3 Удирдлага мэдээллийн систем

*Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй*

*байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.*

ҮБТДС нь боловсролын яам, сургалтын алба, хүний нөөц, санхүү, багш болон суралцагчдын хооронд мэдээлэл солилцох харилцаа, холбоог мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах орчин бүрдүүлэхийн тулд орчин үеийн техник технологид суурилсан мэдээллийн систем, программ хангамжуудыг ашигладаг.

***Дээд боловсролын мэдээллийн систем (HEMIS)*** – Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын яам, түүний харьяа байгууллага хоорондын үйл ажиллагааны мэдээлэл солилцох, удирдах систем юм. Манай сургууль нь 2014 оноос хойш тасралтгүй ашиглаж байгаа ба үүгээр дамжуулан суралцагч, төгсөлт, багш, эрдэм шинжилгээ, сургалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагуудтай хуваалцдаг.

***Удирдлагын мэдээллийн систем*** – 2016-2024 оны хооронд сургалт болон санхүүгийн үйл ажиллагааг “ECM” ХХК-тай гэрээ байгуулан UNIMIS удирдлагын мэдээллийн системийг ашиглан явуулдаг байсан.



*Зураг 6.4 Программ хангамжийн үндсэн модулиуд*

UNIMIS систем нь хэдийгээр багш, суралцагч, сургалтын албаны модуль болон санхүүгийн модуль зэрэг олон дэд модулиудаас бүрддэг ч модуль хоорондын интеграци муу, тайлан мэдээ гаргалт дутуу, хүний нөөц, элсэлт зэрэг сургалтын удирдлагын системд заавал байх ёстой систем байхгүй, хөгжүүлэлтийн явц удаан байдаг зэргээс шалтгаалж энэхүү системийг цаашид сургалтын удирдлагад ашиглахад төвөгтэй байсан тул 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн ашиглахаа больсон.

***2024 оны 11-р сарын 18-ны өдөр “ЮТИЛИТИ СОЛЮШН” ХХК-тай гэрээ байгуулан хуучин системийг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор Smart University System (SUS) системийг өөрсдийн сургалтын удирдлагын систем болгон ашиглахаар болсон.***

Энэхүү систем нь дараах дэд системүүдээс бүрддэг бөгөөд хоорондоо интеграци хийгддэг. Үүнд:

- ***Сургалтын удирдлагын систем*** (http://sis.nipe.edu.mn) - Сургалтын удирдлагын систем нь хичээлийн стандарт, хөтөлбөр, анги, оюутан, хичээл,

хуваарь, тэтгэлэг, дүн, суралцагчдын сургалтын төлбөрийн зэрэг мэдээллийг бүртгэх удирдах боломжийг олгодог. Оруулсан бүх мэдээллийг excel файл болгон татах болон суралцагчдын мэдээллийн график болгон тайлан байдлаар авах боломжтой.







*Зураг 6.5 Сургалтын удирдлагын систем*

- ***Хүний нөөцийн систем*** (http://hr.nipe.edu.mn) - Хүний нөөцийн системд багш, ажилчдын мэдээллийг бүртгэснээр ажилчдын ирц, томилолт, өргөдөл, гомдол болон ажилчдын дунд явуулах сургалт, судалгаа зэргийг явуулах боломжтой болсон.
- ***Багшийн систем*** (http://professor.nipe.edu.mn) - Багшийн систем нь багш заах буй хичээлийнхээ мэдээлэл, лекц, семинарыг оюутан бүрд хүртээмжтэй байлгахын тулд мэдээллийг оруулах, ирц, явц, бие даалт зэрэг дүнгийн мэдээлэл оруулах боломжийг олгодог. Мөн эрдэм, шинжилгээний модулийн хүрээнд багш өөрийн бүтээл, тавьсан илтгэл, нийтэлсэн өгүүлэл, эшлэлийн талаарх мэдээллийг оруулах боломжтой ба ингэснээр цаашид багшийн ажлын үр дүнг дүгнэх, шагнал, урамшуулал тооцоход дөхөм болно.
- ***Оюутны систем*** (http://student.nipe.edu.mn) - Оюутны веб нь оюутанд өөрийн үзэх хичээлийн сонгох, сонгосон хичээлийн мэдээлэл явцыг харах боломж олгодог. Мөн сургуулийн тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт болон сургалтын төлбөрийн үлдэгдэл зэргийг мэдэх боломжтой. Энэхүү системээр дамжуулан багшийн туслахаар ажиллах, чөлөөний хүсэлт, санал гомдол зэргийг илгээж болно. Багшийн оруулсан лекц, семинар болон даалгавар харах, илгээх боломжтой.
- ***Номын сангийн систем (***http://library.nipe.edu.mn***)*** – Номын санч өөрийн номын сан дах номын мэдээллийг ангилан бүртгэх боломжтой ба тухайн сар, жилээр тайлан мэдээ гаргах боломжтой. Багш, оюутан бүр номын сангийн катологиос ном хайх боломжтой ба хэрэв тухайн ном электрон хэлбэртэй бол шууд унших болон захилга өгөх боломжтой.

Дээрх системүүд мөн тестийн модуль, эрдэм шинжилгээний модуль, өөрийн үнэлгээний модуль, санхүүгийн модуль болон зайн сургалтын модулиудыг агуулдаг.

**Номын сангийн цогц систем (Lib4U) –** Энэхүү программ хангамж нь электрон номын сан, электрон каталог байгуулах, номын сангийн хөмрөгт байх ном, тогтмол хэвлэл, эрдмийн ажил, аудио видео гэх мэт материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх үйл ажиллагааг автоматжуулах, номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан, статистик мэдээллээр хангагдах боломж олгодог. Мөн бусад их дээд сургуулийн нээлттэй

номын санд байрлах ном, бичвэрүүдийг унших боломжтой байдгаараа давуу талтай.

### 6.4 Мэдээллийн ил тод байдал

*Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчид, олон нийтэд нээлттэй хүргэж, тогтмол шинэчилдэг байна.*

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн  мэдээллийг түгээдэг байна.

***Нийгмийн сүлжээгээр сурталчлах***

ҮБТДС нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, веб сайт, телевиз, сонин сэтгүүлээр олон нийтэд өөрийн сургууль, салбар нэгжүүдийн үйл ажиллагаа, сургалт, эрдэм шинжилгээ, арга зүй, зохион байгуулалтын талаар үнэн зөв мэдээлэх, харилцан ойлголцох, итгэл үнэмшлийг бэхжүүлэхийн төлөө тасралтгүй ажиллаж байна. ҮБТДС-ийн дотоод журамд заагдсан нийгмийн соён гэгээрүүлэх үйлчилгээг суралцагсдадаа тасралтгүй үзүүлдэг.

ҮБТДС-ийн веб сайтыг төрийн байгууллагын веб сайтад тавигдах MNS 6285 стандартын дагуу хийж сайжруулах, мэдээллийн агуулга, багтаамжийг тогтмол сайжруулж байхаар төлөвлөн, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Жил бүрийн 6 дугаар сард Үндэсний олон нийтийн радио телевиз болон бусад телевизүүдтэй гэрээтэй ажиллан өөрийн сургууль, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн онцлог давуу талуудыг нийтэд түгээн сурталчлахын зэрэгцээ энэ ажлыг явуулахад Facebook платформ, пэйж хуудас ашиглан сонирхсон хүн бүрд тодорхой мэдээллүүдийг хүргэж үйлчилдэг. Давхардсан тоогоор жил бүр 500 гаруй контент, мэдээллийг нийтэд хүргэж, 50-60 хүнд сонирхсон асуудлаар ойлголт өгч ажиллаа.

***Оюутны цахим хуудас***

Магистрант бүр өөрийн нэвтрэх эрхээр оюутны веб хуудсанд нэвтрэн хичээлийн хуваарь, дүнгийн мэдээлэл, сургалтын төлөвлөгөө, тодорхойлолт болон судлах хичээлийн мэдээллийг авах боломжтой.






*Зураг 6.6 Оюутны вебийн харагдах байдал*

Цаашид “Биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн хичээлүүдийг онлайн хэлбэрээр нийт төгсөгчид болон магистрантуудад танилцуулж, хөтөлбөрийн хичээл бүрийн үр дүнг танилцуулж, судлах аргыг нь ойлгуулна. Мөн хөтөлбөрийн ил тод байдлыг дээшлүүлэхийн тулд онлайн танилцуулгыг сайжруулах, оюутан нэг бүрд хүргэх талаар анхаарч ажиллана. Гол нь мэдээллийн контентуудын агуулга, дизайныг сайжруулах, тогтмол ажиллуулж хэвшихэд анхаарч ажиллах шаардлагатай.

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

***Хэвлэмэл хуудас тараах***

Эцэг эх, ЕБС-ийн төгсөгч нарт зориулан Сургуулийн болон хөтөлбөрүүдийн давуу тал, онцлогийг харуулсан хэвлэмэл хуудсыг сайжруулан боловсруулж, жил бүр 1000 ш-г хэвлүүлэн “Боловсролын үзэсгэлэн яармаг”, уулзалт арга хэмжээ, үзүүлэх тоглолт, спортын уралдаан тэмцээн, хөтөлбөр сурталчлах өдөрлөг зэрэг үйл ажиллагааны үеэр тарааж сурталчилсан.







*Зураг 6.7 Хэвлэмэл хуудас*

***Элсэгчдэд зориулсан үзүүлэх тоглолт, тэмцээн зохион байгуулах***

Тус сургуулиас жил бүрийн 4 дүгээр сараас эхлэн спортын арга хэмжээнүүдийн үед болон ЕБС-ийн сургуулиуд дээр өөрийн сургуулийг сурталчилсан спортын үзүүлэх тоглолтыг давхардсан тоогоор 2018 онд- 6 удаа, 2019 онд- 8 удаа тус тус зохион байгуулж, 300-аад оюутнуудыг хамруулсан. Мөн 2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилийн 9 дүгээр сарын 3 дахь долоо хоногт шинээр элссэн нэгдүгээр ангийн оюутнуудын дунд Үндэсний бөх, Сагсан бөмбөг, Волейболын төрлүүдээр тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд энэ арга хэмжээнд жил бүр 300-аад элсэгч оролцжээ.

**6.5 Шалгуур 6 SWOT, TOWS шинжилгээ**

| Давуу тал (Strength) | Сул тал (Weakness) |
|---|---|

| | |
|---|---|
| • **Эффектэд удирдлагын бүтэц:** Хөтөлбөрийн зорилгод нийцсэн засаглал, удирдлагын тогтолцоо, үр дүнтэй хороод, дэд хороодын зохион байгуулалт.<br>• **Мэдээллийн технологийн дэвшилтэт шийдэл:** UNIMIS болон Smart University System зэрэг системийг ашиглан сургалт, санхүүгийн үйл ажиллагааг автоматжуулсан.<br>• **Хамтын ажиллагааны оролцоог дэмжих:** Багш, оюутнууд, захиргааны ажилтнуудын санал хүсэлтийг хөтөлбөрт тусгах тогтолцоо бүрдүүлсэн.<br>• **Сургалтын чанарыг баталгаажуулах тогтолцоо:** Чанарын баталгаажуулалтын хороод, дэд хороодоор дамжуулан хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянах, үнэлэх. | • **Цахим сургалтын агуулгын хүртээмж хязгаарлагдмал:** Зайн сургалтын хичээлүүдийг бүрэн нэвтрүүлэх шаардлага бий.<br>• **Хүний нөөцийн ур чадварын ялгаа:** Тодорхой чиглэлээр ажиллаж буй захиргааны ажилтнуудын мэргэшил, сургалтын хэрэгцээ хангалтгүй.<br>• **Хөтөлбөрийн шинэчлэлийн хугацаа:** Хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явц харьцангуй удаан, оролцогч талуудын шийдвэр гаргалтад хугацаа зарцуулагддаг. |
| **Боломж (Oppotiunities)** | **Эрсдэл (Threats)** |
| • **Олон улсын хамтын ажиллагаа:** Гадаадын их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж мэдээллийн системийг хөгжүүлэх боломж.<br>• **Шинэ технологи нэвтрүүлэх:** Хүний нөөцийн систем, зайн сургалт зэрэг шинэ дэд системийг өргөжүүлэх.<br>• **Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах:** Олон нийтэд зориулсан мэдээлэл түгээх сувгуудыг өргөжүүлэх замаар хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх. | • **Технологийн шинэчлэлийн зардал өндөр:** Системүүдийн шинэчлэл, техник хангамжийн зардал нь хөтөлбөрийн бусад хэрэгцээнд нөлөөлж болзошгүй.<br>• **Өрсөлдөөн:** Бусад их, дээд сургуулиудтай мэдээллийн системийн үр ашиг болон сургалтын чанараар өрсөлдөх шаардлага.<br>• **Мэдээллийн аюулгүй байдал:** Электрон системүүдийн нууцлал, аюулгүй байдлын асуудал. |
| **OS стратеги** | **OW стратеги** |
| • **Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх:** Мэдээллийн системийн давуу талуудаа ашиглан гадаад түншүүдтэй хамтран технологи, сургалтын шинэчлэлд оролцох.<br>• **Шинэ технологи нэвтрүүлэх:** Дотоодын удирдлагын системд хүний нөөцийн болон зайн сургалтын модулиудыг нэвтрүүлэх замаар багш, оюутны оролцоог нэмэгдүүлэх.<br>• **Ил тод байдлыг сайжруулах:** Мэдээллийн ил тод байдлыг дэмжих маркетингийн стратегийг хэрэгжүүлж олон нийтэд хүрэх сувгуудыг өргөжүүлэх. | • **Хүний нөөцийн чадавхыг сайжруулах:** Захиргааны ажилтнуудын сургалтыг дэмжиж, мэргэжлийн чиглэлээр ур чадвар дээшлүүлэх.<br>• **Цахим сургалтыг өргөжүүлэх:** Зайн сургалтын хичээлийг боловсруулж, цахим орчны хүртээмжийг нэмэгдүүлэх.<br>• **Шинэчлэлийн хурдац:** Хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг хурдасгах, оролцогч талуудын санал хүсэлтийг шуурхай тусгах тогтолцоо бүрдүүлэх. |

| ST стратеги | WT стратеги |
|---|---|
| • **Санхүүгийн эрсдэлийг бууруулах:** Мэдээллийн системийн зардлыг бууруулахад чиглэсэн зохистой бодлого хэрэгжүүлэх.<br>• **Өрсөлдөөний давуу талыг нэмэгдүүлэх:** Чанарын баталгаажуулалтын тогтолцоог өрсөлдөх давуу тал болгон ашиглах.<br>• **Мэдээллийн аюулгүй байдлыг хангах:** Электрон системийн нууцлал, хамгаалалтын түвшинг сайжруулах. | • **Шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлэх:** Хөтөлбөрийн шинэчлэлийн хороодын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж шийдвэр гаргалтыг хурдасгах.<br>• **Мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх:** Технологийн хөгжлийг дэмжих чадвартай мэргэжилтнүүдийг ажилд авах, дотоод сургалтаар бэлтгэх.<br>• **Зардлын оновчлол:** Зардлыг нарийвчлан тооцож, мэдээллийн системийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх. |

### 6.6 Сайжруулах арга зам

- **Мэдээллийн системийн шинэчлэлийг үргэлжлүүлэх:** Smart University System-ийн хөгжүүлэлтийг сайжруулж, хүний нөөц, зайн сургалт, тестийн модуль зэрэг шинэ дэд системийг нэмэгдүүлэх.
- **Цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх:** Зайн сургалтын хөтөлбөрүүдийг сайжруулж, контент боловсруулах багийг мэргэшүүлэх сургалтад хамруулах.
- **Хүний нөөцийн хөгжлийг дэмжих:** Захиргааны ажилтнууд болон багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх.
- **Системийн аюулгүй байдлыг сайжруулах:** Электрон мэдээллийн аюулгүй байдлын өндөр стандартыг нэвтрүүлж, өгөгдлийн нууцлал, хамгаалалтыг баталгаажуулах.
- **Ил тод байдлыг хангах:** Хөтөлбөрийн талаарх мэдээллийг цахим платформоор дамжуулан нийтэд нээлттэй байлгаж, оролцогч талуудын санал хүсэлтийг шуурхай тусгах тогтолцоог бэхжүүлэх.

### 6.7 Үнэлгээ

Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийн "Удирдлага ба мэдээллийн систем" хэсгийн өөрийн үнэлгээний тайлан нь их сургуулийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлагад нийцэж байна.

Хүснэгт 6.3 Удирдлага мэдээллийн системд хийсэн өөрийн үнэлгээ

| Шалгуур | Үзүүлэлт | Хэмжээс | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|
| **6.1** | Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо,захиргааны бүтэц | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг хангаан тэнхимийн санаачилгаар үйл | **Хангалттай сайн** |

| | | | |
|---|---|---|---|
| **6.2** | Сүүлийн 5 жилд захиргааны болон туслах ажилтны ажил мэргэжилдээ өсөн дэвжиж, мэргэжил дээшлүүлсэн байдал | ажиллагааг тогтмол явуулдаг<br><br>**Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан<br><br>**Сайжруулах шаардлагатай:** Нэг үзүүлэлтийг хангасан<br><br>**Хангалтгүй:** Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | **Хангалттай сайн** |
| **6.3** | Удирдлагын мэдээллийн системийн хөгжил | | **Хангалттай сайн** |
| | Хөтөлбөрийг удирдахад удирдлагын мэдээллийн системийн үүрэг | | **Хангалттай сайн** |
| | Хөтөлбөрийгсайжруулахад дүн шинжилгээг ашигласан байдал | | **Хангалттай сайн** |
| | Элсэгч, суралцагч, төгсөгчид болон оролцогч талуудад хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй хүргэдэг систем бүрдсэн эсэх, үр дүн, сайжруулалт | | **Хангалттай сайн** |
| | Багш, суралцагчдад шинэчилсэн мэдээллийг тухай бүрд шуурхай мэдээлдэг арга хэрэгслийн хөгжүүлэлт. Хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчилдаг байдал | | **Хангалттай сайн** |

**6.8 Дүгнэлт**

Магистрын хөтөлбөрийн "Шалгуур 6 - Удирдлага ба мэдээллийн систем"-ийн хүрээнд ҮБТДС нь үр дүнтэй удирдлага, дэвшилтэт мэдээллийн системийн шийдлүүдийг ашиглаж байгаа нь хөтөлбөрийн чанарыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Гэсэн хэдий ч цахим сургалтын хүртээмж, хүний нөөцийн ур чадвар, мэдээллийн аюулгүй байдал зэрэг зарим асуудалд анхаарах шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийг хангахын тулд дэвшилтэт технологи, хүний нөөцийн хөгжлийг уялдуулан хөтөлбөрийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр тасралтгүй ажиллах хэрэгтэй.

## ШАЛГУУР 7. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

### 7.1 Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

*Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт, төгсөлт, төгсөгчийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц үйл явцад бүх тал оролцдог байна.*

“Монгол Улсын нийт ард иргэдийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт, спортын амжилтыг эрхэмлэн, төгсөгчдөд ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудын сэтгэл ханамжийг дээдэлсэн биеийн тамир, спортын боловсролын үйлчилгээг үзүүлж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулдаг,

өөрчлөлт шинэчлэлтийг түгээгч Их Сургууль болно” гэж шинэчлэн тодорхойлж, Эрдмийн Зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 5-ны 08 тоот тогтоолоор баталгаажуулан хэрэгжүүлж байна. Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн стратеги төлөвлөгөөнд чанарын хяналт, дотоод баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлж, тогтвортой сайжруулалтыг ханган хэмээн заасны дагуу ажилладаг.

**Чанарын баталгаажуулалтын албаны он цагийн хэлхээс:**

| 2016 он хүртэл | 2016 оны 10-р сарын 10 | 2017 оны 05-р сарын 05 | 2018 оны 12-р сарын 25 | 2024 оны 03-р сарын 11 |
|---|---|---|---|---|
| Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт болох "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг үндэслэн ҮБТДС-ийн "Дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын алба"-ны ажиллах журмыг боловсруулан баталж, түүнийг үндсэн удирдлага болгон ажиллаж байсан | “Дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын алба”-ны ажиллах журмыг -нд ҮБТДС-ийн захирлаар батлуулж үндсэн удирдлага болгож байв. (“Албан хөтөч” 60-64-р хуудас) | уг албаны нэрийг БМИҮЗ-ийн зөвлөмжийн дагуу нэрийг нь өөрчилж “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” болгож ажиллах журмыг батлаж одоог хүртэл мөрдөн ажиллаж байна. | ҮБТДС-ийн захирлын 44 тоот тушаалаар “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” –ны. бүрэлдэхүүн болон ажлын төлөвлөгөөг шинэчлэн батлав | ҮБТДС-ийн захирлын 25 тоот тушаалаар “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” –ны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. |

Сургуулийн ерөнхий төсөв төлөвлөгөөнд чанарын баталгаажуулалтын албаны тухайн хичээлийн жилд гарах зардлыг тусгаж нөөц боломжоор ханган ажилладаг. Манай сургуулийн хувьд 2021, 2023 онд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлөөс гаргасан "Боловсролын чанарын баталгаажуулалт", "Чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн тайлбар толь", Ирээдүй нь хөдөлмөр эрхлэлт, боловсролын бодлогын уялдаа гэх номуудыг гарын авлага болгон ашиглаж байна.




Сургуулийн “Чанарын дотоод баталгаажуулалтын алба”-ны тогтолцоо нь сургуулийн дотоод нэгжүүд болон багш ажилтнуудын бие даасан байдал, эрх чөлөөгөө ханган ажиллахад дэмжлэг үзүүлж улмаар хамт олны үйл ажиллагааны

чанарын баталгааг хангах бодлого баримтлан чанарын удирдлагын тогтолцоог хянаж дүгнэн бүрэн ажилладаг.

Хүснэгт 7.1 Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний матриц

| Үнэлэх хэсэг | Үнэлэх чиглэл | Үнэлэх зүйл | Үнэлэх шалгуур | Хэн хариуцах | Хэзээ үнэлэх |
|---|---|---|---|---|---|
| Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт | Хөтөлбөрийн үзэл баримтлал | Сургалтын хөтөлбөр | Журам 3.1,3.3 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | 3 жил тутамд |
| | Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүн | Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүн | Журам 3.1 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | 3 жил тутамд |
| | Сургалтын төлөвлөгөө | Сургалтын төлөвлөгөө-ний матриц | Журам 2.1, 3.1 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | Жилд 1 удаа |
| | Хичээлийн стандарт хөтөлбөр | Хичээлийн стандарт хөтөлбөр | Журам 2.1, 3.2 дагуу үнэлэх | Тэнхим, хөтөлбөрийн хороо, захирал | Жилд 1 удаа |
| Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт | Суралцахуйн үр дүнгийн үнэлгээ | Төгсөх ангийн оюутнуудаас | Төгсөлт-ийн шалгалт-ын дүн, дипломын дүн | Шалгалтын комисс, сургалтын алба | Хавар төгсөх үед |
| | Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа | Оюутан, багш, ажилтнууд | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд 1 удаа |
| | Хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ | Төгсөгчид, ажил олгогчоос | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд 1 удаа |
| | Хичээлийн хөтөлбөрийн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа | Хичээлийг судалсан оюутнуудаас | Цахим болон цаасаар | Сургалтын алба, ЧДБАлба | Жилд 1 удаа |
| | Хичээлийн үнэлгээ | Багш нарын явцын үнэлгээгээр | Ирц, явц, бие даалтын үнэлгээний хуудас | Тэнхимийн эрхлэгч, сургалтын алба | Улирал бүр |

***Сургалтын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, үр нөлөө***

- **Хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэх**

"Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэхдээ нэгдүгээрт тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнгийн хамаарлын матрицыг гаргасан байна. Мөн тодорхой ажил олгогч, хөтөлбөрт оролцогчдын саналыг судална.

- **Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх**

ҮБТДС нь хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ хяналт шинжилгээ хийж, тэнхимийн үйл ажиллагааг хөтөлбөрийн хэрэгжилттэй холбон үнэлгээ өгсөн. Нийт хичээлийн хөтөлбөр тус бүрээр багш нар өөрийн үнэлгээний тайлан бичиж, чанарын баталгаажуулалтад бэлтгэсэн. Мөн тасралтгүй байх зарчмаар хөтөлбөрт оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг авч хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж байна.

- **Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх**

Хөтөлбөрийн нэр хүндийн үзүүлэлт нь элсэгчдийн тоо, шилжилт хөдөлгөөний шалтгаан, гадаад оюутны тоо, мэргэжлийн уралдаан тэмцээний амжилт, ажлын байрны эрэлт зэргээр тодорхойлогдоно. Хөтөлбөрийн суралцахуйн болон хичээлийн үр дүнг үнэлэх үнэлгээний даалгаврыг хичээл бүрээр боловсруулж, тохирлыг удаа дараа хянаж сайжруулсан. Үнэлгээний даалгавраар магистрын ажил хамгаалалт хийж байна.

Чанарын дотоод баталгаажуулалтын албанаас хичээлийн үр дүн, багшийн заах арга, ур чадвар, харилцаа хандлагын талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг улирал тутамд авч, үр дүнг нэгтгэж хичээлийн чанарыг сайжруулахад анхаарч ирсэн. Мөн хөтөлбөр хэрэгжих үйл ажиллагааг зохион байгуулагч сургуулийн захиргаа, хөтөлбөрийн алба, сургалтын албаны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Магистрын ажил хамгаалалтаас үндэслэж мэргэжлийн удирдагч нараас судалгаа авч боловсруулалт хийсэн. Энэ судалгаанд ҮБТДС-ийн 8 багш, удирдагч 5 эрдэмтэн багш хамрагдсан. Тэд магистрын хөтөлбөрийн хэрэгжилтийг ерөнхийдөө сайн гэж үнэлсэн.

2015 оноос өмнө багцын хөтөлбөрүүд хэрэгжиж эхлэхээс өмнө тухайн нэг багш өөрийн заадаг хичээлийн хөтөлбөрөө боловсруулан, тэнхимийн эрхлэгчээр батлуулан хэрэгжүүлдэг байсан бол хөтөлбөрт дотоод чанарын баталгаажуулалт хийх бодлогын чиг хүрээнд дараах байдлаар шинэчлэн өөрчилсөн болно. Үүнд:

1. Багш нар тухайн хичээлийн стандарт хөтөлбөрөө боловсруулах
2. Тэнхимийн бүх багш нарын хурлаар хэлэлцүүлэх /хөтөлбөрийн дэд хороо засаж сайжруулах/
3. Сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн эцэслэн батлуулах

Ингэснээр тухайн нэг багшийн зааж буй хичээлийн агуулга хөтөлбөрт бусад багш нар санал, зөвлөмж өгөх, багшийн шийдвэр гаргах, хичээл хоорондын уялдаа холбоо сайжрах зэргээр багш нарын бүтээлч байдал нэмэгдэх, хамгийн гол нь хөтөлбөрт сайжруулалт хийхэд дөхөм болж байна.




*Зураг 7.1 Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтад оролцох талуудын схем*

Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад оролцогч талууд нь сургуулийн захиргаа, хөтөлбөрийн хороо, чанарын баталгаажуулалтын алба, багш, оюутан, төгсөгч, ажил олгогч, бусад гэсэн талуудаас бүрдэнэ. Энэ нь бүх талуудын оролцоо санал хүсэлтээр сургалтын хөтөлбөрийг үнэлж дүгнэх сайжруулах арга юм.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ оролцогч болон сонирхогч талуудын оролцоог дэмжих зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтарч ажилладаг.

### 7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

*Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.*

Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль 2023 онд Биеийн тамирын багш”, “спортын дасгалжуулагч” “биеийн тамирын арга зүйч” мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн нь магистрын сургалтын хөтөлбөрийг сайжруулах, магадлан итгэмжлүүлэхэд нөлөөлж байна. Мөн бидэнд өмнөх туршлагаасаа суралцах боломжийг олгож байгаагаараа давуу талтай байна. Иймээс “Биеийн тамирын боловсрол” магистрын сургалтын хөтөлбөрийг магадлуулах хүсэлтийг Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлд хүргүүлж байна. Тус магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлснээр хөтөлбөрт оролцогч гадаад, дотоодын талуудын тоо нэмэгдэх, хөтөлбөрөөр төгсөгчид мэргэжлийн салбар, ажлын байран дээр хүлээн зөвшөөрөгдөх, хөтөлбөрийн сайжруулалт тасралтгүй хийгдэж чанар, үр дүн дээшилнэ.

“Биеийн тамирын боловсрол” магистрын хөтөлбөрөөр төгсөгчид мэргэжлийн салбар, ажлын байран дээр хүлээн зөвшөөрөгдсөнийг нотлох баримт материалыг магистрт элссэн болон төгсөгчдийн тоо, ажлын карьерын өсөлтөөр харуулж байна.

2020-2021 оны хичээлийн жилд оюутны тоо буурч 18 оюутан элссэн нь тухайн жилд цар тахлын хөл хорио гарсантай холбоотой байсан. 2021-2022 –с эхлэн “Бриж монголиа групп”-тэй хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна БНХАУ-с оюутан элсүүлдэг болов. Энэ групп-с хятад оюутнуудад зориулж монгол хэлний сургалт явуулдаг буюу орчуулагчаар хангадаг.

Ажил олгогчдын зүгээс бодлогоор магистрантурт суралцуулах захиалга одоогоор ирээгүй байна. Зөвхөн манай сургууль өөрийн сургуульдаа багшаар авах боломжтой гэж үзсэн, спортын тодорхой төрлийн өндөр зэрэг цолтой, цаашид судалгаа шинжилгээний ажил хийх сонирхол, чадвартай бакалаврын төгсөгчийг магистрантурт элсэн суралцахыг санал болгож ирсэн. Ингээд магистрын зэргээ хамгаалсны дараа Биеийн тамирын сургуульд багш шалгаруулж авах журмын дагуу шалгалтад оруулж, сургуульдаа багшаар ажиллуулж буй хэд хэдэн багш байна.

***Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж, өөрийн үнэлгээ хийдэг байдал***

Хүснэгт 7.2 Хөтөлбөрийн оролцогч талуудаас авдаг сэтгэл ханамжийн судалгаа

| № | Хэнээс | Судалгааны агуулга | Судалгаа авах хэлбэр | Судалгаа авах давтамж |
|---|---|---|---|---|
| 1 | Багш | Сургалтын хөтөлбөр | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| | | Хичээлийн орчин | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| | | Эрдэм шинжилгээ | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| | | Хүний нөөцийн асуудал | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| 2 | Магистрант | Сургалтын хөтөлбөр | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| | | Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| | | Багшийн хандлага, ёс зүй | Цахимаар болон цаасаар | Жил бүр |
| 3 | Сонирхогч талууд /ажил олгогч г.м/ | Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт | Цахимаар болон цаасаар | Жил бүр |




*Зураг 7.2 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа*

Хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлт нь хөтөлбөрийн үр дүнгийн бас нэг гол үзүүлэлт юм. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг тодруулах 9 асуулт бүхий судалгааг утсаар болон цахим хуудас, чатаар авлаа. Судалгаанд нийт 60 магистрант хамрагдаж хариулт өгсөн болно.

2022-2023 оны 20 төгсөгчөөс ажил эрхлэлтийн судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзвэл нийт төгсөгчийн 79.87% мэргэжлийн дагуу ажил эрхэлж байгаа, 51,17% төгсөөд 6 сарын дотор ажилд орсон, 64.16% 12 сарын дотор ажилд орсон байна. Мөн 10.88% мэргэжлийн бус ажил эрхэлж, 2.97% ажил эрхлээгүй, 2.99% ахисан түвшинд суралцаж, өөр чиглэлийн бакалаврт суралцаж байгаа төгсөгч байхгүй байна.

2023-2024 оны 20 төгсөгчөөс ажил эрхлэлтийн судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзвэл нийт төгсөгчийн 80.48% мэргэжлийн дагуу ажил эрхэлж байгаа, 48.07% 6 сарын дотор ажилд орсон, 56.54% 12 сарын дотор ажилд орсон байна. Мөн 12.19% мэргэжлийн бус ажил эрхэлж, 4.56% ажил эрхлээгүй, 2.60% ахисан түвшинд суралцаж, өөр чиглэлийн бакалаврт 1.30% суралцаж байна.

### *Ажил олгогчоос авсан судалгаа*

Энэхүү судалгааг ерөнхий боловсролын 9 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 1 цэцэрлэгээс асуулгын аргаар авсан. Судалгаанд оролцогч тал буюу ажил олгогч нь уг хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдийг дараах байдлаар үнэлсэн байна.




*Зураг 7.3 Ажил олгогчдоос өгсөн төгсөгчдийн үнэлгээ*

Цаашид уг хөтөлбөрөөр төгсөгчдөд тулгарч буй бэрхшээл арга зам, тэднийг төгсөлтийн дараах давтан сургалтад хамруулах, ЕБС-ийн хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийн талаар сургалт семинар, харилцан туршлага солилцох уулзалт хийхээр төлөвлөж байна.

***Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх***

"Биеийн тамирын боловсрол" магистрын хөтөлбөрийг хөтөлбөрийн дэд хороо, /тэнхим/, хөтөлбөрийн хорооноос өгсөн “хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын удирдамж загвар”-ын дагуу боловсруулан, хянуулан хэлэлцүүлж сайжруулсны үндсэн дээр хөтөлбөрийн хороонд өгч үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээ хийх үйл ажиллагааг 2023 оны 9 сараас 2024 оны 05 сар хүртэлх хугацаанд гүйцэтгэв. УБТДС-ийн хөтөлбөрийн хорооноос тус хөтөлбөрт үнэлгээ хийх багш шинжээчдийг томилон ажиллуулав. Ингэхдээ дараах холбогдох баримт бичиг, удирдамж, зааврын дагуу үнэлгээ хийх чиглэлийг өгсөн болно.

## 7.3 Шалгуур 7 SWOT, TOWS шинжилгээ

| **Давуу тал (Strength)** | **Сул тал (Weakness)** |
|---|---|
| • УБТДС нь 33 жилийн туршлагатай, Монгол улсын анхны ууган хувийн хэвшлийн дээд сургууль юм. Жил ирэх бүр материаллаг баазаа нэмэгдүүлж, багшлах боловсон хүчнээ зузаатгаж ирсэн.<br>• Биеийн тамирын боловсрол мэргэжил нь даяарчлагдаж буй эрин зуунд хамгийн эрэлт хэрэгцээтэй, хүний биеийн болон сэтгэлийн эрүүл мэндэд онцгой ач холбогдолтой мэргэжил юм.<br>• Уг мэргэжлийн хөтөлбөрт сайжруулалт, боловсруулалт хийж үр дүнг үнэлэхийн сацуу сүүлийн жилүүдэд чанарын дотоод | • Төгсөгчдийг давтан сургалтад хамруулж ур чадварыг нэмэгдүүлэх, тасралтгүй суралцах зарчимд суралцуулах шаардлагатай гэж харж байна.<br>• Багш мэргэжилтний цалин, хөдөлмөрийн хөлс доогуур үнэлэгдэж байна гэж харж байна.<br>• Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа тогтмолжуулах, бодит үр дүнг эрэлхийлэх шаардлагатай |

| | |
|---|---|
| баталгаажуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх гэж хичээн ажиллаж байна.<br>• Энэхүү чанарын баталгаажуулалтад оролцогч талуудыг сайн хамруулах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. | |
| **Боломж (Oppotiunities)** | **Эрсдэл (Threats)** |
| • Ярмаг, нисэх, төв аймаг зэрэг бүсийн элсэгчдийг өргөнөөр хамруулах<br>• Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг тогтмолжуулснаар хөтөлбөрийн чанарыг сайжруулах<br>• Олон жилийн туршлага, түүх, чадварлаг багш нар дээрээ үндэслэж сайн боловсон хүчнийг нийгэмд гаргах зэрэг боломж харагдаж байна. | • Сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ шаардлага өндөр болж байгаа<br>• Ажлын байр дээрх хөдөлмөрийн хөлс хангалтгүй. Иймээс төгсөгч мэргэжлийн бус ажил хийх хандлагатай |

### 7.4 Сайжруулах арга зам

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг тогтмолжуулах, хөтөлбөрийн сайжруулалтыг цаг тухай бүрд хийдэг болох
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтад тэнхим, багш нарын оролцоог нэмэгдүүлэх
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол авах, үнэн бодит үр дүнг харуулах
- Хөтөлбөрөөр суралцаад амжилттай төгссөн боловч ажлын байраар хангагдаж чадаагүй оюутнуудын шалтгааныг илрүүлэх, арга хэмжээ боловсруулах
- Дотоодын болон гадаадын спортын шинжлэх ухааны мэргэжлийн сургуулиудын хөтөлбөрийг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Үндэсний болон олон улсын тэргүүлэх эрдэмтэн, судлаачдын санал зөвлөгөөг тусгах, хамтран ажиллах, туршлага солилцох.

### 7.5 Үнэлгээ

Хүснэгт 7.3 Чанарын баталгаажуулалтад хийсэн өөрийн үнэлгээ

| Шалгуур | **Үзүүлэлт** | **Хэмжээс** | **Өөрийн үнэлгээ** |
|---|---|---|---|
| 7.1 | Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт | **Хангалттай сайн:** Өгсөн үзүүлэлтийг хангах тэнхимийн санаачилгаар үйл ажиллагааг тогтмол явуулдаг | **Хангалттай сайн** |

| | | | |
|---|---|---|---|
| | Сургалтын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, үр нөлөө | **Хангалттай:** Өгөгдсөн үзүүлэлт бүрийг бүрэн хангасан<br>**Сайжруулах шаардлагатай:** Нэг үзүүлэлтийг хангасан<br>**Хангалтгүй:** Тухайн шалгуурын дагуу үйл ажиллагаа хэрэгжээгүй | |
| 7.2 | Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл | | **Хангалттай сайн** |

Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын эрх зүйн үндэс бүрдсэн, амжилттай шат дараатай сайжирч хэрэгжиж байгаа гэж үзэж байгаа тул "Биеийн тамирын боловсрол" хөтөлбөрийн чанарын үнэлгээ, баталгаажуулалт хэсгийн өөрийн үнэлгээний тайлан нь дээд сургуулийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангаж байна гэж үзлээ.

**7.6 Дүгнэлт**

Биеийн тамирын боловсрол магистрын хөтөлбөрийн “Чанарын баталгаажуулалт”-ын өөрийн үнэлгээнд суурилан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Магистрын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо бүрдэж, уг хөтөлбөрөөр суралцагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг ҮБТДС-аас барьж байгаа бодлого, чиглэл, сургалтын журамд нийцүүлэн ажиллаж байна.
2. Цаашид энэхүү хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах үйл ажиллагаанд бүх талын оролцогчдыг хамруулах, тэдний оролцоог дэмжих, хамтран ажиллахад анхаарах хэрэгтэй.